

**Монгол Улсад орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулав.**

---

**Судалгааны захиалагч:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

**Ажлын хэсгийн ахлагч:**

А.Намсаманд

ШШГЕГ-ын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, хурандаа

**Нарийн бичгийн дарга:**

Б.Алтангэрэл

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

**Гишүүд:**

М.Хүрэлбат

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

## Агуулга

Өмнөх үг	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Нэр томъёоны тайлбар	5-6
Зураг, хүснэгтийн жагсаалт	7-9
Удиртгал	10-16
Нэгдүгээр бүлэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ	
1.1. Монгол Улсад хуулийн этгээдээс төлбөр гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал	17-45
1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт	46-75
Хоёрдугаар бүлэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй байдалд хийсэн шинжилгээ	
2.1. Шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааныг шийдвэрлэж буй байдал	76-89
2.2. Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны хэрэгжилт	90-137
2.3. Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй байдал, шийдвэрлэх арга зам	138-141
Гуравдугаар бүлэг. Гадаадын зарим оронд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын онцлог	
3.1. ОХУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог	142-154
3.2. БНХАУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог	155-175
3.3. ХБНГУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог	176-185
3.4. БНСУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог	186-190
Дүгнэлт	191-192
Санал-зөвлөмж	192-193
Эх сурвалжийн жагсаалт	194
Хавсралт	195-197

## Өмнөх үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн нэг болох иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад өнөөгийн байдлаар нь эрх зүйн зохицуулалтын болоод практик хэрэгжилтийн хувьд хүндрэлтэй асуудлууд байсаар байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд 1996 онд 25.6 тэрбум төгрөгний өр төлбөр барагдуулж байсан бол 2019 онд 1 их наяд 900 гаруй сая төгрөг буюу 74 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь иргэн, хуулийн этгээд хоорондын бизнесийн болон зээлийн харилцаа асар хурдацтай хөгжиж буйтай шууд холбогдож байдаг.

Шийдвэр гүйцэтгэх албаны зүгээс мэргэжлийн судлаачидтай хамтран шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хавсрага судалгааны ажлыг тогтмол хийж ирсэн бөгөөд 2020 онд ДХИС-ийн судалгааны багтай хамтарсан бүтээл болох "Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт" судалгааны тайлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оны "Шилдэг бүтээл"-ээр шалгарсан явдал бидэнд ихээхэн урам зориг өгсөн билээ.

Энэ удаа бид Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачдтай хамтран төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, улмаар тулгамдсан асуудлыг судалгаа-шинжилгээний үндсэн дээр нээн илрүүлж, шийдвэрлэхтэй холбоотой санал, зөвлөмж боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагад танилцуулах хүрээнд энэхүү судалгааны тайланг боловсрууллаа.

Энэхүү судалгааны тайланг зөвхөн иргэний шийдвэр гүйцэтгэгч нарт зориулагдсан бус хуулийн их дээд сургуулийн оюутан, суралцагч, судлаач, сонирхогч хэн бүхний таалалд нийцсэн бүтээл болсон байх гэдэгт гүнээ итгэж байна.

Хүндэтгэсэн:

ШШГЕГ-ын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга,

Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, хурандаа

А.Намсаманд

### Товчилсон үгийн жагсаалт:

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЗХШТХ	Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
УДШ	Улсын Дээд Шүүх
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

## Нэр томъёоны тайлбар

(Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд хамаарах зарим нэр томъёог тайлбарлав.)

	Арилжааны банк
	хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх зорилготой ашгийн төлөө, бусдын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага
	Барьцаа
	үүргийн гүйцэтгэлийг хангуулах, баталгаажуулах зорилгоор үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчээс авч буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хөрөнгийн эрх
	Орлого
	бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас тухайн хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгал, өр төлбөрийн барагдуулалт
	Валют
	Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ.
	Вексель
	төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргалдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримт
	Гомдол
	төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт
	Гэрээ
	хоёр буюу түүнээс дээш талууд ямар нэгэн зүйл хийх, эсхүл хийхгүй байх талаар тохиролцсон хуулийн хувьд хүчин төгөлдөр хэлэлцээр
	Хэлцэл
	иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/
	Зардал
	бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдаж байгаа хөрөнгө ба зарцуулалтыг мөнгөөр илэрхийлсэн хэмжээ
	Зөрчил
	хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүй
	Ипотек
	үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа

	Итгэмжлэл
өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээдэд бичгээр тодорхойлсныг	
	Клиринг
төлбөр тооцоо хийхээс өмнө мөнгөн хөрөнгийн, эсхүл үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг дамжуулах, тохируулах, баталгаажуулах үйл явц бөгөөд үүнд шилжүүлгийн үр дүнгийн тооцоолол, төлбөр тооцооны эцсийн дүнг тодорхойлох ажиллагаа	
	Ногдол ашиг
ногдол ашиг гэдэг нь хувьцаа эзэмшигч нарт тарааж өгдөг компанийн орлогын тодорхой хувь	
	Тодорхойлолт
үйл явдал, бодит байдлын үнэн зөвийг нотлох зорилгоор холбогдох шийдвэр, мэдээ баримтад үндэслэн гаргасан баримт бичиг	
	Төлбөр авагч
эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээд	
	Төлбөр төлөгч
төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээд	
	Хэрэг гүйцэтгэгч
хариуцагчийг татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэгч, дахин хөрөнгөжүүлэх ажиллагаанд хяналт тавих, хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах эрхтэйгээр нэхэмжлэгчдийн хурлаас санал болгосноор шүүхийн томилсон этгээд	
	Хуулийн этгээд
өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл	
	Хувьцаа
компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг	
	Компани
Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг	

## Зураг, хүснэгтийн жагсаалт

Зураг 1.	Улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо /хуулийн этгээдийн төрөл, оноор/
Зураг 2.	Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн, татан буугдаж, хасагдсан хуулийн этгээд
Зураг 3.	2016 онд шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал
Зураг 4.	2016 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл
Зураг 5.	Иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн байдал
Зураг 6.	2017 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл
Зураг 7.	2018 онд шүүхээс шийдвэрлэсэн иргэний хэрэг, маргаан
Зураг 8.	2018 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл
Зураг 9.	2019 онд Шүүхээс иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн байдал
Зураг 10.	2019 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл
Зураг 11.	2020 онд Шүүхээс иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэсэн байдал
Зураг 12.	2020 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл
Зураг 13.	2016-2020 оны хооронд иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан
Зураг 14.	2016-2020 оны хооронд иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан
Зураг 15.	2016-2020 оны хооронд хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан
Зураг 16.	Архангай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 17.	Архангай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 18.	Баян-Өлгий хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 19.	Баян-Өлгий аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 20.	Баянхонгор аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 21.	Баянхонгор аймгийн аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 22.	Булган аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 23.	Булган аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 24.	Говь-Алтай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 25.	Говь-Алтай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 26.	Говьсүмбэр аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 27.	Говьсүмбэр аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 28.	Дархан-Уул аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/

Зураг 29.	Дархан-Уул аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 30.	Дорнод аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 31.	Дорнод аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 32.	Дорноговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 33.	Дорноговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 34.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 35.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 36.	Дундговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 37.	Дундговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 38.	Завхан аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 39.	Завхан аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 40.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 41.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 42.	Орхон аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 43.	Орхон аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 44.	Өвөрхангай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 45.	Өвөрхангай аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 46.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 47.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 48.	Өмнөговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 49.	Өмнөговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 50.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 51.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 52.	Сүхбаатар аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 53.	Сүхбаатар аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 54.	Сэлэнгэ аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/



Зураг 55.	Сэлэнгэ аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 56.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 57.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 58.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 59.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 60.	Увс аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 61.	Увс аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 62.	Төв аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 63.	Төв аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 64.	Ховд аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 65.	Ховд аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 66.	Хөвсгөл аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/
Зураг 67.	Хөвсгөл аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 68.	Хэнтий аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021
Зураг 69.	Хэнтий аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/
Зураг 70.	Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 71.	Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 72.	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 73.	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 74.	Налайх дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 75.	Налайх дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 76.	Багануур дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 77.	Багануур дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 78.	Улсын хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо
Зураг 79.	Улсын хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн
Зураг 80.	Шийдвэр гүйцэтгэгчдээс хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 81.	Шийдвэр гүйцэтгэгчдээс хуулийн зохицуулалтыг өөрчлөхөд хамаарах асуудлын талаарх судалгааны дүн
Хүснэгт 1.	Улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо /хуулийн этгээдийн төрөл, оноор/
Хүснэгт 2.	Хуулийн этгээдийн бүртгэлийн сүүлийн 3 жилийн статистик

## Удиртгал

Монгол Улс 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, эдийн засаг, нийгмийн харилцаанд олон шинэ хэлбэр бий болж, тэдгээрийг зохицуулах эрх зүйн өөрчлөлтийг харьцангуй богино хугацаанд хийх шаардлагатай болсон. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн талаар гаргасан анхны шийдвэр нь 1991 оны нэгдүгээр сарын 15-нд гаргасан Засгийн газрын "Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 20 дугаар тогтоол юм. Уг тогтоолд:

1. Нефть бүтээгдэхүүний үнийг дунджаар 95 хувь, технологийн хэрэгцээнд нийлүүлэх нүүрсний үнийг 75 хувь, цахилгаан эрчим хүчний үнийг 94 хувь, хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг 20-280 хувиар нэмэгдүүлэн, аж үйлдвэрийн зарим барааны үнийг 7-70 хүртэл нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд цаашид 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тарифыг улсаас тогтоож байхаар жагсаалтыг баталсан.

2. Бүх төрлийн барааны жижиглэн худалдаалах үнэ, үйлчилгээний тарифыг хоёр дахин, мөн улсын байгууллагад ажиллагчдын цалин хөлс, тэтгэвэр, оюутны тэтгэлгийг хоёр дахин нэмэгдүүлсэн.

3. Үйлдвэр, аж ахуйн газар, иргэдээс төсөвт төлөх татвар, хураамжийн хэмжээг мөн 2 дахин өсгөхөөр тус тус тогтоосон байна.

Уг тогтоолын гол зорилго нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн болон улсын төсвийг алдагдлыг бууруулах, мөнгө, зээл, санхүүгийн механизмыг боловсронгуй болгох, үнэ, цалин хөлсний уялдааг сайжруулж зах зээлийн зохистой тэнцвэрийг хангах гэж тэмдэглэгджээ. Гэтэл энэ тогтоол гарснаар үйлдвэрлэлийн зардалд зонхилох нөлөөтэй бензин, түлшний болон нүүрс, цахилгааны үнэ хоёр дахин нэмэгдсэний дээр нийт улс орны хэмжээнд цалин хөлс, үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг ихээхэн нэмэгдүүлж, улмаар мөнгөний ханшийг хоёр дахин бууруулсан шийдвэр болсон бөгөөд инфляци 1993 онд 325.5 хувь хүртэл өссөн билээ.

Манай орны эдийн засаг 1980-аад оны сүүлчээс эхлэн зогсонги байдалд орсон бөгөөд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилт эхлэнгүүт уналтад орсон нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол үүсэж, хэрэглээний бүтээгдэхүүний үнэ огцом өсөх нэг нөхцөл болжээ. Шилжилтийн эхний жилүүдэд эдийн засгийн уналтыг тогтворжуулахын зэрэгцээ шинэ тогтолцоонд шилжихэд шаардлагатай дараах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг цаг алдалгүй авах хэрэгцээ шаардлага үүсэж

байлаа. Үүнд:

1. Нэн тэргүүн ээлжинд бараа, бүтээгдэхүүний үнийг чөлөөлж, зах зээлийн зарчмаар үнэ тогтох нөхцөлийг бүрдүүлэх, ханшийн уян хатан тогтолцоог бий болгох;

2. Улсын өмчийг хувьчилж, хувийн өмчийг бүртгэх, худалдан борлуулах;

3. Хоёр шатлалт банкны тогтолцоог хөгжүүлж, хувийн хэвшлийн санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох;

4. Гадаад худалдааны нээлттэй бодлого хэрэгжүүлэх;

5. Татварын тогтолцоог бүрдүүлэх зэрэг бүтцийн өөрчлөлтийн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгохын зэрэгцээ тэдгээрийг нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлж, хэрэгжүүлэх замаар эдийн засгийн шинэ тогтолцооны үндэс суурь тавигдаж байлаа.

Шилжилтийн үеийн эхний жилүүд болох 1991-1992 онд улсын үйлдвэрийн газруудын санхүүжилтийн болон борлуулалтын тогтолцоо задарч, цалин тавьж чадахгүй, шаардлагатай санхүүжилт авах боломжгүй болж, хэвийн үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй болсон юм. Үүний зэрэгцээ өмч хувьчлалтай холбоотойгоор цаашдын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхой бус байдал ихэссэн байна. Иймээс улсын үйлдвэрийн ихэнх газрууд ажилчдаа цөөлөх, халах, үйл ажиллагаагаа хүмийх эсвэл зогсоох зэрэг арга хэмжээг авч эхэлсэн нь эдийн засаг 1990-1992 онд огцом уналтад орох нөхцөл болсон. Эдийн засгийн уналтыг даган бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан үед төгрөгийн нийлүүлэлт огцом нэмэгдсэн нь 1990-1992 онд инфляци гурван оронтой тоогоор хэмжигдэхэд нөлөөлсөн. Ийнхүү гипер инфляцид өртсөн иргэдийн инфляцийн хүлээлт тодорхой хугацаанд буурахгүй байснаас 1996 оныг хүртэл инфляци 50 хувиас дээш хадгалагдаж, иргэд мөнгөө бэлнээр хадгалах, төлбөр тооцоогоо бэлнээр хийх сонирхлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ажээ.

Социализмын үед улсын банк улсын үйлдвэрийн газарт зээл олгохдоо эргэн төлөгдөх эрсдэлийг бус зөвхөн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг гол шалгуур болгон олгодог байсан бөгөөд борлуулалтын тогтолцоо нь улсын нэгдсэн системтэй байсан учраас эргэн төлөлтийг борлуулалтын системээс нь шууд авах боломжтой байжээ. Зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр эдгээр харилцаа цоо шинэ зарчим, хэлбэрээр зохион байгуулагдах болсон бөгөөд энэ талаарх ойлголт бүхий л түвшинд бараг байхгүй байснаас зарим буруу хандлага гарах тохиолдол цөөнгүй байжээ. Тухайлбал, шинээр байгуулагдсан банкууд хуучин тогтолцооны

жишгээр иргэн, аж ахуйн газарт ямар нэгэн судалгаагүй их хэмжээний зээл олгох, банк хоорондын их хэмжээтэй хуурамч нэхэмжлэл бичиж, зээл богино хугацаанд авах, банкинд ажилладаг хүмүүс илүү мэдээлэлтэй байснаас өөрийн танил талдаа зээл олгох зэргээр гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээг нэмэгдүүлж байв.

Санхүүгийн зуучлал 2000 оныг хүртэл буурч байсныг мөнгө, зээлийн үзүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь буурч, өсөхгүй байснаас харж болно. Энэ нь шилжилтийн эхэн үед хувийн өмчийн эрх зүйн зохицуулалт бий болсны дараа иргэн, аж ахуйн газрууд бизнесээ явуулах санхүүжилтийн эх үүсвэрийг банкнаас авах, харин дөнгөж үүсч бий болсон банкууд зээлийн эргэн төлөгдөх эрсдэлийг тооцон зээл олгох шинэ харилцааг хөгжүүлэх, зохицуулах, хянах зэрэг үйл ажиллагаа жигдрэх буюу хэвийн түвшинд явагдах нөхцөл бүрдэхэд барагцаагаар 10 орчим жил зарцуулсныг илэрхийлж байна. Нөгөө талаас тухайн үед иргэд, бизнес эрхлэгчид мөнгөө банкинд хадгалуулахаас илүүтэйгээр бэлнээр зарцуулж, хадгалж байсныг гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ өндөр, улмаар энэ нь эргээд инфляцийг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлж байлаа. 2000 оноос эхлэн харьцаа үзүүлэлт бүгд сайжрах хандлага ажиглагдсан буюу банк, санхүүгийн салбарын хөгжилд ахиц дэвшил гарч, тэр чинээгээр иргэд, бизнес эрхлэгчдийн банк, санхүүгийн салбарт итгэх итгэлийг бага багаар нэмэгдүүлж чадсан байна.

Шилжилтийн үед эдийн засгийн хямрал, тогтворгүй байдал бий болоход дотоод хүчин зүйлээс гадна социалист системийн орнуудын хамтын ажиллагааны “Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл” үйл ажиллагаагаа зогсоож, гадаад эдийн засгийн орчин огцом өөрчлөгдөж, гадаад худалдааны борлуулалтын зах зээлийн тогтолцоо задарч, эдийн засгийн санхүүжилтийн гол эх үүсвэр зогсож, зээл тусламжийн хэмжээ эрс багассан зэрэг хүчин зүйл томоохон нөлөө үзүүлсэн юм<sup>1</sup>.

Иргэний эрх зүйн харилцаанд иргэдээс гадна аливаа байгууллага өөрийн нэрээр оролцон эрх эдэлж, үүрэг хүлээж байдаг. Эдгээр байгууллага нь хуульд заасны дагуу байгуулагдаж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хуулиар тогтоосон журмын дагуу татан буугдах тул “хуулийн этгээд” гэж нэрлэдэг. Товчоор хэлбэл үйл ажиллагаа нь хуулиар зохицуулагддаг гэсэн үг.

---

<sup>1</sup> “Монгол Улсад хэрэгжсэн мөнгөний бодлого: 100 жилийн түүхэн сургамж” судалгааны ажил. Н.Баяртсайхан. 2018 он.

Өнөөдөр Монгол Улсад 94,491 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд эдгээрийн 77,5% нь компани, 2,5% нь хоршоо, 2,6 % нь нөхөрлөл, 0,4% нь ТӨҮГ, ОНӨҮГ, 4,9% нь төсвийн байгууллага, 11,1% төрийн байгууллага, 0,9% бусад хуулийн этгээд эзэлж байна.

Хүснэгт 1. Улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо /хуулийн этгээдийн төрөл, оноор/<sup>2</sup>

Хуулийн этгээдийн төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
компани	42421	46618	48787	54844	59848	66010	72492	73253
Хоршоо	2072	2424	2645	2745	2881	2709	2765	2379
Нөхөрлөл	1881	1859	1887	1989	2113	2365	2528	2442
ТӨҮГ, ОНӨҮГ	261	343	334	350	381	387	393	382
Төсвийн байгууллага	3929	4081	4166	4278	4349	4463	4579	4656
Төрийн байгууллага	4180	4283	6229	7561	8578	9025	10806	10528
Бусад	191	243	261	427	447	802	862	851
<b>Нийт</b>	<b>54935</b>	<b>59851</b>	<b>64309</b>	<b>72194</b>	<b>79197</b>	<b>85761</b>	<b>94425</b>	<b>94491</b>

Зураг 1. Улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо /хуулийн этгээдийн төрөл, оноор/



<sup>2</sup> 1212.mn


2018 онд 15309, 2019 онд 15465, 2020 онд 14030 хуулийн этгээд шинээр бүртгэж, 2018 онд 752, 2019 онд 712, 2020 онд 757 хуулийн этгээд татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан байна<sup>3</sup>.

*Хүснэгт 2. Хуулийн этгээдийн бүртгэлийн сүүлийн 3 жилийн статистик*

д/д	Статистик мэдээллийн үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
<b>Улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээд</b>		<b>15309</b>	<b>15465</b>	<b>14030</b>
1	Хувьцаат компани	8	7	7
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11712	12190	11590
	Үүнээс: гадаадын хөрөнгө оруулалттай	481	216	71
3	Төрийн бус байгууллага	2476	2323	1675
4	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар		8	15
5	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлвэрийн газар		130	118
7	Нөхөрлөл	760	399	280
8	Хоршоо	67	53	64
9	Хадгаламж зээлийн хоршоо	41	30	18
10	Сан	133	165	103
11	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	91	130	116
12	Шашны байгууллага	21	29	27
13	Хэвлэл мэдээллийн байгууллага			7
14	Боловсрол, сургалтын байгууллага			9
15	Засгийн газар хоорондын байгууллага			1
<b>Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд</b>		<b>752</b>	<b>712</b>	<b>757</b>

*Зураг 2. Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн, татан буугдаж, хасагдсан хуулийн этгээд*

<sup>3</sup> УБЕГ-ын 2018-2019 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ /www.burtgel.gov.mn/



### **Судалгааны ажлын зорилго, зорилт:**

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд Шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой иргэний хэрэг, маргааныг шийдвэрлэж буй байдал, шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, улмаар практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон дүгнэлт-зөвлөмж гаргах зорилгыг өмнөө тавин ажиллалаа.

Зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1. Монгол Улсад хуулийн этгээдээс төлбөр гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалд дүн шинжилгээ хийх;
2. Шүүхээс 2016-2020 оны хооронд хуулийн этгээдтэй холбоотой иргэний хэргийг шийдвэрлэж ирсэн байдал, хэрэгжилтэд шинжилгээ хийх;
3. Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны хэрэгжилтэд шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх
4. Гадаадын зарим оронд хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй ажиллагааны онцлогыг судлах
5. Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой санал-зөвлөмж боловсруулах зэрэг болно.

### **Судалгааны ажлын арга зүй:**

Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн судалгаа нь эрдэм шинжилгээ, судалгаа-боловсруулалтын ажлын түүхчлэх, харьцуулах, бичиг баримтад дүн

шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, асуулгын болон ярилцлагыг ашиглаж боловсруулалт хийсэн болно.

Судалгааны тайланд тусгагдсан тоо баримтыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Статистикийн төв газраас авсан албан ёсны мэдээ, тайлангаас авсан.

Түүнчлэн ШШГЕГ-ын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 250 шийдвэр гүйцэтгэгчийн 188 шийдвэр гүйцэтгэгчээс буюу 75.2%-иас судалгаа авлаа.



## **Нэгдүгээр бүлэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ**

### **1.1. Монгол Улсад хуулийн этгээдээс төлбөр гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал**

Хуулийн этгээдийн талаарх ойлголтын анхны үүслийг тодруулахаар олон орны эрдэмтэд судалж ерөнхийд нь бодитчилох, дүрслэх, үгүйсгэгчид гэсэн гурван бүлэгт хувааж үзжээ. Эдгээр онолын агуулгыг авч үзвэл:

Бодитчилох онол: Хуулийн этгээдийг оюуны болоод биеийн бодит байдалд оруулан хуулийн этгээд нь харагдаж баригдах биетэй, сэтгэх, шийдэх сэтгэхүйтэй гэж үздэг бодитчилох онолыг Gierke, Zitelmann, Binder, Saleilles нар голлон төлөөлдөг.

Дүрслэх онол: Хуулийн этгээдийг зөвхөн дүрсэлсэн, төсөөлсөн үзэгдэл гэж ойлгон, түүнд психо-физикийн бодит бие байхгүй гэж үздэг дүрслэх онолын гол төлөөлөгчид нь Kierulff, Savigny, Puchta, Bierling нар юм.

Үгүйсгэгч онол: Хуулийн этгээд гэсэн үзэгдийг үгүйсгэгч онолыг Vareilles-Sommieres, Stammler, Serment, Holder болон Kelsen нарын үзэл баримтлал бүрдүүлдэг бөгөөд Windscheid-ын эзэнгүй эрхүүдийн тухай онол, Brinz-ийн зорилтот хөрөнгийн тухай онол мөн энэ бүлэгт хамаарна<sup>4</sup>.

Хуулийн этгээд өөрөө үйлдэл хийхгүй, харин удирдах буюу төлөөлөх байгууллагаараа дамжуулан үйлдэл хийх ба байгууллага нь нэг юмуу хэсэг хүнээс бүрдэж буй, хуулийн этгээдийн үйлдэл тэгэхээр түүний нэр дээр хийсэн хэн нэг хүний эсвэл хүмүүсийн үйлдэл юм.

Хуулийн этгээд нь эрх зүйн чадвараараа хүнээс ялгагдана. Хуулийн этгээд абсолют эрх зүйн чадвартай, мөн шинж чанараараа гагцхүү хүнийх байж болох эрх, үүргүүдээс бусад бүхий л эрх, үүргийг эдэлдэг. Эрх зүйн чадамжийн тухайд хуулийн этгээд нь ямагт төлөөлөгчөөр /удирдах буюу төлөөлөх байгууллагаараа/ дамжуулан үйлдэл хийж, хүн шиг эрх зүйн чадамжтай байж чадахгүй. Хуулийн этгээдийн оронд түүний нэрийн өмнөөс төлөөлөгч, төлөөллийн байгуулагууд нь үйлдэл хийх, эрх зүйн мэдэгдэл гаргах, эрхээ хэрэгжүүлэх гэх мэт шаардлагатай гэж үзжээ.

Зарим эрдэмтэн, судлаачид хуулийн этгээдийн үүсэл, хөгжлийг сүм хийд бий болсон цагаас үүсэлтэй гэж үздэг байна. Тэр үед төрөөс хуулийн

---

<sup>4</sup> Р.Батхүү. LEGIS сэтгүүл. УБ., 2002. 1 дугаар.,

этгээдийн өмчлөлд байгаа эд хөрөнгө, сүм хийдийн тэргүүн нас нөхцсөн байсан ч өв залгамжлалын асуудлыг хөндөлгүйгээр тэргүүн хэн болохоос үл хамааран шилждэг байсан. Энэ мэтээр нилээд олон янзаар сүм хийд нь хүний нийгмийн анхны байгууллагын нэг болохын хувьд одоогийн бидний ойлгодог нийгмийн харилцаанд хүнтэй адил эрх тэгш оролцохыг эрмэлзэгч хуулийн этгээдийн эхлэл байсан гэх үндэслэл бий.

Хуулийн этгээдийн талаарх үзэл баримтлал нь XIV-XVII зуунд эдийн засгийн томоохон түлхэгч хүч болсон худалдааны хөгжил, далайн аялал зэрэг үйл явцтай холбоотойгоор үүсэн бий болсон гэж үздэг бол нөгөө үзэл баримтлал нь компанийн үүсэл гарлыг эртний үетэй холбоотойгоор авч үздэг гэж хэлэхэд болно.

Гэхдээ компаний оршин байх нь тийм ч хурдан хүлээн зөвшөөрөгдөөгүй, өөрийн гэсэн саад бэрхшээлийг даван туулж гарч иржээ. Тухайлбал "The British East India Company-ийг байгуулахад Английн Парламентаас зөвшөөрөл олгож байжээ. Ер нь хуулийн этгээдийг хүнтэй адил нийгмийн харилцаанд оролцогч болохын хувьд эрх зүйн ойролцоо статустай болгохыг хичээн чармайж ирсэн түүхтэй.

Ийм ч учраас барууны орнуудад "Corporate Social responsibility" буюу компани нь нийгмийн өмнө хариуцлага хүлээх ёстой, компаний аливаа шийдвэр нь нийгэмд ямар үр дагавар авчирч болохыг тооцоолох ёстой гэсэн үзэл бодол нэлээд хүчтэй барьдаг.

Эртний үед компани нь эдийн засгийн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэж байгаагүй ба харин дундад зууны үеэс худалдаа хийхээс өөр хамтран ажил хийх зорилготой байгуулагдсан худалдааны нэгдэлд оролцогчид нь өөрсдийн хүч хөрөнгөө нэгтгэн худалдаа, арилжаа хийж эхэлсэн түүхтэй. Энэ үеэс эхлэн компани нийгмийн амьдралд голлох үүрэг гүйцэтгэн өнөөдөр бидний нийгэмд корпораци болон хувирчээ.

Орчин үеийн компанийн үүсэл хөгжил европтой салшгүй холбоотой байдаг. Европ дахь компанийн хөгжилд Голланд, Англи улс голлох үүрэг гүйцэтгэжээ.

XVI зууны сүүлчээр Голландад далайн худалдаа ихээр хөгжиж эхэлсэн байна. Үүнд Испани улс хамгийн ихээр саад болдог байсан тул нилээд олон хөлөг онгоц бүхий өөрийгөө хамгаалах чадвартай цуваа явдаг болсон байна. Сүүлдээ Голландын худалдаачдын хооронд хэт их өрсөлдөөн гарч, ашиг буурч эхэлсэн учраас төр засгийн санаачлагаар худалдааг нэгтгэн ашигтай болгох зорилгоор Ост Индийн компанийг байгуулсан байна. Энэ компанийг

бий болгоход Голландын олон газруудаас адил хувь, хөрөнгө оруулсан бөгөөд тэдгээр нь тодорхой хугацааны дараа өөрийн эзэмшлийн хувийг бусдад шилжүүлэх боломжтой болж, улмаар хамгийн бага шилжүүлэх боломжтой хэсгийг нь хувьцаа гэх болжээ. Эхэн үедээ Ост Индийн компани нь нилээд төвлөрсөн бус тогтолцоотой мэт тус тусдаа асуудал хариуцсан хэсгээс бүрдэж байсан байна. Харин компанийн эрх мэдлийн гол асуудлууд нь хэсэг бүхий төлөөлөл, зөвлөлд харьяалагдаж, тэд компаний үйл ажиллагааны талаар санал солилцож, хуралдаж байгаад энэхүү үйл явцаа “хувьцаа эзэмшигчдийн” хурал гэж нэрийдэх болжээ<sup>5</sup>.

Англи улс нь компанийн үүсэл хөгжил, эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийн хувьд нилээд сохирхолтой ард түмэн, зарим судлаачид орчин үеийн компани нь Англид үүссэн гэж үзэх тохиолдол байдаг. Компанитай холбоотойгоор хувьцаа болон хөрөнгийн зах зээл ихээхэн хурдацтай хөгжсөн байна.

Америкийн нэгдсэн улсад тусгаар тогтнолын эхэн үеэс компани буюу корпораци нь бизнес хийх үндсэн хэлбэр нь байж, түүхэн хөгжилд нь ихээхэн ач холбогдол өгсөн. Америкийн нэгдсэн улс холбооны улс учраас корпорацийн талаарх эрх зүйн зохицуулалт нь муж улс бүрээрээ тодорхой хэмжээгээр ялгаатай.

Монгол Улсын тухайд XIX зууны эхээр гадаадын пүүсүүд олон байсан баримт байдаг. Үүнийг хэдийгээр Монголд өөрсдийн байгуулсан компани байгаагүй ч гадаад улсын бизнесийн хэлбэр оршин байсан энэ үеэс эхтэй гэж хэлж болох үндэстэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын тойм:

### **Нэг. “Монгол Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай” /1926 он/**

Засгийн газрын 1926 оны 26-р хурлын тогтоолоор Аливаа хэргийг шүүн таслах газруудыг байгуулах тухай дүрмийн 2-р зүйлд заасан цэргийн болон цаг зуурын хэргийг шүүн таслах газруудаас мөрдөн, шийтгэхээр заасан хэргүүдээс зааглан “Монгол Улсын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай” хуулийг батлан гаргасан байна. Энэ хуульд Иргэний, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг хамтад нь хуульчилж өгсөн ба хуулийн есдүгээр бүлэгт Шүүх таслах газруудын тогтоолыг гүйцэтгэх

---

<sup>5</sup> Б.Мөнхтулга: Компаний эрх зүйн түүхэн хөгжил. УБ., 2003. 5-7 дахь тал

түхай /104-115-р зүйл/ асуудлыг зохицуулсан байна.Үүнд:

104-р зүйл. Шүүн таслах газрын аливаа тогтоолыг хүчин төгөлдөр болсны дараа удаашруулалгүй гүйцэтгэвэл зохино.

Тайлбарлах нь: Шүүх таслах газрын аливаа тогтоолыг үсэг зурсны дараа хүчин төгөлдөр болсонд үзэж дахин засаж өөрчлөхгүйгээр гүйцэтгэх боловч аливаа заалдан мэдүүлж болох хэргүүдээс үл дагах этгээд гарваас тэр хэргийг дээд газруудаас тогтоон шийтгэж хариу иртэл гүйцэтгэхийг түдгэлзвэл зохино.

105-р зүйл. Аливаа иргэний хэргийг шийтгэсэн тогтоол хүчин төгөлдөр болсны дараа нэхэмжилсэн этгээдээс гуйвал уг хэргийг гүйцэтгэх шийтгүүлэхээр харъяат шүүх таслах газрын түшмэлээс түүнд тусгай хуудас олговол зохино.

106-р зүйл. Дээрх зүйлд дурдсан гүйцэтгэх шийтгүүлэх хуудсыг тусгай маягтийн ёсоор үйлдэж шүүх таслах газрын тэргүүлэгч ба нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж олговол зохино.

Тайлбарлах нь: Дээрх зүйлд дурдсан хуудасны маягтыг энэхүү хуулийн сүүлд хавсаргав.

107-р зүйл. Аливаа цаазаар аваачих ялт хүмүүсээс энэ хуулийн 11 дүгээр зүйлийн ёсоор зохих газар хөнгөтгөх, хэлтрүүлэхийг гуйн мэдүүлсэн бол хариу иртэл шүүх таслах газрын тогтоолыг гүйцэтгэхийг түдгэлзүүлбэл зохино.

108-р зүйл. Шүүх таслах газрын аливаа хэргийн тогтоолыг хотуудад цагдан сэргийлэх газрууд, хөдөөд харъяа орон нутгийн албаны газруудаар гүйцэтгүүлбээс зохимой.

109-р зүйл. Хэрэв шүүх таслах газрын тогтоолыг гүйцэтгэн шийтгэхэд нэхэмжлэгдсэн этгээдийн эд хөрөнгө зэргийг битүүмжлэх ба данс үйлдэж үнэ хаялцуулан худалдах учир тохиолдвоос гаднаас томоо бүхий хоёр хүнийг урьж ирүүлэн гэрч болгож суулгаваас зохимой. Аливаа тогтоолыг гүйцэтгэн шийтгэж дууссан учир тусгай тогтоолыг үйлдэж харъяат газрын түшмэд ба гэрчийн этгээдүүд гарын үсэг зурж зохих шүүх таслах газар мэдүүлж байцаах тэмдэг болговоос зохимой.

110-р зүйл. Аливаа өр ширийн зэрэг зүйлийн нэхэмжлэгдсэн этгээдийн хөрөнгө хогшлыг дээр дурдсан ёсоор битүүмжлэх ба худалдахад түүний эм, хүүхэд буюу нэг хөрөнгөний ураг төрөлд зөвхөн амьдралын хувь үлдэхээс гадна аж үйлдвэрт чухал холбогдол бүхий зүйлүүдийг хураан авч үл болно.

111-р зүйл: Аливаа өр ширийн зэрэг зүйлийн төлбөр сүйтгэл төлөх этгээд үнэхээр хоосон ядуу болох аваас түүний хогшлыг үзэж гүйцэтгэн шийтгэвээс зохино.

112-р зүйл: Аливаа өр шир нэхэмжилсэн зэрэг иргэний хэрэгт үнэхээрийн бат баримтлах зүйл буй аваас дагаж буй хууль дүрэмд үл гажуудуулахаар хурдавчлан шийтгэн таслахад дагавал зохих зааврыг дараагийн зүйлүүдэд жагсаалаа.

113-р зүйл: Хураангуйгаар хурдавчлан шийтгэвэл зохих хэргүүд нь:

1. Вексель ба бусад аливаа зүйлийг зээлдүүлсэн барьцаалуулсны зэрэг явдлыг баталж зохих албаны газар нийтийн дүрмийн ёсоор гэрчлүүлсэн үнэмлэх бичгийг баримталж нэхэмжилсэн хэргүүд

2. Аливаа иргэний хэргийн учир харилцан тэмцэлдсэн этгээдүүд энэхүү хуулийн 84 дүгээр зүйлийг баримталж завсардсан эв найрамдлын ёсоор хэлэлцэж тасалсан хэргийн тогтоолыг дагаж уул төлбөр зэргийг үл гүйцэтгэсэн хэргүүд

3. Бусдаас гэрээ бичгийн ёсоор зээлдсэн буюу түрээслэсэн аливаа хөрөнгийг тогтоосон хугацаа дууссан даруй уул эзэнд эргүүлэн эс өгсний тухай хэргүүд

114-р зүйл. Аливаа өр ширийн зэрэг иргэний хэргийг хураангуйгаар хурдавчлан шийтгэхийг эрж мэдүүлсэн этгээдээс уул хэргийн бат баримтлах гэрээ буюу үнэмлэх зэргийн зүйлүүд ба тэрхүү зүйлүүдээс сийрүүлэн бичсэн нижгээд хувьд өөрийн гарын үсэг зурж хамт мэдүүлбэл зохино. Энэхүү хуулийн 43 ба 45 дугаар зүйлүүдэд заасан татварыг хэрэг мэдүүлэхийн хамт тооны ёсоор хураалгавал зохино. /43-р зүйл: Нэхэмжилсэн зүйлийн үнийн дээр зохих хүүг хэрэг мэдүүлсэн өдөр хүртэл нэмэгдүүлэн бодож шүүх таслах газарт дүрмийн ёсоор татварыг хураалгавал зохино, 45-р зүйл: Шүүх таслах газарт тусгай дүрмийн ёсоор хураалгавал зохих аливаа татвар зэргийг хэрэг мэдүүлэхийн хамт төлөвөөс зохино. Хэрэв үнэхээрийн төлж чадахгүй бол хэрэг дуусахыг хүртэл татвар хураахыг алгуурлаж болно/

115-р зүйл. Аливаа өр ширийг нэхэмжилж мэдүүлэхэд энэ хуулийн 38, 39, 40, 41 ба 43 дугаар зүйлийг баримталбал зохино. /38-р зүйл: Аливаа өр ширийн зэрэг иргэний хэргийг мэдүүлэхэд нөгөө этгээдийн үргэлж буюу түр суудаг газар, жич алба хааж буй газрын шүүх таслах газарт мэдүүлэх бөгөөд энэхүү хуулийн 2-р зүйлийн 3-р анги ба 3, 4-р зүйлүүдэд нийцүүлбэл зохино гэж заасан байжээ.

## **Хоёр. БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль” /1929 он/**

1929 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн БНМАУ-ын Засгийн газрын XXI хурлын тогтоол, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн мөн оны 64 дүгээр хурлын тогтоолын нэгдүгээр зүйлийг үндэслэн “БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль”-д нэмэлт оруулжээ. Энэ хуулийн XI бүлгийг “Шүүн таслах газруудад өр ширийн зэрэг иргэний хэргийг таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэх тухай” гэж нэрлээд 123-201 дүгээр зүйлүүдийг тусгасны дээр тогтоол гүйцэтгэгчээс үйлдэх дансны тэмдэглэл, маягтын загварыг баталжээ.

Уг хуульд Улсын цааз хуулийг хянан зохиох тусгай комиссоос Өр ширийн зэрэг иргэний хэргийг хураангуйгаар хурдавчлан шийтгэх тухай 10-р бүлгийг 11 зүйлтэйгээр төлөвлөн БНМАУ-ын Засгийн газрын 1928 оны 01-р сарын 27-ны өдрийн 4 дүгээр хуралд оруулж, уг хурлын тогтоолоор Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд нэмэлт оруулж байжээ.

Засгийн газрын 1929 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр хурлын тогтоолын 3 дугаар зүйлээр Монгол Улсын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд Шүүх таслах газруудад өр ширийн зэрэг иргэний хэргийг таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэх тухай уг хуулийн 9 дүгээр бүлэгт нэмэгдүүлэн зохиосон 11-р бүлгийг батлан гаргасан байна. Тухайлбал, 1929.09.23 –ны БНМАУ-ЫН 14 дүгээр бага хурлын тогтоолоос “Шүүх таслах тухай”... шийдвэрт “Өр ширийн зэрэг харилцан үл тохирох иргэний хэрэг үүдэх гаргах нь үлэмжхэн бөгөөд тухай бүр шүүх таслах газраар таслуулахад удаашрах боогдох гэм бүхий учир хэн алины дөхөм тусыг бодож иргэний хэргийг тогтоон шийтгэх шүүх таслахыг явуулбал зохино” гэжээ.

БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд иргэний болон эрүүгийн процессийг нарийвчлан зааглаж ялгаагүй, ард нийтийн бичиг үсгийн боловсролтой холбоотойгоор нэхэмжлэлийг амаар гаргах боломжийг заасан зэрэг цаг үеийн онцлог шинжтэй байсан боловч шүүхийн харьяаллыг анх удаа тодорхой заасан байдаг. Мөн хуульд “аливаа өр ширийн зэрэг иргэний хэрэг 100 төгрөг хүртэл буюу 4 бодоос дээш бус бол хошууны шүүн таслах газрын тогтоолыг заалдан мэдүүлж үл болохоор тусгасан” нь давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарласан шинжтэй байна.

1930 онд БНМАУ-ын 6 дугаар их хуралд Засгийн газрын хэлэлцүүлсэн

илтгэлийг сонсож гаргасан тогтоолд хууль цаазын ба шүүх таслах хэргийн тухай хэсгийн 2-т "...Урьд тогтоосон Иргэний ба байцаан шийтгэх хуулиудын дотроо хуучирч битүүлэгдсэн буюу шинэчлэн зохих зүйлүүдийг залруулбал зохино" гэж заасан чиглэлээр Шүүх явдлын яамнаас Аливаа иргэний хэргийг шүүх таслах тухай тайлбар /заавар/-г батлан гаргажээ. Найман бүлэг тавин долоон зүйлтэй уг тайлбар нь иргэний процессийг эрүүгийн процессоос зааглан өгсөн түүхэн ач холбогдолтой албан ёсны тайлбар байсан.

1940 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын хоёрдугаар Үндсэн хуулийг Улсын VIII их хурлаас батлан гаргаж, "Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий феодалын дарлалыг устгасан, цаашид нийгмийн журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыгхангаж, бүхий хөдөлмөрчин /малчин, ажилчин, оюутан /ардын тусгаар тогтносон улс мөн болно" гэж улсын хөгжлийн зорилтыг тодорхойлжээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1943 оны 03 дугаар сарын 15-ны 20 дугаар хурлын "Сум хороодын дарга нарыг шүүн таслах үүргээс чөлөөлөх тухай" тогтоолд "Шүүхийн тогтоол гүйцэтгэх ажилд сумдын захиргаад нь оролцож аймгийн шүүхүүдийн шаардсанаар уг тогтоолуудыг гүйцэтгэж байвал зохино" гэжээ.

### **Гурав. Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль" /1949 он/**

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1949 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр зарлигаар батлагдсан "Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль"-ийн 6 дугаар бүлгийг "Шүүхийн гүйцэтгэгч нар" гэж нэрлээд уг хуулийн 42-44 дүгээр зүйлүүдэд дараах заалтууд тусгагдсан байна. Үүнд:

-Иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр, магадлалууд ба эд хөрөнгийг гаргуулах тухай асуудалтай холбогдсон эрүүгийн хэргийг шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг шүүхийн гүйцэтгэгч нараас гүйцэтгэнэ.

Шүүхийн гүйцэтгэгч нар бол аймаг, хотын шүүхүүд ба Дээд шүүхийн дэргэд байх бөгөөд шүүх яамнаас эрхлэн томилно. Өөрсдийн ажлын талаар Ардын шүүгч буюу Дээд шүүхийн даргад захирагдана.

-Ардын хэсгийн шүүхүүдээс гаргасан эд хөрөнгийг төлүүлэх асуудалтай холбогдсон шүүхийн шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг сумдын захиргаанаас гүйцэтгэнэ.

Шүүхийн гүйцэтгэгч нар ба мөн шүүхийн даалгавараар шүүхийн

гүйцэтгэгч нарын үүргийг биелүүлж байгаа сумдын захиргааны ажилтан нараас шүүхийн шийтгэсэн тогтоол, шийдвэр ба магадлалуудыг биелүүлэхээр шаардсан шаардлагыг бүх албан тушаалын хүмүүс ба ард иргэдээс заавал гүйцэтгэвэл зохино гэжээ.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1952 оны 5-р сарын 27-ны өдөр зарлигаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль батлагдсан. Уг хууль нь 22 бүлэг, 161 зүйлтэй, БНМАУ-ын шүүхийн байгууллагад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг тогтоосон, анхны төрөлжсөн хууль юм.

Энэхүү хууль Монгол улсын хөгжлийн зорилготой уялдан хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалсан, иргэний хэргийн аль ч үе шатанд прокурор өөрийн үзэмжээр оролцдог, иргэний хэргийн болон шүүхийн харьяаллыг тодорхой заасан, улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, төлөх журмыг нарийвчлан тодорхойлсон, нотлох баримтын асуудлыг бүлэг болгон тусгасан, шүүхийн шийдвэрийг Шүүх яамны сайд, улсын прокурор хянадаг байжээ.

### **Дөрөв. БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль /1952 он/**

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагааны талаар заахдаа:

Шүүхээс шийдвэр гаргахын өмнө уг хэргийг хянан үзэж байх ажиллагааны үед нэхэмжлэлээ хангуулах тухайн хүсэлтийг нэхэмжлэгч нь шүүхэд гаргаж болно. Нэхэмжлэлийг хангахдаа хариуцагчийн мөнгөн хөрөнгө буюу эд хогшлыг битүүмжлэх тухай магадлалыг гаргах замаар гүйцэтгэнэ. Энэхүү магадлалыг шүүхийн гүйцэтгэгчээс шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмаар биелүүлнэ. Улсын албан байгууллага ба үйлдвэрийн газруудад гаргасан нэхэмжлэлийг урьдчилан хангахаар хөрөнгийг битүүмжилж үл болно.

Нэхэмжлэлийг хангахаар хөрөнгийг хамгаалах тухай гаргасан өргөдлийг уг хэргийг хянан үзэж байгаа шүүхээс зохигчдыг дуудахгүйгээр шийдвэрлэнэ. Нэхэмжлэл нь зохих баримтаар гүйцэд батлагдсан ба эсхүл уул нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авахгүй бол шүүхээс гаргасан шийдвэрийг ханган биелүүлэх бололцоогүй болох байдалд хүрэх хэрэгт нэхэмжлэлийг хангахаар хөрөнгийг урьдчилан хамгаалж болно.

Нэн даруй биелүүлбэл зохих шийдвэр:

-Ажлын хөлс ба хүүхдийн тэтгэврийн тухай нэхэмжлэл хийгээд зохигчийн эрхээс үндэслэн гарсан нэхэмжлэлийн зүйлүүд



-Хугацаа нь хэтэрсэн төлбөрийн талаар Монгол банкнаас гаргасан нэхэмжлэл

Шүүхийн гүйцэтгэгч буюу сумын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны газруудаас гүйцэтгэх зүйлүүд гэвэл:

1. Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр ба нотариатын конторын гүйцэтгэх хуудсууд;

2. Торгууль хүлээлгэх ба нэхэмжлэлийг хангах тухай иргэний ба эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан магадлалууд, түүнчлэн хулгайлсан ба үрэгдүүлсэн зүйлийг төлүүлэх тухай шийтгэсэн тогтоолууд;

3. Улсын арбитрын шийдвэрүүд;

4. Зохигчдоос шүүхэд батлуулж эвлэрсэн хэлэлцээний тухай магадлалыг тус тус гүйцэтгэх ёстой.

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх 1952 оны хууль нь 18 бүлэг 161 зүйлтэйгээр батлагдсан байна. Энэ хуульд хуулийн этгээдтэй холбоотой дараах заалтууд тусгагдсан байна. Тухайлбал:

Хоёрдугаар бүлэг: Шүүхэд төлөөлөх хүмүүс

10-р зүйл. "Улсын ба хоршооны болон бусад олон нийтийн байгууллага нь тогтоосон хууль буюу байгууллагын дүрмийн ёсоор томилж байгаа төлөөлөгчөөрөө дамжуулан нэхэмжлэлийг гаргах ба хариуцлагыг хүлээх болно".

Зохигчдыг төлөөлж болох хүмүүс нь:

- Өмгөөллөх коллегийн гишүүд
- Энэ зүйлийн нэгдүгээрт хэсэгт дурдсан байгууллагуудын төлөөлөгчид
- Зохигчдын ураг төрлийн хүмүүс ба хэргийг хянан шийдвэрлэх явдалд шүүхээс зөвшөөрөн оруулсан бусад хүмүүс болно.

11-р зүйл. "Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд өөрийн байгууллагын хэргийн талаар хийгээд үйлдвэрчний эвлэлийн гишүүдээс гаргасан хөдөлмөрийн хэргийн нэхэмжлэлийн талаар өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд оролцох эрхтэй болно"

Гуравдугаар бүлэг: Харьяалагдан таслагдах хэргүүд

15-р зүйл. "Аймаг, хот ба хэсгийн шүүхүүд нь улсын арбитраас эрхлэн шийдвэрлэвэл зохих хэргүүдээс бусад 50 мянган төгрөгөөс үл хэтрэх нэхэмжлэлийн иргэний бүх хэргүүд мөн энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан бүх нэхэмжлэлүүд, хөдөлмөрийн хуулийг зөрчсөнөөс ба зохигчдын эрх, өв залгамжлах тухай болон хүүхдийн тэтгэврээс үндэслэн гарсан нэхэмжлэлүүдийг үнийн хэмжээг харгалзахгүйгээр хянан шийдвэрлэнэ"

16-р зүйлд “Дээд шүүхэд 50 мянгаас дээш төгрөгийн нэхэмжлэлтэй иргэний бүх хэрэг харьяалагдан таслагдана. Дээд шүүхийн дарга нь ямар ч иргэний хэргийг өөрийн үзэмжээр дээд шүүхэд харьяалагдах зарим хэсгийг аймаг, хотын буюу хэсгийн шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно”

17-р зүйлд “Иргэний бүх хэргийг ардын шүүгчээр даргалуулан ардын хоёр төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ”<sup>6</sup>.

Дөрөвдүгээр бүлэг: Шүүхийн зардлууд

27-р зүйл. “Тэмдэгтийн татварыг хураахгүй шалтгаан гэвэл”

- Ажлын цалин хөлс нэхэмжилсэн ба хөдөлмөрийн харьцаанаас үндэслэн гарсан бүх шаардлагын нэхэмжлэлээс,

- Гар үйлдвэрийн хоршооллын системд багтах үйлдвэрийн нэгдэл /артель/-ийн гишүүдийн ажлын шагналын нэхэмжлэлээс

- Улсын төсөвт албан байгууллагын нэхэмжлэлээс

Есдүгээр бүлэг: Нэхэмжлэл хангах тухай

46-р зүйл. “Улсын албан байгууллага ба үйлдвэрийн газруудад гаргасан нэхэмжлэлийг урьдчилан хангахаар хөрөнгийг битүүмжилж үл болно”,

Арван тавдугаар бүлэг: Гүйцэтгэх хуудсыг олгох тухай

95-р зүйл. “Нэн даруй биелүүлбэл зохих шийдвэр”

б/ Хугацаа хэтэрсэн төлбөрийн талаар Монгол банкнаас гаргасан нэхэмжлэл

Арван есдүгээр бүлэг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байдал

120-р зүйл. “Улсын ба хоршоо, олон нийтийн байгууллагын хоорондын бүх маргалдааны талаар гаргасан шийдвэрийг биелүүлэх хугацааг нэг жилээр тогтоох бөгөөд буёад бүх маргалдааны талаар гурван жилийн хугацааг тогтооно”, Хэрэв шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс хөөн хэлэлцэх хугацааны дотор биелүүлэхгүй байгаа шийдвэрийг буцаан ирүүлбэл уул хугацааг шинээр эхэлнэ,

127-р зүйл. “Шүүхийн гүйцэтгэгчид орсон мөнгөн хөрөнгө нь өрт этгээдээс шинээр нэмэгдэж байгаа төлбөрийг хангахад хүрэлцэхгүй бол түүнийг дурдсан ээлж дараагаар хувиарлах болно”

---

<sup>6</sup> С.Энхбаяр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол улсын хуулиуд /1926,1952,1967,1994,2002 он/.УБ., 2005. 68-70 дахь тал

• Ажлын хөлс ба хөдөлмөрийн харилцаанаас үүсэж гарсан нэхэмжлэлүүд болон зохиогчийн эрх ба зохион бүтээсэн зүйлийн тухай нэхэмжлэл

- Тахир дутуу болсны нэхэмжлэл
- Хүүхдийн тэтгэвэрийн тухай нэхэмжлэл
- Үйлдвэрчний хороо ба нийгмийн аюулаас хамгаалах зүйлийн шимтгэлийн талаар үйлдэрчний эвлэлийн байгууллагаас гаргасан шаардлага
- Монгол банкны нэхэмжлэл
- Бусад нэхэмжлэл

Хорьдугаар бүлэг: Эд хөрөнгөөс төлбөрийг гаргуулах тухай

133-р зүйл. “Хадгаламжийн каст байгаа ба хоршооны байгууллагад оруулсан зүйлийг битүүмжлэн хураах явдлыг гагцхүү эрүүгийн хэргийн талаар шүүхийн буюу мөрдөн байцаах байгууллагын тогтоолоор гүйцэтгэнэ”.

135-р зүйл. “Аж ахуйн байгууллагуудын их барилгын талаар харилцах данснаас төлбөрийг гаргуулахдаа гагцхүү арбитор буюу шүүхээс тэр төлбөрийг их барилгатай холбогдолтой гэж үзвэл сая гүйцэтгэж болно”.

Хорин нэгдүгээр бүлэг: Улсын ба хоршоо, олон нийтийн байгууллагуудаар өр төлүүлэх

152-р зүйл. “Монгол банкинд буюу түүний салбаруудад харилцах данс буюу тооцооны данстай улсын ба хоршооны болон бусад байгууллагууд нь 100-гаас дээш төгрөгийн төлбөртэй бол нэхэмжлэгч нь төлбөрийг гаргуулах тухай баримт бичгийг банкинд шилжүүлэх бөгөөд банк нь уул мөнгийг хариуцагчийн данснаас нэхэмжлэгчийн дансанд шууд шилжүүлэн гүйцэтгэнэ. Харин нэхэмжлэгч нь банкинд харилцах дансгүй бол хариуцагчийн данснаас ардын шүүхийн тусгай харилцах дансанд шилжүүлнэ”

153-р зүйл. “Энэхүү хуулийн 152 дугаар зүйлд дурдсан албан байгууллагаар төлүүлэх мөнгөний тоо нь 100 төгрөгөөс илүү бус бол уул төлбөрийг гүйцэтгэх хуудсыг шүүхийн тогтоол гүйцэтгэгчдэд шилжүүлнэ”

154-р зүйл. “Энэхүү хуулийн 153 дугаар зүйлд дурдсан хариуцагч этгээдийн харилцах дансанд 3 сарын турш мөнгө байхгүй байвал монгол банк буюу түүний салбарууд нь зохих гүйцэтгэх хуудсыг нэхэмжлэгчдэд буцаан

---

<sup>7</sup> С.Энхбаяр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/. УБ., 2005. 87-89 дэх тал

өгөх бөгөөд нэхэмжлэгч нийтийн журмаар төлөх тухай гүйцэтгэх хуудсаа шүүхийн тогтоол гүйцэтгэгчдэд шилжүүлж болно

155-р зүйл. “Улсын буюу орон нутгийн төсөвтэй албан байгууллагуудын хөрөнгө хогшлыг хурааж өр төлүүлж үл болно. Хэрэв төлбөрийг эс төлбөл авах этгээд нь тэр албан байгууллагын дараах жилийн төсөвт уг төлбөрийг нэмэн төсөвлөх тухайг санхүүгийн зохих байгууллагуудад хүсэлтээ тавьж болно”

156-р зүйл. “Ажлын хөлс төлүүлэх явдал гүйцэтгэх хуудсаар төлүүлэгдээгүй байвал уг өрийг уул нэхэмжилсэн этгээд буюу шүүхийн гүйцэтгэгчийн өргөдлөөр уг өрийг хариуцагчийн төсвийн аль ч зүйлээс гаргуулах тухай магадлалыг шүүхээс гаргавал зохино. Үүнд: Зээллэгийг эрхэлсэн хүн нь өөртөө байгаа төсвийн бүх зүйлийн тухай шүүхэд мэдэгдэх үүрэгтэй болно,

157-р зүйл. “Хоршоо ба бусад олон нийтийн байгууллага хийгээд аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газраар төлүүлэх тухай шийдвэрийг гүйцэтгэхдээ шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь дагаж шийтгүүлж байгаа хуулиар төлбөр гаргуулж болох хөрөнгийг баривчилж худалдах ажилд орно. Үүнд 1 сарын дотор цалин хөлсөнд олгогдох гэж байгаа мөнгөнөөс төлбөрийг гаргуулж үл болно”

Хорин хоёрдугаар бүлэг: Ажлын хөлс ба зохигчдын шагналаас төлбөрийг гаргах тухай

158-р зүйл. “Улсын ба хоршоо болон бусад олон нийтийн байгууллага нь шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шаардлагаар өрт этгээд нь тэднийд ажиллаж байгаа эсэх, ямар цалин хөлс авч байгааг мэдэгдэх үүрэгтэй”

Улсын ба хоршоо, олон нийтийн байгууллагын хоорондын бүх маргалдааны талаар гаргасан шийдвэрийг биелүүлэх хугацааг нэг жилээр тогтоох бөгөөд бусад бүх маргалдааны талаар гурван жилийн хугацааг тогтооно. Хэрэв шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс хөөн хэлэлцэх хугацааны дотор биелүүлэхгүй байгаа шийдвэрийг буцаан ирүүлбэл уул хугацааг шинээр эхэлнэ<sup>8</sup>. Шүүхийн гүйцэтгэгч буюу сумын гүйцэтгэх захиргаа нь шийдвэр ба магадлалыг биелүүлэх ажилд орохдоо уул биелүүлбэл зохих зүйлээ 15 өдрийн дотор сайн дураар гүйцэтгэх тухай шаардсан бичгийг өрт этгээдэд нэн даруй явуулна. Хэрэв өрт этгээд нь тийнхүү сайн дураараа

---

<sup>8</sup> С.Энхбаяр. "ИХШХШийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд" УБ., 2005 он. 28 дахь тал

гүйцэтгэх явдлаас зайлсхийвэл шүүхийн гүйцэтгэгч буюу сумын гүйцэтгэх захиргаа нь албадан төлүүлнэ.

Шүүхийн гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлаа уул хөрөнгө байгаа газарт нь гүйцэтгэх бөгөөд хэрэв чухал хэрэг тохиолдвол шүүхийн гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх ажлаа уул аймаг буюу хотын дэвсгэр нутгийн гадна гүйцэтгэнэ.

Шүүхийн гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлаа биелүүлэхдээ, эд хөрөнгийг нлрүүлэх зорилгоор хөндлөнгийн 2 этгээдийг оролцуулан өрт этгээд буюу түүний гэр бүлийн хүмүүсийг байлгаж, орон сууцанд нь үзлэг хийх бөгөөд харин хэрэг тохиолдвол түүний орон байр буюу юм хадгалах газрыг нь албадан нээж шалгаад тухайн актыг гаргана.

Хойшлуулж үл болох хэрэг тохиолдвол тогтоол гүйцэтгэх ажлыг ардын шүүгчийн зөвшөөрлөөр шөнийн цагт гүйцэтгэж болно.

Шүүхийн гүйцэтгэгч нь шүүхийн магадлал ба нэхэмжилж буй этгээдийн өргөдөлгүйгээр гүйцэтгэх ажлаа хойшлуулах буюу зогсоох эрхгүй болно. Шүүхийн гүйцэтгэгчид орсон мөнгөн хөрөнгө нь өрт этгээдээс шинээр нэмэгдэж байгаа төлбөрийг хангахад хүрэлцэхгүй бол түүнийг дурдсан ээлж дараагаар хувиарлах болно.

1. Ажлын хөлс ба хөдөлмөрийн харилцаанаас үүсэж гарсан нэхэмжлэлүүд болон зохиогчийн эрх ба зохион бүтээсэн зүйлийн тухай нэхэмжлэл;

2. Тахир дутуу болсны нэхэмжлэл;

3. Хүүхдийн тэтгэврийн тухай нэхэмжлэл;

4. Үйлдвэрчний хороо ба нийгмийн аюулаас хамгаалах зүйлийн шимтгэлийн талаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гаргасан шаардлага;

5. Монгол банкны нэхэмжлэл;

6. Бусад нэхэмжлэл.

Шийдвэр ба магадлал бусад албан бичгийг гүйцэтгэхдээ, гүйцэтгэх хуудас авсан өдрөөс хойш хотод бол 20 өдөр, бусад газар бол 1 сар хүртэлх хугацаанд гүйцэтгэх ба төлбөр төлүүлэх талаар бүх чухал арга хэмжээг авсан боловч төлөгч этгээд нь хөрөнгө хогшил ба ажлын хөлс байхгүй учраас уул төлбөрийг гаргуулах бололцоо байхгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь хөндлөнгийн 2 хүмүүс ба орон нутгийн байгууллагаас хүнийг оролцуулан энэ тухай акт бичиж ардын шүүгчээр батлуулахаар оруулна.

Шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлаа дуусмагц гүйцэтгэсэн

бүх баримт бичгийг ардын шүүгчид оруулах бөгөөд ардын шүүгч түүний ажиллагаа нь зүйтэй болсон эсэхийг хянан үзнэ. Хэрэв ардын шүүгч нь тийнхүү гүйцэтгэсэн ажлыг зүйтэй болсон гэж үзвэл гүйцэтгэлийн зүйлээ архивт тушаах тухай шийдвэр өгнө. Хэрэв шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн ажил нь буруу болсон байвал дутагдлыг засах тухай шийдвэрийг ардын шүүгч нь өгнө.

Шүүхийн шийдвэрийг биелүүлсэн шүүхийн тогтоол гүйцэтгэгч ба бусад шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагын ажиллагаанд гаргасан гомдлыг уул шийдвэрийг гүйцэтгэсэн нутгийн ардын шүүхэд гаргана.

Төлбөрийг өрт этгээдийн хөрөнгийг данслах, битүүмжлэх ба улмаар худалдах замаар гаргуулан авна. Шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь хөрөнгийг бүртгэн<sup>9</sup> данслахдаа өр төлөгч буюу түүний гэр бүлийн хүмүүс ба хөндлөнгийн 2 этгээдийг байлцуулан гүйцэтгэнэ. Төлбөр хүлээсэн этгээдийн гуравдугаар этгээд дээр байгаа хөрөнгийг төлбөрт авахдаа энэ бүлэгт заасныг үндэслэн гүйцэтгэнэ. Хадгаламжийн касст байгаа ба хоршооны байгууллагад оруулсан зүйлийг битүүмжлэн хураах явдлыг гагцхүү эрүүгийн хэргийн талаар шүүхийн буюу мөрдөн байцаах байгууллагын тогтоолоор гүйцэтгэнэ.

БНМАУ-ын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулж үл болно. Аж ахуйн байгууллагуудын их барилгын талаар харилцах данснаас төлбөрийг гаргуулахдаа гагцхүү арбитр буюу шүүхээс тэр төлбөрийг их барилгатай холбогдолтой гэж үзвэл сая гүйцэтгэж болно<sup>9</sup>.

Зээлдүүлэгч этгээд аж ахуйн газрын их барилгад үл холбогдох харилцах данс буюу өөр хөрөнгөнөөс төлбөр гаргуулахдаа гагцхүү их барилгад үл хамаарах бусад үүргийн зүйлээс төлбөр гаргуулж болно.

Битүүмжлэгдсэн хөрөнгөний данснаас 3 дугаар этгээдийн гомдлоор ямар 1 хогшил хөрөнгийг хасах тухай асуудлыг шүүхээс нийт нэхэмжлэлийн журмаар шийдвэрлэнэ. Шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь дансалсан хөрөнгийг битүүмжилж болох ба энэ тухай дансалсан актанд дурдана. Шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь хөрөнгийг данслахын хамтаар түүнийг захын дундын үнийг баримтлан үнэлнэ. Хэрэв чухалд үзвэл хөрөнгийг үнэлэхийн тулд экспертийг урьж болно.

Дансалсан хөрөнгийг эдэлж хэрэглэхэд үнэ чанараа алдахгүй бол өр төлөгч этгээдэд эдэлж хэрэглэхийг зөвшөөрөөд түүнд хадгалуулж болно. Хэрэв өр төлөгч этгээд нь тэр хөрөнгийг хадгалах явдлаас татгалзах бол

---

<sup>9</sup> С.Энхбаяр. "ИХШХШийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд" УБ., 2005 он. 30 дахь тал

шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь өөрийн үзэмжээр өөр хүнийг томилон хадгалуулна.

Хадгалагч хүн нь өр төлөгч этгээд биш бол хадгалсны шагналыг ардын шүүхийн тогтоосон ёсоор авна. Хадгалж байсан шагналыг уул хөрөнгө хогшлыг худалдан борлуулсан мөнгөнөөс олгоно. Дансалсан ба баривчилсан эд хогшлыг дор дурдсан журмаар борлуулна.

-Улсаас хатуу үнэ тогтоосон барааг улсын ба хоршооны байгууллагуудын тогтоосон үнээр тэдгээр байгууллагуудад нь шилжүүлнэ.

-Задгай ба эдлэлийн алт, платина, мөнгө, ембүү мөн түүнчлэн үнэтэй чулууг

-Монгол банкинд шилжүүлэн улмаар тэдгээрийн өртгийг зохих үнээр уул төлбөрийг гаргуулж буй нэхэмжлэгчид хүргүүлнэ.

-Бусад төрлийн хураагдсан хөрөнгийг үнэ хаялцуулан худалдана.

-Шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс үнэ хаялцуулан нийтэд худалдах зүйлийн тухай 3 хоногийн урьдаас орон нутгийн сонинд буюу энгийн зарлалыг олон нийтийн явах газар гаргана.

Өр төлөгч этгээд нь ямар хөрөнгийг ямар ээлж дараагаар худалдвал зохихыг зааж хэлэх эрхтэй болно. Хэрэв эхний худалдсан хэсэг хөрөнгө хогшлын үнэ нь уул төлбөрийг төлөхөд хангалттай хүрэлцвэл цаашид үргэлжлэн худалдах явдлыг зогсооно.

Хөрөнгө хогшлыг үнэ хаялцуулан худалдахад худалдан авсан этгээд нь түүнийхээ үнийг тэр даруйдаа төлбөл зохино. Авсан юмны үнийг төлөөгүй хүн нь үнэ хаялцуулан худалдах ажилд цаашид оролцох явдлаас хасагдана. Байшин барилгыг нийтийн өмнө үнэ хаялцуулан худалдсан бол түүнийг авсан хүнд худалдсан тухай актын хуулбарыг олгоно. Энэ хуулбарыг уул байшин барилгын байгаа газрын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд заавал бүртгүүлбэл зохино. Худалдсан зүйлийн мөнгөнөөс уул хөрөнгийг барьж авах, хадгалах ба түүнийг худалдахад зориулсан зардлыг төлөөд бусад үлдсэнийг уул төлбөрийг төлүүлэхэд зориулна. Үнэ хаялцуулан худалдуулсанд үл тооцох шалтгаан гэвэл:

- Үнэ хаялцуулан худалдахад худалдан авахаар хэн ч эс ирвэл
- Хэрэв ирсэн хүмүүс нь тогтоосон үнэ дээр дахин үнэ эс нэмбэл үнэ хаялцуулан худалдсан гэж тоолж үл болно. Үнэ хаялцуулан худалдаж буй хогшил хөрөнгө нь хэрэв худалдагдахгүй бол төлбөрийг авах этгээд нь түүний төлбөрт өгөхөөр худалдаж байгаа тэр хогшил хөрөнгийг худалдахаар тогтоосон үнээр бодож шилжүүлэн өгөх тухай 3 хоногийн дотор өргөдлөө гөргөж болно.

Үнэ хаялцуулахаар худалдахад төлбөр авагчдын хэн нь ч уул хөрөнгө хогшлыг өөртөө үлдээж авахгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь 5 өдрөөс хожимдуулахгүйгээр анх үнэ хаялцуулан худалдахаар тогтоосон журмыг баримтлан хоёрдугаар удаа үнэ хаялцуулан худалдахыг зарлана. 2 дугаар удаа үнэ хаялцуулан худалдаж чадаагүй ба төлбөр авагчид нь уул хөрөнгийг шилжүүлэн авахыг хүсэхгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс уул хөрөнгийг өр төлөгч этгээдэд буцаан өгөхийн хамт гүйцэтгэх хуудсыг уул өр авагчид шилжүүлэн өгч тухайн актыг бичнэ гэжээ.

### **Тав. Иргэний хууль /1960 он/**

1960 оны III Үндсэн хуулийн үзэл санааг тусгасан социалист гэх тодотголтой Иргэний байцаан шийтгэх хуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын их хурлаас 1967 оны 6 дугаар сарын 29-ны өдөр батлан гаргасан. Уг хууль нь бүтцийн хувьд 6 хэсэг, 39 бүлэг 313 зүйлтэй бөгөөд "...Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэний шүүн таслах ажиллагааны зорилт нь тус улсын нийгмийн ба төрийн байгууламж, аж ахуйн социалист систем, социалист өмчийг хамгаалах, иргэдийн улс төр, хөдөлмөр, орон сууцны ба бусад хувийн болон эд хөрөнгийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, түүнчлэн улсын албан байгууллага, үйлдвэрийн газар, хөдөө аж ахуйн нэгдэл бусад хоршоолол, олон нийтийн байгууллагын эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэний хэргийг түргэн шаламгай, зөв шийдвэрлэх явдал мөн. Иргэний шүүн таслах ажиллагаа нь социалист хууль ёсыг бэхжүүлэх, эрх зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх, иргэдийг эх орон, социализм коммунизмын үйл хэрэгт хязгааргүй үнэнч болгон хүмүүжүүлэх, БНМАУ-ын хуулийг хэлбэрэлтгүй биелүүлэх, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн сахихад тус дөхөм үзүүлэх ёстой" хэмээн зорилтоо тодорхойлсон байв.

Иргэний байцаан шийтгэх 1952 оны хуультай харьцуулж үзвэл 1967 оны хууль нь зорилго, бүтцийн ялгаатайгаас гадна иргэний хэрэг үүсгэх үндэслэл, шүүхийн болон хэргийн харьяалал, хэргийн оролцогч, улсын тэмдэгтийн хураамж, нотлох баримт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах зэрэг процессын эрх зүйн олон асуудлыг илүү дэлгэрэнгүй, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохицуулсан нэгдмэл төрөлжсөн эрх зүйн акт байсан ба 30 шахам жил Монгол Улсын иргэний шүүн таслах ажиллагааны үндсэн зарчим, журмыг тодорхойлж ирсэн билээ. Уг хуулийн 263-р зүйлд зааснаар:

Төлбөр төлөгч тогтоосон хугацаанд шийдвэрийг гүйцэтгээгүй буюу сайн



дураар гүйцэтгэхээс татгалзвал шүүхийн тогтоол гүйцэтгэгч шийдвэрийг албадан гүйцэтгэнэ.

Албадан гүйцэтгэх арга хэмжээнүүд:

- Төлбөр төлөгчийн хөрөнгийг данслан битүүмжлэх ба худалдан борлуулж төлбөр гаргуулах;
- Төлбөр төлөгчийн цалин, бусад орлогоос төлбөр гаргуулах;
- Төлбөр төлөгчийн бусдад байгаа мөнгө, эд хөрөнгөөс төлбөр гаргуулах;
- Шүүхийн шийдвэрт заасан ямар нэгэн тодорхой зүйлийг төлбөр төлөгчөөс гаргуулан авах ба төлбөр авагчид шилжүүлэх;
- Хуулийн дагуу шүүхийн шийдвэрт заасан бусад арга хэмжээг авна.

Шүүхийн тогтоол гүйцэтгэгч шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үед шаардлагатай бол төлбөр төлөгчийн байр ба түүний агуулахад үзлэг хийх эрхтэй. Төлбөр төлөгчийн байр, агуулахыг нээж үзэхдээ орон сууцны захиргааны эрх бүхий төлөөлөгчийг байлцуулна<sup>10</sup> гэх зэргээр заажээ.

Гуравдугаар бүлэг: Хэргийн ба шүүхийн харьяалал

21-р зүйл. Шүүхийн байгууллагад харьяалагдах иргэний хэргүүд

“Хоршоолол, олон нийтийн байгууллага хоёрын хоорондох маргаан, түүнчлэн эдгээр байгууллага ба улсын байгууллагын хоорондох эд хөрөнгийн маргааныг хэрэв Улсын арбитраар шийдвэрлүүлэхээс зохигчдын аль нэг татгалзвал уг маргааныг шүүх авч хэлэлцэнэ<sup>11</sup>”, “Түүнчлэн гадаадын иргэн буюу байгууллага оролцсон хэргийг нэгэн адил шүүх авч хэлэлцэнэ”

25-р зүйл. “Хоршоолол, олон нийтийн байгууллагын хоорондох, түүнчлэн эдгээр байгууллага, улсын байгууллагын хоорондох эд хөрөнгийн маргааны нэхэмжлэлийн хэмжээ нь гучин мянган төгрөгөөс дээш байвал аймаг хотын шүүх хэлэлцэнэ”

27-р зүйл. “Хуулийн этгээдэд гаргах нэхэмжлэлийг түүний ажил хэргийг байнга явуулж байгаа байгууллагын оршин байгаа газрын шүүхэд гаргана”

48-р зүйл. “Хуулийн этгээд болох улс, хоршоолол, олон нийтийн байгууллага нь хууль буюу дүрмээр тогтоосон эрх хэмжээнийхээ дотор ажиллаж байгаа өөрийн байгууллага, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан

<sup>10</sup> С.Энхбаяр. “ИХШХШийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд” УБ., 2005 он. 104 дэх тал

<sup>11</sup> С.Энхбаяр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/. УБ., 2005. 113-115 дахь тал

байцаан шийтгэх ажиллагаанд оролцоно”, “Хуулийн этгээдийн хувиар оролцож байгаа албан байгууллагын эрх баригчид өөрийн албан тушаал буюу эрх олгогдсоныг нотлох үнэмлэх бичгийг шүүхэд үзүүлэх ёстой”.

64-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэд нь шүүхээс шаардсан нотлох бичиг баримтыг тогтоосон хугацаанд нь шаардсан шүүхэд шууд явуулах буюу эсхүл түүний хүлээн авах эрхийг шүүхээс олгосон этгээдэд гардуулан өгнө”, “Хэрэгт оролцоогүй улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэд нь шаардсан баримт бичиг буюу түүний хуулбарыг өгөх буюу түүнийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх боломжгүй байвал энэ тухайн шалтгааныг зааж шүүхэд даруй мэдэгдэх үүрэгтэй”.

Арван зургадугаар бүлэг: Шүүх хурлын ажиллагаа

119-р зүйл. “Шүүхэд хэлэлцэж байгаа эрхийн талаар эрх бүхий байгууллагын буюу хамт олны саналыг гаргуулахын тулд хэрэгт зохиогчоор оролцоогүй олон нийтийн байгууллагын төлөөлөгчийг шүүхийн магадлалаар иргэний хэрэг хэлэлцэж байгаа шүүх хурлын ажиллагаанд оролцож болно”

“Олон нийтийн байгууллагын төлөөлөгчид нь хэргийн материалтай танилцах, шүүх хурал бүрд байлцах, нотлох баримт гаргах, нотлох баримтыг шинжлэхэд оролцох, хэргийн оролцогчид, гэрч, шинжээчид асуулт тавих, шүүх хурлын ажиллагааны явцад гарсан асуудлын талаар саналаа хэлэх, шүүх хурлын шүүмжлэлд оролцох эрхтэй”.

“Олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн хамт олны төлөөлөгчдийн эрх нь шүүхэд хэлэлцэж байгаа хэргийн талаар олон нийтийн байгууллагын бүх гишүүд буюу төлөөлөгчийг сонгосон байгууллага, эсхүл хамт олны хурлаас гаргасан шийдвэрээр батлагдана”.

154-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагаас мөнгөн төлбөр гаргуулах тухай шийдвэрийг шүүх гаргахдаа төлбөрийн шинж байдал ба хариуцагчийн банкинд байгаа ямар данснаас гаргуулбал зохихыг заана”.

Хорин есдүгээр бүлэг: Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гомдол гаргах

200-р зүйл. “Төлбөр гаргуулах тухай захиргааны байгууллагын дор дурдсан үйл ажиллагаанд иргэдээс гаргасан гомдлыг шүүх авч хэлэлцэнэ.

Үүнд:

1. Улсын ба орон нутгийн албан татвар, хураамжийн дутууг төлүүлэх

2. Ойн хууль зөрчсөн, мөн улс, хоршоолол, олон нийтийн нийгмийн аж ахуйн хадлан, тариалан, сүйтгэсэн бусад таримал зүйлийг эвдэж, гэмтээсэнтэй холбогдон гарсан хохирол ба торгуулийг төлүүлэх”

Гучин тавдугаар бүлэг: Тогтоол гүйцэтгэлийн ажиллагаа

275-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, түүнчлэн иргэд нь өөрсдийн харьяанд төлбөр төлөгч ажиллаж байгаа эсэх, түүний сард авч байгаа цалинг шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шаардсанаар тогтоосон хугацаанд гаргаж мэдэгдэх үүрэгтэй”

Гучин долдугаар бүлэг: Улс хоршоолол, олон нийтийн байгууллагад холбогдолтой шийдвэрийг гүйцэтгэх

288-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагууд холбогдолтой шийдвэрийг энэ бүлэгт заасан тусгай журам болон БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн ерөнхий журмын дагуу гүйцэтгэнэ”

289-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагаас гүйцэтгэх бичиг баримтаар төлбөрийг юуны өмнө банкинд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгөөс гаргуулна<sup>12</sup>”

“Банк дахь дансанд мөнгөн хөрөнгө байхгүй буюу байсан ч төлбөрт хүрэхгүй бол төлбөр бүхий улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно. Эдгээр эд хөрөнгийг борлуулах явдлыг БНМАУ-ын хууль тогтоомжинд заасан журсаар гүйцэтгэнэ”

290-р зүйл. “Банкинд данс бүхий улс, хоршоолол, олон нийтийн байгууллага нь төлбөр төлөгчийн банзинд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа гүйцэтгэх бичиг баримтыг батлан зохих хэлтэст шууд ирүүлэх бөгөөд тэр нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг албадан гаргаж төлбөр авагчийн дансанд шилжүүлнэ”.

“Банкинд дансгүй төлбөр авагч байгууллага нь төлбөр төлөгч байгууллагын банкинд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа гүйцэтгэх бичиг баримтыг шүүхийн тогтоол гүйцэтгэгчид явуулах бөгөөд шүүхийн тогтоол гүйцэтгэгч төлбөр төлөгчийн данснаас уг мөнгийг гаргуулж шүүхийн харилцах дансанд шилжүүлэхээр банкны зохих хэлтэст уул бичиг баримтыг явуулна”.

---

<sup>12</sup> С.Энхбаяр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд /1926, 1952, 1967, 1994, 2002 он/. УБ., 2005. 207-209 дэх тал

“Төлбөр төлөгчөөс гаргуулах мөнгийг гүйцэтгэх бичиг баримтад заасан түүний данснаас гаргах ба харин тийм заалтгүй бол уг мөнгийг төлбөр төлөгчийн ямар данснаас гаргуулахыг банк биеэ дааж шийдвэрлэнэ”.

“Улсын буюу орон нутгийн төсөвтэй албан байгууллагаас гүйцэтгэх бичиг баримтаар төлбөрийг уг албан байгууллагын төсвөөр санхүүждэг данснаас гаргуулна”.

“Хэрэв төлбөрийг төлөхгүй бол төлбөр авагч нь төлбөр төлөгчийн дээд байгууллага буву санхүүгийн зохих байгууллагад төлбөрийн мөнгийг уг байгууллагын дараачийн ойрын төсөвт оруулахыг хүсэх эрхтэй”.

“Улсын буюу орон нутгийн төсөвтэй албан байгууллагын тусгай ба бусад төсвийн бус хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа энэ бүлэгт заагдсан ерөнхий журмыг баримтална”.

291-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа цалин хөлсөнд төлөх төлбөрөөс бусдыг ээлжит цалин олгоход шаардагдах мөнгөн хөрөнгөөс гаргуулж болохгүй”.

“Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгийн жагсаалтыг хуулиар тогтооно”.

292-р зүйл. “Төлбөр гаргуулбал зохих улс, хоршоолол олон нийтийн байгууллага татан буугдах үед тогтоосон журмаар уг төлбөрийг гаргуулахаар гүйцэтгэх бичиг баримтыг татан буулгах комисст шилжүүлнэ. Гүйцэтгэх бичиг баримтыг шилжүүлсэн тухай төлбөр авагчид мэдэгдэнэ”, “Нэгдэл буюу хоршооллын бусад байгууллага татан буугдахад түүний ямар ч эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно”.

Гучин наймдугаар бүлэг: Гаргуулсан төлбөрийг хувиарлах

293-р зүйл. “Төлбөр төлөгчөөс гаргуулсан мөнгөнөөс тэргүүн ээлжинд тогтоол, шийдвэр гүйцэтгэх явдалтай холбогдон гарсан зарлдлыг төлөөд үлдсэн мөнгийг төлбөр авагчдын шаардлагыг хангахад зориулна. Бүх шаардлагыг хангаад үлдсэнийг төлбөр төлөгчид буцааж өгнө”, “Төлбөр төлөгчөөс улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад гаргуулсан төлбөрийн мөнгийг шүүхийн тогтоол гүйцэтгэгч банкинд байгаа уг байгууллагын тооцооны дансанд хийх ба хэрэв тийм данс байхгүй буюу дугаар нь мэдэгдэхгүй байвал шүүхийн харилцах дансанд хийнэ”.

296-р зүйл. Хоёрдугаар ээлжинд гарах төлбөрүүд

- Улсын ба орон нутгийн чанартай албан татвар ба төсөвт орох албан татварын бус төлбөрийн талаарх шаардлага
- Заавал даатгах улсын даатгалын талаарх шаардлага

297-р зүйл. хуулиар өөр дэс дараалал тогтоогоогүй бол барьцаагаар хангагдаагүй улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын шаардлагыг дөрөвдүгээр ээлжинд хангана”, “Барьцаагаар хангагдаагүй улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын шаардлагыг дөрөвдүгээр ээлжинд хангана”, “Дурьдсан шаардлагуудыг хангасны дараа бусад бүх шаардлагыг хангана”

299-р зүйл. “Улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын банкинд байгаа данснаас төлбөр гаргуулах дэс дараалал нь тусгай хуулиар тодорхойлогдоно”.

### **Зургаа. Шүүхийн байгууламжийн тухай хууль /1978 он/**

БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн 61-63 дугаар зүйлээр: Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг томилох, чөлөөлөх журам, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолыг гүйцэтгэх, шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шаардлагыг заавал биелүүлэх асуудлууд зохицуулагдаж байв. Тухайлбал:

-Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг томилох, ажлаас чөлөөлөх асуудлыг аймаг, хотын болон тусгай шүүхийн даргын тушаалаар шийдвэрлэх;

-Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолын эд хөрөнгө гаргуулах тухай заалтыг тогтоол гүйцэтгэгч биелүүлэх;

-Хууль тогтоомжид заасан нөхцөлд шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь эд хөрөнгийн хохирол барагдуулах, торгууль, төлбөр ноогдуулсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлэх;

-Шүүгчийн тогтоолыг биелүүлэхээр шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг бүх албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэйг тус тус заан тодорхойлжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 237 дугаар тогтоолоор “Шүүхийн тогтоол гүйцэтгэх журмын тухай заавар”-ыг батлан гаргажээ.<sup>2</sup>

Энэ зааврын нийтлэг үндэслэлийн “Тогтоол гүйцэтгэх ажиллагааны үндсэн нөхцөл” гэдэгт:

1. Аймаг, хотын болон тусгай шүүх, хэсэг, район, орон нутгийн хотын ардын шүүхийн тогтоол гүйцэтгэгчид БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 252 дугаар зүйлд заасан шүүхийн болон бусад байгууллагын шийдвэрийг шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар эхлэн гүйцэтгэнэ.

2. БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн 63 дугаар зүйл, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 260 дугаар зүйлд зааснаар шүүхийн тогтоол, шийдвэр, магадлалыг биелүүлэхээр шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг бүх албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй гэж заажээ.

Монгол Улсад ардчилсан хөдөлгөөн өрнөж, ардчилсан Үндсэн хууль 1992 онд батлагдсанаар социалист хэв маягийн хуулиудыг ардчилсан шинжтэй болгон шинэчлэх шаардлага гарсан.

1992 онд батлагдсан Үндсэн хууль нь Монголын Улсын тусгаар тогтнол хийгээд нийгэм төрийн байгууллын ардчилсан үндэс тулгуурыг бататгаж, нийгэмд хүний эзлэх эрх зүйн байдал, төрийн байгууламж, засаг төрийн эрх мэдлийн хуваарилалт, түүний байгууллагын болон нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, Үндсэн хуулийг сахин хамгаалах хяналтыг тогтоосон төрийн гол хууль юм. Энэ Үндсэн хуулиар Монгол Улсын төрийн бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг бататган бэхжүүлэхийн хамт хүний эрх, эрх чөлөө, хуулийг дээдэлсэн, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн хэсэгт хуульчилсан нь шүүхийн хараат бус бие даан ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Дээрх чиг хандлагаас үүдэн шинэ Үндсэн хуулиар хуульчилсан үзэл баримтлалыг бусад хуулиар зөв дэлгэрүүлж, тогтвортой баримтлах нь Монголын нийгэм тогтвортой хөгжих үндэс, гол арга зам тул тус хуульд нийцүүлэн өмнө үйлчилж байсан, 1967 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хуулийг өөрчлөх шаардлага гарч, Монгол Улсын Их Хурал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг 1994 онд баталж гаргасан.

1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь процессын эрх зүйн анхны ардчилсан хууль болохынхоо хувьд өмнөх хуулийн үзэл, баримтлал, бүтцийг хөгжлийн шинэ шатанд гаргаж, иргэний хэргийг шүүхээр хянан хэлэлцэх ажиллагааг үндсээр нь өөрчилсөн гэж хэлж болно. Хуулийн нэрээсээ эхлээд иргэний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хүмүүнлэг, ардчилсан шинжийг агуулсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 191-234 дүгээр зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг заажээ. Энэ хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх шийдвэрүүдэд:

1. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр;

2. Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн торгох, эд хөрөнгө хураах ял болон хөрөнгө гаргуулах заалт;

3. Захиргааны зөрчил гаргасан этгээдээс торгууль, төлбөр гаргуулах талаар гарсан шийтгэвэр;

4. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар биелүүлбэл зохих гадаад улсын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, холбогдох баримт бичиг;

5. Арбитрын шийдвэр хамаарагдахаар заасан байна.

### **Долоо. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль /1994 он/**

Улсын Их Хурлаас 1994 оны тавдугаар сарын 10-ны өдөр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль” батлан гаргав.

Шинэ хууль нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалтын анхны бие даасан хууль байснаар өөрийн онцлогтой. Хууль гарах болсон шалтгааныг Нэгд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа олон арван эрхийн актаар зохицуулагдаж ирснийг тусгайлан хуульчлах шаардлагатай болсон, Хоёрт, Шийдвэр гүйцэтгэлийн албаны цар хүрээ өргөжин тэлэхийн хирээр ажилтнуудын эрх, үүргийг тодруулах, тэдний ажиллах эрхийн баталгааг төрийн тусгай албаны ажилтныхтай ойртуулан авч үзэх хэрэгтэй болсон, Гуравт, Шийдвэр гүйцэтгэлийн албыг харьцангуй бие даалгах нийгмийн шаардлага тавигдсан зэрэгтэй холбон үзэж болно.

Хуулийн зорилтыг “Шийдвэр гүйцэтгэлийн албаны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, ажилтны эрх, үүргийг тодорхойлох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлжээ. Хуулийн бүтэц нь: 1-р бүлэг: Нийтлэг үндэслэл, 2-р бүлэг: Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны бүрэн эрх, үйл ажиллагааны баталгаа, 3-р бүлэг: Бусад зүйл гэсэн бүлгүүд, 16 зүйлээс бүрдэж байв.

### **Найм. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль /1996 он/**

1996 онд Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль батлагдан гарснаар Монгол Улсад бүх төрлийн шүүхийн шийдвэрийг нэгдсэн байдлаар зохицуулах болсон байна.

Уг хуульд шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагааны талаар заахдаа:

Төлбөр төлөгч энэ хуульд заасан /45 хоног/ заасан хугацаанд шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй буюу биелүүлэхээс татгалзвал шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг албадан биелүүлэхээр дараахь арга хэмжээ авна. Үүнд:

1/ төлбөр төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах;

2/ төлбөр төлөгчийн цалин, бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

3/ төлбөр төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах;

4/ шийдвэрт заасан тодорхой зүйлийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх;

5/ хуульд заасан бусад арга хэмжээ.

Төлбөр төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааны талаар:

Төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор түүний өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийнэ. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, битүүмжлэх, барьцаалах, хураах явцад түүний биедээ буюу ямар нэг газар, бусад этгээдэд нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор тэдний биед болон тухайн газарт нэгжлэг хийж болно. Шаардлагатай гэж үзвэл шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн банкин дахь дансны зарлагын хөдөлгөөнийг тухайн эд хөрөнгөөс төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний эд хөрөнгийг битүүмжлэх буюу барьцаалж, төлбөр төлөх хугацаагаар тогтоож өгнө. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийж, түүний хөрөнгийн хэмжээг тогтоосны дараа тухайн банкинд мэдэгдэл өгөх замаар төлбөр төлөх хүртэл хугацаагаар зогсоож болно.

Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн буюу барьцаалсан эд хөрөнгийг хураана. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн, эсхүл битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг уг хугацаа дуусахаас өмнө чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол эд хөрөнгийг буцааж олгоно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааг явуулахад уг хэрэгт хувийн сонирхолгүй, эрх зүйн бүрэн чадамжтай, хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулна. Хөндлөнгийн гэрч нь уг ажиллагааны явц, агуулгыг баталж өгөх үүрэгтэй. Төлбөр төлөгч эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны зохих байгууллагын төлөөлөгчийг байлцуулна. Төлбөр төлөгч нь хуулийн этгээд байвал уг байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг



битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааны явцад тэмдэглэл хөтөлж, байлцсан этгээдүүдээр гарын үсэг зуруулна. Тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг шийдвэр гүйцэтгэгч тэдэнд тайлбарлаж өгнө.

*Эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагааны талаар:*

Төлбөр төлөгч иргэний хувийн өмчийн эд хөрөнгөөс гаргуулна. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн төлбөрийг түүний банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгө, түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгөөс гаргуулна. Эд хөрөнгө нь төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс гаргуулна.

*Эд хөрөнгийг үнэлэх талаар:*

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Тухайн эд хөрөнгийг үнэлэхэд хүндрэл учирсан, гүйцэтгэгчээс тогтоосон үнэлгээг төлбөр төлөгч зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шинжээч томилж болно. Үнийн талаар гарсан маргаан, гомдлыг шүүх шийдвэрлэнэ.

*Эд хөрөнгийг хадгалах талаар:*

1. Шийдвэрт гүйцэтгэгч нь битүүмжилсэн, барьцаалсан, хураасан эд хөрөнгийг төлбөр төлөгч болон бусад этгээдэд хадгалуулж болно.
2. Хадгалагч эд хөрөнгийг хэвийн байдлаар арчлан хадгалах үүрэгтэй.
3. Эд хөрөнгө хадгалагч нь төлбөр төлөгч буюу түүний гэр бүлийн гишүүн, биш бол хадгалсны хөлсийг тохиролцсоны дагуу авна. Мал, амьтан хадгалуулсны хөлсийг тэдгээрт зарцуулсан зардлыг тооцон авна.
4. Төлбөр төлөгчөөс хураасан үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг банкинд хадгалуулна.

*Эд хөрөнгийг худалдан борлуулах талаар:*

-Хураагдсан эд хөрөнгийг хураагдсан эд хөрөнгө худалдах дэлгүүр болон үнэ хаялцуулах, зуучлах худалдаагаар худалдана. Шаардлагатай тохиолдолд орон нутгийн алслагдсан байршлаас хамаарч тасаг, хэсгийн даргын зөвшөөрлөөр шийдвэр гүйцэтгэгч нь үл хөдлөх эд хөрөнгөөс бусад хураагдсан эд хөрөнгийг өөрөө шууд худалдаж болно. Үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валют, үнэт цаасыг хууль тогтоомжид заасан журмын дагуу худалдана. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйлс, химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрөлтэйгээр олж авах зүйлийг холбогдох байгууллагад худалдах

буюу шүүхийн шийдвэрийн дагуу шилжүүлнэ.

Эд хөрөнгийг, түүнийг хураахад тогтоосон үнийг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж худалдана. Эд хөрөнгийг хураан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг нэн даруй худалдана. Энэ хугацаанд худалдаагүй эд хөрөнгийг төлбөр авагчид төлбөртөө тооцон авахыг санал болгох буюу төлбөр төлөгчид мэдэгдэн үнэ хямдруулан худалдаж болно. Төлбөр авагч авахаас татгалзсан буюу худалдаагүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид буцаан өгнө гэх зэргээр тухайн үеийн хууль тогтоомжуудад шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагааны талаар тусгасан байна.

Төр, эрх зүйн хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцүүлэн шүүхийг шинэчлэн хөгжүүлэх, шударга ёс, хүний эрхийн баталгаа болгон төлөвшүүлэх зорилгоор Улсын Их Хурал 2000 онд “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г баталжээ. Уг төлөвлөгөө нь шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, хараат бус байх, хариуцлага хүлээдэг байх, мэдрэмжтэй байх, шударга байх, хүртээмжтэй байх, бүтээмжтэй байх гэсэн 6 суурь үнэлэхүйг үндэс болгожээ.

### **Ес. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2002 он/**

Хууль сахиулах байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чирэгдэл, дамжлага багатай бүтэц бий болгох, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдуулан хуулийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг бүхэлд нь өөрчлөх явцад 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Иргэний, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль мөн шинэчлэгдсэн байна.

Тус хуулийн долдугаар бүлэг.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах онцлогийг доорхи байдлаар тусгажээ.

57 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах

57.1. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч тухайн банк, банкны бус санхүүгийн байгууллагад хүргүүлэх бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж, 3 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ. Нэхэмжлэлийн шаардлага хангах хэмжээний мөнгөн хөрөнгө төлбөр төлөгчийн дансанд байхгүйн улмаас

мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй талаар мэдэгдэнэ.

57.2. Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэмж тусгахыг шаардана.

57.3. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх явцад бэлнээр хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө илэрвэл түүнийг хураан авна.

57.4. Төлбөрт гаргуулсан бэлэн мөнгийг тэр өдөрт нь төлбөрийн шаардлагын хэмжээгээр, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тооцон авч төлбөр авагчид шилжүүлнэ.

57.5. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бэлнээр хадгалагдаж байгаа буюу банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан журмаар битүүмжлэх арга хэмжээ авч болно.

57.6. Төлбөр төлөгч нь банк байх тохиолдолд тухайн арилжааны банкны Монголбанк дахь харилцах данснаас хасалт хийх буюу төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.

58 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

58.1. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс хассан буюу гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулна. Энэ тохиолдолд тухайн эд хөрөнгө хаана, юунд ашиглагдаж байгаа нь үл хамаарна.

59 дүгээр зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүмжлэх дараалал

59.1. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг дараахь дарааллаар битүүмжилнэ:

59.1.1. үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй эд хөрөнгө /үнэт цаас, хуулийн этгээдийн хадгаламжинд буюу бусад тооцоонд буй мөнгөн хөрөнгө, валют болон түүнтэй адилтгах бусад хөрөнгө/;

59.1.2. бэлэн бүтээгдэхүүн, бусад материал, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй материал;

59.1.3. үл хөдлөх эд хөрөнгө, түүхий эд материал, үйлдвэрлэлийн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэг материал;

59.1.5. тусгай зөвшөөрөл.

60 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах

60.1. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн мөнгөн болон бусад эд хөрөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

60.2. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.

61 дүгээр зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх

61.1. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу битүүмжилснээс хойш 3 хоногийн дотор уг байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн тухай мэдэгдлийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт хүргүүлнэ.

61.2. Мэдэгдэлд уг үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, тоо хэмжээ, байршил, төлбөр авагчийн шаардсан мөнгөн дүнгийн тухай мэдээг хавсаргана.

61.3. Мэдэгдлийн хуулбарыг татварын байгууллагад явуулна.

61.4. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийг хийх эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 61.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан бол тухайн битүүмжлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг тодорхойлсон лавлагааг 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх байгууллагад өгнө.

62 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээд өөрчлөгдөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах журам

62.1. Төлбөр төлөгч-хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

63 дугаар зүйл. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах

63.1. Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагааг нь зогсоох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

63.2. Татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль болон Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ.

63.3. Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэн төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.

2017 онд Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчил, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн шинэчлэлттэй уялдан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 5 хэсэг, 27 бүлэг, 302 зүйлтэйгээр баталж 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөж байна.

## 1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг **хуулийн этгээд** гэнэ.” гэж тодорхойлжээ. Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага” байхаар заажээ. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийн онцлог бүхий бие даасан субъект юм.

Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг “хуулийн этгээд” гэж ойлгохоор заасан.

Хуулийн этгээдийн үйл ажиллагааг Иргэний хууль болон бусад хуулиар, тухайлбал Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нөхөрлөл компаний хууль, Хоршооны хууль, Аж ахуй нэгжийн хууль, Банкны тухай, Үнэт цаасны тухай гэх мэт бусад хуулиудаар зохицуулдаг.

Хуулийн этгээд нь дараах онцлог шинжтэй байна. Энэ нь:

- Тусгайлсан хөрөнгөтэй байх /үүсгэн байгуулагчийн буюу гишүүдийн хөрөнгөнөөс тусгайлсан байх/
- Эд хөрөнгийн бие даасан хариуцлага хүлээдэг
- Өөрийн оноосон нэртэй байж, түүгээр иргэний эрх зүйн харилцаанд оролцож эрх олж, үүрэг хүлээдэг
- Оршин байх хаяг, бүртгэлийн гэрчилгээтэй, тамга, тэмдэг банкинд харилцах данстай, үйлдвэрлэл, үйлчилгээ, ажил үүргийн мөрийн хөтөлбөр болсон бичиг баримттай байх<sup>13</sup>
- Нэгдмэл зохион байгуулалттай байх /өөрийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжтэй байх/
- Шүүх, арбитраж өөрийн нэрээр оролцоно /нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд байна.

Аливаа хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, мөн татан буугдах бөгөөд улсын бүртгэлээс хасагдсанаар эрх зүйн чадвар нь дуусгавар

<sup>13</sup> Т.Мөнхжаргал. Монгол Улсын иргэний эрх зүй. УБ., 2000. 92-94 тал

болно. Зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр явуулах бол ийнхүү зөвшөөрөл авснаар чадвар үүсч, зөвшөөрөл хүчингүй болсноор чадамж нь дуусгавар болдог байна.

Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг ерөнхий ба тусгай гэж ангилна. Хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагаа явуулах /ИЭЗ-н бүхий л эрх, үүрэгтэй байх/, уг үйл ажиллагаанаас бий болох эрхийг эдэлж, үүрэг хүлээх чадварыг ерөнхий чадвар гэх бол үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн тусгай чадвартай, энэ нь гагцхүү хууль буюу дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах чадвартай гэсэн үг бөгөөд үүнийг тусгай чадвар гэнэ. Хуулийн этгээд өөрийнхөө үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээж, хариуцлага хүлээх чадварыг хуулийн этгээдийн чадамж гэнэ. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар, чадамж зэрэг үүсч, зэрэг дуусгавар болдог. Хуулийн этгээдэд эрх зүйн бүрэн чадамжтай иргэд нэгддэг.

Жишээ нь: Нийтийн зориулалттай эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, тухайн орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий, хуулийн этгээдийн эрхгүй, заавал гишүүнчлэлтэй холбоо буюу СӨХолбоог байгуулахад эрх бүхий байгууллагад бүртгүүлж, шийдвэрийг хүлээн авснаар эрх зүйн чадамж нь үүсдэг. Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх, тусгай зөвшөөрөл нь авсан өдрөөс үүснэ.

Мөн Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох”-оор заасан.

### **Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах**

Хуулийн этгээдийг иргэд, бусад хуулийн этгээд, төрөөс дангаараа буюу хамтран байгуулж болох ба ямар төрөл, хэлбэрийн хуулийн этгээд байгуулж байгаагаас шалтгаалан байгуулах журам нь ялгаатай байдаг. Түүнчлэн хуулийн этгээд өөрийн нэр, оршин байх нэг газар буюу хууль ёсны хаягтай байна.

Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцох бөгөөд удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

Өмчлөгч нь аль ч төрлийн хуулийн этгээдийг байгуулах эрхтэй ба хуульд заасан журам горимын дагуу үүсгэн байгуулна. Хуулийн этгээдийг дараахь аргаар байгуулна. Үүнд:

- Хуульд зааснаар тусгай зөвшөөрлөөр /эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх/
- Хуульд зааснаар эрх бүхий байгууллагын шийдвэрээр /төрийн байгууллага/
- Сайн дурын үндсэн дээр /бүртгүүлэх журмаар, үүсгэн байгуулах гэрээний үндсэн дээр/

Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ. Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зармыг нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг хуулийн этгээдийн салбар гэх бөгөөд хуулийн этгээд нь хууль ёсны нэг оршин байх хаягтай байна. Түүнчлэн хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулах бөгөөд эдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй, үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулна.

### **Хуулийн этгээдийн төрөл, ангилал**

Дэлхийн улс орнуудын хувьд хуулийн этгээдийн олон төрлүүд байдаг бөгөөд мөн тэдгээрийн эрх зүйн тогтолцоо, практик, заншил зэргийн улмаас хууль тогтоомждоо янз бүрээр нэршиж иржээ. Хамгийн түгээмэл төрөл, тэдгээрийн нэршлүүдийг авч үзвэл: хуулийн этгээд-legal entity: бизнесийн байгууллага-business entity, компани-company, корпораци-corporate, нөхөрлөл-partnership, холбоо-association, хоршоо-cooperative, сан-foundation гэх мэт. Хуулийн этгээдийг ерөнхийд нь: Хувийн эрх зүйн хуулийн этгээд ба нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилдаг. Хувийн зорилгыг хэрэгжүүлэхээр нэгдсэн, хувийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан зохион байгуулагддаг.

Дэлхийн бусад улс орнуудад хуулийн этгээдийн олон янзын нэршлүүдийг хэрэглэдэг бөгөөд заримаас нь дурдвал: нээлттэй хувьцаат компани - public corporation, company, хамтарсан үйлдвэр, хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газар - joint venture, хувийн хязгаарлагдмал



компани - private limited company, төрийн бус байгууллага - non-governmental organization, сангууд - foundations, donation гэх мэт.

Хуулийн этгээд нь удирдлагын хувьд төвлөрсөн удирдлагатай /захирал, ерөнхийлөгч гэх мэт/, хамтын удирдлагатай /тэргүүлэгчид, зөвлөл, удирдах зөвлөл гэх мэт/ байна.

Хуулийн этгээдийг дараах байдлаар ангилж болно. Энэ нь:

- Үйл ажиллагааны чиглэлээр
- Өмчийн төрөл, хэлбэрээр
- Эрх зүйн зохицуулалтаар
- Зохион байгуулалтын шинжээр
- Үүсгэн байгуулагдах үндэслэлээр
- Эрх зүйн байдлаар
- Өмчлөгч буюу үүсгэн байгуулагчийн эрхийн байдлаар зэрэг болно.

#### Зорилго чиглэлээр нь

• Ашгийн төлөө хуулийн этгээд: Үйл ажиллагааныхаа үр дүнд ашиг олох, хуримтлал бий болгох зорилготой байдаг. Жишээ нь компани, нөхөрлөл, ОНҮГ, УУГазар хамаарна.

• Ашгийн төлөө бус хуулийн этгээд: Хууль, өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулж, төсөвлөсөн хөрөнгө, гишүүдийн татвар, хандивыг захиран зарцуулна. Жишээ нь: төрийн болон төрийн бус байгууллага, шашны байгууллага, сан хамаарна.

#### Өмчийн хэлбэрээр нь

- Нийтийн өмчийн /төрийн, орон нутгийн, шашны/
- Хувийн өмчийн /хувь хүний, дундын/
- Холимог /нийтийн өмчийн холимог, нийтийн болон хувийн өмчийн холимог/

#### Үйл ажиллагааны шинжээр нь

- Энгийн
- Нийлмэл /хуулийн этгээдүүдийн нэгдэл/

#### Үүсгэн байгуулагдах үндэслэлээр нь

- Сайн дурын үндсэн дээр /нөхөрлөл, компани, хоршоо, ТББ гэх мэт/
- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр /төрийн байгууллага, зарим ТББ, УУГ, ОНӨҮГ/

### Эрх зүйн байдлаар нь

- Үндэсний
- Гадаадын
- Гадаадын хөрөнгө оруулалтта буюу холимог

### Өмчлөгч буюу үүсгэн байгуулагчийн эрхийн байдлаар нь

• Тусгайлсан эд хөрөнгийн хувьд түүний өмчлөгч буюу үүсгэн байгуулагч эд хөрөнгийн эрхээ хадгалдаг /компани, нөхөрлөл, хоршоо, өмчлөгчөөс санхүүждэг бусад хуулийн этгээд/

• Тусгайлсан эд хөрөнгийн хувьд түүний өмчлөгч буюу үүсгэн байгуулагч эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй /олон нийтийн байгууллага, төрийн байгууллага/

### Зохион байгуулалтын шинжээр нь

• Нөхөрлөл /гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хуувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ. Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно/

• Хоршоо /эдийн засгийн болон нийгэм соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд нэгдсэн хамтын удирдлага хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ/

• Компани /хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагдсан өөрийн тусгайлсан хөрөнгөтэй ашгийн төлөө зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ/

• Сан /нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай нэгдмэд зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг хэлнэ.

• Холбоо /нэгдмэл тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг хэлнэ/

• Төрийн бус байгууллага /иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага/

- Бусад хуулийн этгээд

## **Хуулийн этгээд үйл ажиллагаагаа зогсоох үндэслэл, арга хэлбэр**

Хуулийн этгээд албадлагаар эсвэл сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа зогсоож болно. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайлбал шүүх, бүртгэлийн байгууллагын шаардлагаар албадлагаар үйл ажиллагаагаа зогсоох бол өмчлөгч, түүнээс эрх олгосон эсхүл үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаагаа зогсоосон бол сайн дурын үндсэн дээр гэж үзнэ.

Хуулийн этгээд эрхээ дуусгавар болгож татан буулгах, эрхээ залгамжилж өөрчлөн байгуулах замаар үйл ажиллагаагаа зогсоож болно.

**Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах** дараах хэлбэрүүд байна. Үүнд:

- Нийлүүлэх  $A+B=B$  /хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бөий болсон хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нийлүүлэх гэнэ/

- Нэтгэх  $A+B=B$  /хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэтгэх гэнэ/

- Хуваах  $B:2=A, B$  /хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуудийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ/

- Тусгаарлах  $A-B=A, B$  /хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ/

- Өөрчлөх  $A=A1$  /хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно/

### **Хуулийн этгээдийг дараах үндэслэлээр татан буулгадаг.**

- Өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан.

- Дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

- Үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан.

- Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан.

- Хуульд заасан бусад үндэслэл

Хэрэв хуулийн этгээд татан буугдаж байгаа бол дараах шаардлагуудыг дарааллын дагуу биелүүлэх үүрэгтэй. Энэ нь:

1. Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөрийг барагдуулах

2. Хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээд гүйцэтгэсэн ажиллагааны зардлыг барагдуулах

3. Дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлагыг биелүүлэх

4. Хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөрийг барагдуулах

5. Хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгийг олгох

6. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад төлөх хөдөлмөрийн хөлсийг олгох

7. Хууль тогтоомжид заасан бусад этгээдэй хийх тооцоог дуусгах зэрэг болно.

Хуулийн этгээдэд холбогдох шаардлагаг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтлана.

### **Хуулийн этгээдийн дампуурал**

Зарим нэг хуулийн этгээд харилцагч нартаа төлбөл зохих өр төлбөрөө барагдуулж чадахгүй, өөрөөр хэлбэл эдийн засгийн хувьд бие даан үргэлжлэн оршин тогтнох нөхцөлгүй болдог. Хуулийн этгээдийн дампуурлыг сайн дурын ба сайн дурын бус гэж ангилна. Сайн дурын дампуурах гэдэг нь төлбөрийн чадваргүй болсон учир дампуурсанд тооцохыг хүсч тухай хуулийн этгээд шүүх болон харилцагч талдаа өөрөө мэдэгдэхийг хэлэх бол сайн дурын бус дампуурал гэдэг нь тухайн хуулийн этгээд төлбөрийн чадваргүй учир үүргээ гүйцэтгэхээс татгалзсан гэж үзэж, түүнийг дампуурсанд тооцуулахаар харилцагч нар нь шүүхэд нэхэмжлэл гаргана гэсэн үг юм. Дампуурах хэргийн хариуцагч нь нөхөрлөл, хоршоо, компани, ТӨҮГазар, ОНӨҮГазар байх ба тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компани хамаардаггүй байна.

Хуулийн этгээдийн дампуурлыг субъектив хандлагаар нь тодорхой этгээдээс шалтгаалахгүйгээр урьдчилан тооцоолох боломжгүй буюу болгоомжгүй байдлын үр дүнд үүсэх дампуурал болон хуурамч дампуурал гэж авч үзэх боломжтой.

1. Хуулийн этгээдээс шалтгаалахгүйгээр урьдчилан тооцоолох боломжгүй буюу азгүй тохиолдлоос үүсэх дампууралд гадаад хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд: эдийн засгийн талаасаа эдийн засгийн хямрал, инфляци, бараа материал, үйлчилгээний үнийн өсөлт, харилцагчийн төлбөрийн чадваргүй байдал, өндөр татвар, улс төрийн талаасаа улс төрийн тогтворгүй байдал, гадаад бодлого, экспорт, импортын өөрчлөлт, эрх зүйн таагүй орчин, нийгэм талаасаа хүн амын өсөлт, ард түмний аж байдлын түвшин, хэрэглээний соёл, худалдан авах чадвар, мөн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл байх боломжтой.

2. Хуулийн этгээд өөрөө эрсдэлтэй үйл ажиллагаа явуулж болгоомжгүй хандсанаар үүсэх дампууралд дотоод хүчин зүйл буюу хөрөнгө оруулалтын үр ашиггүй бодлого, үйлдвэрлэл, худалдааны дүнд бий болсон хөрөнгийн хомсдол, техник, технологийн доогуур үзүүлэлт, үйлдвэрлэлийн бууралт, бүтээгдэхүүний нөөцийн хэт их үлдэгдэл зэрэг нөлөөлнө.

3. Хуурамч дампуурал нь өөрийн хөрөнгөө нуун дарагдуулах зорилгоор зээлдүүлэгчийн болон бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхээс зайлснийсэн санаатай хууль бус үйлдэл юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох буюу зохиомлоор дампуурсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байдаг.

### **Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт:**

Нэг. Иргэний хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

Дөрөвдүгээр бүлэг: Нэгдүгээр дэд бүлэг

25 дугаар зүйл. Хуулийн этгээд

25.1 Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

25.2. Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.

25.3 Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.

25.4 Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална.

25.5 Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Дөрөвдүгээр бүлэг: Хоёрдугаар дэд бүлэг

33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл

33.1. Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.

33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.

34 дүгээр зүйл. Компани

34.1. Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ.

34.2. Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

35 дугаар зүйл. Нөхөрлөл

35.1. Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

35.2. Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо

36.1. Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.

36.2 Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.

36.3. Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

36.4 Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

36.5 Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.

36.6 Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө

Дөчин дөрөвдүгээр бүлэг: Хоёрдугаар дэд бүлэг

451 дүгээр зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ

451.1 Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.

451.2. Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ.

451.3 Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

498.2 Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм бүрүүтэй үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.

503.2. 7-14 хүртэлх насны иргэн сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгана.

509.2 Гэм хор учруулсны төлбөр төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон бөгөөд түүний эрх залгамжлагч байхгүй бол хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдуулан уг хуулийн этгээдээс төлбөл зохих төлбөрт шаардагдах хэмжээний хөрөнгийг энэ хуулийн 32.5-д заасны дагуу тэргүүн ээлжинд хуримтлуулж, тогтоосон хугацаанд хохирогчид олгож байхын тулд нийгэм хангамжийн байгууллагад шилжүүлнэ.

Тавин хоёрдугаар бүлэг:

513 дугаар зүйл. Гэм хор учруулснаас төлсөн төлбөрийг буцаан нэхэмжлэх шаардлага

513.1. Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн буюу бусад хуулийн этгээд нь гэм буруутай иргэн болон хуулийн этгээдээс төлбөр, тусламжаа буцаан нэхэмжлэх эрхтэй.

513.2. Гэм хорыг хариуцвал зохих иргэн, хуулийн этгээд нь буцаан нэхэмжилсэн шаардлагын дагуу уг хуулийн этгээдийг хохиролгүй болгох үүрэгтэй.

513.3. Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээ нь энэ хуулийн 507 дугаар зүйлд заасан үндэслэлээр багасвал буцаан нэхэмжлэх шаардлагын дагуу хүлээх хариуцлагын хэмжээ нэгэн адил багасна.

Жаран нэгдүгээр бүлэг:

544 дүгээр зүйл. Гадаад улсын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар

544.1. Гадаад улсын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг харьяалсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн зөвшөөрнө.

544.2. Гадаад улсын хуулийн этгээд хэлцэл хийхдээ Монгол Улсын хуулиар тогтоогоогүй хязгаарлалтыг хэрэглэж болохгүй.

549.6. Гадаад улсын хуулийн этгээд буюу иргэн оролцсон хамтарсан үйлдвэр байгуулах тухай гэрээнд тухайн хамтарсан үйлдвэрийн оршин байгаа улсын хуулийг хэрэглэнэ

Хоёр. Нөхөрлөлийн тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

17 дугаар зүйл. Харилцагчдын үүрэг

1.Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа нөхөрлөлтэй харилцагчид татан буугдах гэж байгааг нийтэд мэдээлснээс хойш 3 сарын дотор төлбөр тооцоогоо хийх үүрэгтэй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд харилцагч тал төлбөр, тооцоогоо хийгээгүй бол нэхэмжлэл хангуулах эрхээ алдана.

25 дугаар зүйл. Эд хөрөнгө хуваах



1.Нөхөрлөл татан буугдсаны дараа гишүүд нөхөрлөлд оруулсан хөрөнгөө буцаан авах эрхтэй. Гэхдээ харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл нөхөрлөлийн хөрөнгийг гишүүдэд хувааж болохгүй.

2.Нөхөрлөлийн төлбөрийг бүрэн барагдуулсны дараа гишүүдийн оруулсан хөрөнгийг буцаан олгож, үлдэх эд хөрөнгийг гишүүдэд оруулсан хөрөнгөтэй нь хувь тэнцүү хуваана. Эд хөрөнгийн хэлбэрээр оруулсан хөрөнгийг биет байдлаар нь буцаан олгох боломжгүй бол гэрээнд заасан үнэлгээ, нөхцөлийг баримтална.

3.Нөхөрлөлийн эд хөрөнгө төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол гэрээнд гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байхаар зааснаас бусад нөхцөлд гишүүдээс оруулсан хөрөнгөтэй хувь тэнцүү хэмжээгээр тэдгээрийн хувийн өмчийн эд хөрөнгөөс гаргуулж, харилцагчдын төлбөрийг бүрэн барагдуулна.

Гурав. Компанийн тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

9 дүгээр зүйл. Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага

9.5. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

13 дугаар зүйл. Шинээр компани үүсгэн байгуулах

13.5.2. захиалсан нийт хувьцааны төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 өдрийн дотор хийх.

13.6. Тодорхой шалтгаанаар компани байгуулагдаагүй бол компани үүсгэн байгуулах хурал товлосон өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг буцаан олгох үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ.

27 дугаар зүйл. Компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам

27.1. Компанийг татан буулгах үед түүний өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө.

27.4. Компанийг татан буулгах тухай шийдвэр гаргах үед тухайн компани нь ямар нэгэн өр төлбөргүй бол уг компанийг татан буулгах тухай мэдэгдлийг нийтэд мэдээлэхгүйгээр татан буулгаж болно.

27.10. Татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн зээлдүүлэгчдийн өр төлбөрийг татан буулгах балансыг баталсан өдрөөс эхлэн тус балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дарааллын дагуу барагдуулна.

27.11. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсан тухай мэдэгдлийг компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээдэд явуулснаас хойш 30 хоногийн дотор эцсийн баланс гаргана.

28 дугаар зүйл. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хуваарилах

28.1. Татан буулгах комисс нь зээлдүүлэгч болон бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг дараах дарааллын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна:

28.1.1 давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг болон давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ, түүнчлэн энэ хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу эргүүлэн худалдаж авах давуу эрхийн хувьцааны төлбөр;

28.1.2. энэ хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу эргүүлэн худалдаж авах энгийн хувьцааны төлбөр.

44 дүгээр зүйл. Үнэт цаасны төлбөр

44.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийж болно.

44.2. Компани үүсгэн байгуулах үед гаргасан хувьцааны төлбөрийг компанийг улсын бүртгэлд бүртгэхээс өмнө төлнө.

44.3. Нэмж гаргах үнэт цаасны төлбөрийг тухайн үнэт цаасыг худалдан авах үед бүрэн төлнө.

44.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны төлбөрийг дараах тохиолдолд мөнгөн бус хэлбэрээр хийж болно:

44.4.1 Үүсгэн байгуулах үед үүсгэн байгуулагчид хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийхийг энэ хуулийн 13.3-т заасан үүсгэн байгуулах гэрээнд зөвшөөрсөн бол;

44.4.2. Нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болохоор эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан бол.

44.5. Үүсгэн байгуулах үед хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж байгаа бол түүний үнэлгээг үүсгэн байгуулах хурлаар санал нэгтэй батална.

44.6. Үнэт цаасыг нэмж гаргаж байгаа үед түүний төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх үнэлгээг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ эцэслэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Хоршооны тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

3 дугаар зүйл. Хоршоо, түүний үйл ажиллагааны төрөл

3.1. Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

3.2. Хоршоод аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран эрхлэх зорилгоор бусад хоршоо болон хуулийн этгээдтэй хамтран дундын хоршоо байгуулж болно. Дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байна.

44 дүгээр зүйл. Татан буулгах явцад гишүүдийн хоршоонд нийлүүлэх хувь хөрөнгийг нэмэгдүүлэх

44.1. Хоршоог татан буулгах явцад түүний нийт хөрөнгө нь өр төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол дутаж буй хэсгийг хоршоонд нийлүүлэх хувь хөрөнгөө дээд хэмжээнд нь хүртэл төлөөгүй гишүүдэд хувь оногдуулах замаар гаргуулж нөхөн төлнө.

46 дугаар зүйл. Хөрөнгө хуваарилахыг хориглох хугацаа

46.1. Хоршооны өр төлбөртэй холбоотой нэхэмжлэлийг Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн барагдуулна.

46.2. Хоршоонд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд ийнхүү нэхэмжлэл гаргах боломжгүй нөхцөлд байгаа бол түүнд төлбөл зохих төлбөрийг нэгэн адил төлнө.

46.3. Төлбөрийн талаар маргаантай бол тухайн этгээдэд ногдох хэсгийг тусгаарласны дараа үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваана.

Тав. Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж

2.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

19 дүгээр зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэл

19.8. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн өөрийн хадгаламж, зээлийн хоршоонд төлөх өр төлбөр, үүргийн гүйцэтгэлийг биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол түүний хадгалуулсан хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийн барьцаа болгож, үүргийн гүйцэтгэлийн хэмжээгээр аливаа гүйлгээ хийхийг хориглоно.

27 дугаар зүйл. Гишүүний хүлээх хариуцлага

27.3. Хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс олсон ашиг, орлого, эд хөрөнгөө бусдын өмчлөлд буюу хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдвол тэр хэмжээгээр тухайн эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

Зургаа. Банкны тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банк болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж

2.1 Банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг

хангах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

73 дугаар зүйл. Төлбөр барагдуулах дараалал

73.1. Төлбөрийн нэхэмжлэлийн шаардлагыг банкны эрх хүлээн авагч банкны хөрөнгийг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, төлөгдсөн орлогоос хангахад дараах дарааллыг баримтална:

73.1.1. бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн банкнаас гаргуулж байсан төлбөр;

73.1.2. банкны эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтны хуульд заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс;

73.1.3. банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал;

73.1.4. иргэний Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан нөхөн төлбөр төлөх даатгагдсан хадгаламжаас бусад мөнгөн хадгаламжийн төлбөр;

73.1.5. иргэний Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан нөхөн төлбөр төлөх даатгагдсан хадгаламжаас бусад харилцах дансны төлбөр;

73.1.6. хуулийн этгээдийн Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан нөхөн төлбөр төлөх даатгагдсан хадгаламжаас бусад мөнгөн хадгаламжийн төлбөр;

73.1.7. хуулийн этгээдийн Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан нөхөн төлбөр төлөх даатгагдсан хадгаламжаас бусад харилцах дансны төлбөр;

73.1.8. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгагдсан хадгаламж эзэмшигчийн шаардах эрхийг шилжүүлэн авсан Хадгаламжийн даатгалын корпорацийн шаардлага;

73.1.9. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3-т заасан хадгаламжийн даатгалд хамаарахгүй хадгаламжийн төлбөр;

73.1.10. Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;

73.1.11. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө;

73.1.12. Монголбанкны шаардах эрх бүхий төлбөрийн шаардлага;

73.1.13. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7.2.4, 7.2.5, 7.2.6-д заасан хадгаламжийн даатгалд хамаарахгүй хадгаламжийн төлбөр;

73.1.14. зээл, өрийн хэрэгслийн гэрээнд банкны бусад өр төлбөр, хоёрдогч өглөгийн дарааллаас өмнө байхаар заасан зээл, түүнтэй адилтгах өр төлбөр;

73.1.15. бусад өр төлбөр;

73.1.16. хоёрдогч өглөг.

73.2. Банкны эрх хүлээн авагч нь төлбөр барагдуулахдаа гэрээний дагуу тухайн банкны өрийг түүнд ногдох актив хөрөнгийн хамт бүхэлд нь буюу хэсэгчлэн энэ хуулийн 73.1-д заасан дарааллын дагуу бусдад шилжүүлж болно.

73.3. Банкны хөрөнгийг худалдан борлуулсан орлого нь нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол дарааллын эхний төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

73.4. Нэг дараалалд орсон хэд хэдэн төлбөрийг нэгэн зэрэг барагдуулах боломжгүй бол тухайн төлбөр бүрийн хэмжээнд хувь тэнцүүлэх замаар нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

73.5. Энэ хуулийн 73.1-д заасан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа үлдэх хөрөнгийг тухайн банкны хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эрхийн дагуу хуваарилна.

Долоо.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар туссан байдал:

Нэгдүгээр бүлэг:

4.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана

Хоёрдугаар бүлэг:

13.2. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.

14.2. Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргана.

15.4. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

16.2. Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл хариуцагчийн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргаж болно.

30.1. Маргаантай эрх зүйн харилцааны зохигчийн аль нэг нь уг эрх зүйн маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн/ бол шүүх тэрхүү зохигчийг сонирхогч этгээд буюу эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлан авах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гүйцэтгэгдэж болно.

Дөрөвдүгээр бүлэг:

46.1. Иргэн, хуулийн этгээд шүүхээс шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг шүүхээс заасан хугацаанд гаргаж өгнө. Хэрэв иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргаж өгөх боломжгүй бол энэ тухайгаа шаардсан шүүхэд мэдэгдэнэ.

46.3. Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай, төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр холбогдох иргэн, хуулийн этгээд түүний албан тушаалтан гаргаж өгөх үүрэгтэй

Зургаадугаар бүлэг:

62.1.2. Нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;

62.1.3. Хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;

65.1.10. зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй

#### НАЙМДУГААР БҮЛЭГ:

80.1.1 Зохиогч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага буюу үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой байвал;

#### АРАВДУГААР БҮЛЭГ:

134.2. Энэ хуулийн 133 дугаар зүйлд заасан хэргийг шүүх хүсэлт гаргасан этгээд, холбогдох хуулийн этгээд, иргэнд мэдэгдсэний үндсэн дээр тэдний хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэнэ

134.3. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцож болно.

135.1. Иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ.

136.1. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлтээ иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

#### АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ:

153.1. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ үрэгдсэн хэрэг, шийдвэр гүйцэтгэлийн материалаас үлдсэн болон үрэгдэхийн өмнө иргэн, хуулийн этгээдэд олгосон баримт бичиг, түүний хуулбар, ач холбогдол бүхий бусад баримт мэдээллийг ашиглана. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг хянан шийдвэрлэх шүүх уг хэргийн оролцогч, шаардлагатай бол хэргийг урьд хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн болон шийдвэр гүйцэтгэсэн этгээдээс гэрчийн хувиар мэдүүлэг авч болно.

1551.1. Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч, эсхүл үүргээ биелүүлж чадахгүй болсон хуулийн этгээд өөрийгөө дампуурсанд тооцуулахаар тухайн хуулийн этгээдийн оршин байгаа газрын шүүхэд хүсэлт гаргана.



#### АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ:

162.2.2. гомдол гаргаж буй этгээдийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, эсхүл албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;

#### АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ:

186.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд гүйцэтгэх хуудастай хамт шүүхийн шийдвэр, битүүмжилсэн буюу хураасан эд хөрөнгийн тухай тэмдэглэл, иргэдийн хувийн хадгаламж, хуулийн этгээдийн харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг, тодорхойлолт зэргийг хавсарган явуулна.

189.1. Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна.

189.2.5. хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх салбар буюу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас маргаан үүссэн;

#### АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ:

190.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байршилтай хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах буюу тухайн хуулийн этгээдийн болон түүний салбар, төлөөлөгчийн газрын гаргасан шийдвэртэй холбоотой үүссэн маргаан.

Найм.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах талаар туссан байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хамаарах ба дараах шийдвэрийг үндэслэн явуулна. Үүнд:

- Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр
- Хэргийн хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж

- Монгол улсын Олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрайн шийдвэр

- Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ -ийн эд хөрөнгийн хариуцлага, хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрайн шийдвэр

- Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр

- Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авагдах ба шүүхийн захирамж

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төрлийн хувьд

- Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа

- Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа

- Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагатай холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

- Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

- Зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээг гүйцэтгэгж, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага болон төлөөлөх этгээдэд шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хугацаа тогтоосон мэдэгдлийн гардуулах, эзэмшил өмчлөлийн эд хөрөнгө, орлогыг тогтоох, төлбөрийн чадварын талаарх мэдээллийг хуульд заасны дагуу олж авах, эрх түдгэлзүүлэх, мөнгөн хадгаламж болон харилцах данснаас суутгал хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураан авах, худалдан борлуулах дараах нийтлэг ажиллагааг явуулна.

### **Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, үл хөдлөх эд хөрөнгө, бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, гааль, татвартай холбоотой мэдээллийг цахим мэдээллийн сангаас хугацаа алдахгүй авах боломжтой. Бусад төрийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг

төлбөрийн чадвартай эсэхийг тодруулах зорилгоор гаргуулан авах боломжтой.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгө, үйл ажиллагаатай холбоотой, зөвхөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдээлэлийг авна.

Хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл хувийн ашиг сонирхлоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах, бусдад давуу байдал олгож, ялгамжтай харьцахыг хуулиар хатуу хориглосон байдаг.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээ, тэдгээрийн үнэлгээ, үнэлгээнд нөлөөлөхүйц шинж чанарыг тогтоох зорилгоор өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа түүний өмчлөлийн эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийх, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр бусдын орон байранд нэвтрэн орох эрхтэй.

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгөнд үзлэг хийх, битүүмжлэх, барьцаалах, хураах явцад түүний биедээ эсхүл бусад газарт нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн биед болон тухайн эд хөрөнгийг нуусан газарт нэгжлэг хийж болно. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгөнд нэгжлэг хийх үед бэлэн мөнгө олдсон тохиолдолд төлбөрийн хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авна.

Төлбөрт гаргуулсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цаг, хөдөө орон нутагт 72 цагийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх газрын төлбөрийн дансанд шилжүүлнэ.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг явуулахад хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх үйл ажиллагааг явуулахдаа тэмдэглэл хөтөлнө.

Төлбөр төлөгч ямар эд хөрөнгөө төлбөрт өгөх тухай хүсэлтээ тавих эрх эдлэх ба шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад болохгүй бол энэ хүсэлтийг харгалзан үзэж болдог.

Хуулийн этгээдийг хууль тогтоомж, эсхүл үүрэг байгуулах баримт бичгийн дагуу эрх олгогдсон албан тушаалтан төлөөлөх бөгөөд хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээдэд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичигтэй байна. Төлөөлөгчийн бүрэн эрхийг

төлөөлүүгчээс бичгээр олгосон итгэмжлэл, эрх олгосон бусад баримт бичгээр тодорхойлох бөгөөд итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байна.

- Итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байх.

- Хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх. Олгосон он сар өдөр.

- Хуульд заасан бол нотариатаар батлуулах
- Итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.

Дээр дурьдсан итгэмжлэлд тавигдах иргэний эрх зүйн ерөнхий шаардлагуудаас гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлогтой уялдаж итгэмжлэлд төлөөлөгчийн дараах бүрэн эрхийг бичсэн байна.

- Гүйцэтгэх баримт бичгийг буцааж авах
- Төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх
- Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гомдол гаргах
- Төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэхээр гүйцэтгэх баримт бичигт заасан тодорхой хөрөнгийг хүлээн авах
- Төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэхээр шийдвэрт заасан тодорхой хөрөнгийг хүлээн авах, эвлэрлийн гэрээ байгуулах зэрэг болно.

### **Төлбөр төлөгч хуулийн этгээдийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа.**

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч хуулийн этгээдийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэр гаргаж, банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны дугаар, төрөл, данс эзэмшигчийн нэр болон бусад шаардлагатай мэдээлэл тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч банк, эрх бүхий хуулийн этгээдээс шаардлагатай лавлагаа, тодорхойлолтыг гаргуулж, хэрэв төлбөр төлөгч данстай бол дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэрийг хүргүүлнэ.

Хүлээн авсан даруйд биелүүлж, төлбөр төлөгчийн болон шийдвэр гүйцэтгэчийн шийдвэрт заасан бусад этгээдийн нэр дээр бүртгэлтэй дансны мэдээлэл, дансанд битүүмэлэгдсэн мөнгөн хөрөнгийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт мэдэгдэнэ.

Банк, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхдээ шаардлагатай хэмжээний мөнгөн хөрөнгө төлбөр төлөгчийн

дансанд байхгүйн улмаас мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй талаар шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх үүрэг хүлээдэг.

Дээрх ажиллагааны журам нь үнэт цаас арилжиж, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд дэх данс, бусдын нэр дээр бүртгэлтэй боловч захиран зарцуулах эрхийг төлбөр төлөгч хэрэгжүүлж байгаа бусад дансанд нэгэн адил хамаарах юм.

Шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор хүлээлгэсэн үүргийг зөрчсөн ажиллагааны оролцогч бус гуравдагч этгээд болох банк, эрх бүхий хуулийн этгээдэд холбогдуулан Зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж, хариуцлага тооцох эрх ахлах шийдвэр гүйцэтгэгчид 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон.

Дээр дурдсан эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулна. Мөн төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт металл, эрдэний чулуу, үнэт цаас, бэлэн мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөө бусдад, бусдаас төлбөр төлөгчид, бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөрийг гаргуулж болдог.

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс эхүүл гүйлгээнд оруулах хязгаарласнаас бусад хөрөнгөөс төлбөрийг суутгана. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө хаана, ямар зориулалтаар ашиглагдаж байгааг харгалзахгүй.

Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна. Төлбөр төлөгч нь банк бол тухайн Арилжааны банкны Монгол банк дахь харилцах данснаас хасалт хийх, төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.

**Төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, төлбөрт суутгахтай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа**

Шийдвэр гүйцэтгэгчээс төлбөрөө төлөх хүртэл түүний эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу эзэмшилдээ албадан байлгах явдал нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны барьцааны тухай ойлголтын хамгийн гол шинж юм.

Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох ба энэ тохиолдолд дээрх баялаг нь түүний хөрөнгө болж шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хамааралгүй болж байдаг.

Хөрөнгийг битүүмжлэх барьцаалах гэж тухайн хөрөнгийг захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагаа ба эрхийг хязгаарлах хүрээ болон хугацааг тухайн хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэх үүрэг, түүнийг эзэмшиж, ашиглаж байгаа хэлбэр, гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхэд эзлэх хувийг харгалзан шийдвэр гүйцэтгэгч бие даан тогтоох эрхтэй.

Хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах ажиллагаанд хураан авах худалдан борлуулах төлбөрт суутгах хөрөнгийн дараалал харгалзахгүй.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх зорилго нь:

1. Хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх, худалдан борлуулах, эсхүл хөрөнгийг хамгаалах
2. Төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон бусдад байгаа түүний өмчлөлийн хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх
3. Төлбөр төлөгчийн болон бусдад байгаа түүний өмчлөлийн хөрөнгийг хураах тухай шийдвэрийг гүйцэтгэх

Битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх гэдэгт нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заасан эд хөрөнгийг хамгаалах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нь зөвхөн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгээд зогсохгүй хэргийг хянан шийдвэрлэх шатанд нь явагдаж эхэлдэг өвөрмөц төрлийн харилцаа юм<sup>14</sup>.

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг хураах тухай шийдвэрийг гүйцэтгэх гэдэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шүүхийн болон эрх бүхий албан тушаалтнаас гаргасан эрхийн актыг үндэслэн бичигдсэн гүйцэтгэх баримт

---

<sup>14</sup> Сүлд инфо. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Дугаар 2

бичигт нэр заасан эд хөрөнгийг /мөнгөн хөрөнгийг/ хураан авч буй шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа гэж ойлгож болно.

Банк, эрх бүхий хуулийн этгээд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын дансанд байгаа хөрөнгөөс бусад хөрөнгийг битүүмжлэх ажиллагаанд тэмдэглэл үйлдэж, битүүмжилсэн хөрөнгийн жагсаалт гарган хувийн дугаар бүхий тэмдэг дарна.

Үл хөдлөх хөрөнгө болон өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг нь бүртгүүлбэл зохих бусад хөрөнгийг битүүмжилсэн тухай шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллагад битүүмжилснээс хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

Битүүмжилсэн, барьцаалсан хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах тухай шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч болон эд хөрөнгийн хадгалалтыг хариуцах этгээдэд сануулж, зөрчвөл хариуцлага хүлээлгэхийг анхааруулах шаардлагатай байдаг ба шийдвэр гүйцэтгэх байгууллагаас битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцах этгээд санаатай үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс тавин мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл, зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх хуулийн зохицуулалт үйлчилж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгийг дараах дарааллаар хураан авч, худалдан борлуулан, төлбөрт суутгахаар хуульд зохицуулсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө, бараа ажил үйлчилгээ, үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээнд шууд хэрэглэгдэхгүй бусад материал, үнэт цаас
2. Бараа ажил үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөрөнгийн эрх
3. Бараа ажил үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй үл хөдлөх хөрөнгө
4. Бараа ажил үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамаарал бүхий хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бараа материал, бусад түүхий эд техник, тоног төхөөрөмж, үнэт цаас

Үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй эд хөрөнгөнд “үнэт цаас, хуулийн этгээдийн хадгаламжинд буюу бусад тооцоонд буй мөнгөн хөрөнгө, валют болон түүнтэй адилтгах бусад хөрөнгө” хамаарна.

Уг ойлголтуудыг тодруулбал:

а/ “Үнэт цаас” гэж засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компани гаргасан эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Үнэт цаасны хорооноос нэт цаасны тухай хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг ойлгоно.

б/Хуулийн этгээдийн хадгаламжинд байгаа мөнгөн хөрөнгө гэж уг хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээний үндсэн дээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд хадгалуулсан үндэсний болон цаад валютыг хадгаламжийг хэлнэ.

в/ Валют болон түүнтэй адилтгах бусад хөрөнгүүд хамаарна.

Бэлэн бүтээгдэхүүн, бусад материал үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэггүй материал гэдэгт үл хөдлөх эд хөрөнгө, түүхий эд материал үйлдвэрлэлийн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэг материалууд хамаарна.

Үл хөдлөх эд хөрөнгө, түүхий эд материал, үйлдвэрлэлийн багаж, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд шууд хэрэглэгддэг материал гэдэгт Иргэний хуульд заасны дагуу эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гэсэн хоёр төрөлтэй байх бөгөөд газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарч түүнээс бусад эд юмс хөдлөх эд хөрөнгөд хамаардаг.

Үл хөдлөх эд хөрөнгөд үйлдвэрлэл явуулах суурь нөхцөлд хамаарах барилга байшин, агуулах, газар зэрэг багтдаг бол түүхий эд материал нь түүнийг боловсруулсны үндсэн дээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүхий эд зүйлс байх бөгөөд үйлдвэрлэлд шууд хэрэглэгдэх материалын түүхий эдээс ялгагдах хамгийн гол онцлог нь түүнийг боловсруулж бүтээгдэхүүн хийдэггүй, харин түүхий эдийг боловсруулах явцад хэрэглэгддэгт оршино.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банк дахь харилцах данс хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгөн хөрөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид



бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.

Харин “бусад этгээд”-д хамаарах барьцаалагч тэргүүн ээлжинд хохирлоо арилгуулах эрх эдэлнэ. Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг хураах, худалдан борлуулахтай холбогдсон ажиллагааг явуулдаг. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх зэрэг ажиллагааны нэгэн адил эд хөрөнгө хураах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийн оролцоотой явуулна.

Хураан авах ажиллагаа нь хоёр шатыг дамжин явагдана.

1. Шийдвэр гүйцэтгэгч нь хураан авах хугацааг тогтоох, өөрөөр хэлбэр битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг худалдан борлуулах эсхүл гүйцэтгэх баримт бичигт заасан тохиолдолд төлбөр авагчид шилжүүлэх зорилгоор хураан авах хугацааг шийдвэр гүйцэтгэгч тогтооно

2. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг хураан авна.

Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалахын хамт тухайн эд хөрөнгө болон түүний зарим бүрдэл хэсгийг хураан авч болох бөгөөд Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг хураан авахаар заасан.

### **Төлбөр төлөгч хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах журам**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д “Төлбөр төлөгч хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах өөрчлөгдөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна” гэж заажээ.

### **Төлбөр төлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 98 дугаар зүйлд энэ харилцааг зохицуулсан. Үүнд:

1.Төлбөр төлөгч хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагааг нь зогсоох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

2.Татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль болон Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ.

3.Төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэн төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.

Дээрх хуулийн зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзье. Дампуурлын хэргийн хариуцагчийн хөрөнгийг хуульд зааснаар

1. Хэрэг гүйцэтгэгч

2. Шүүгч өөрийн санаачилгаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд захирамж гарган хамгаалахаар заасан байдаг.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байх үед төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэх явдал тохиолддог. Дампуурлын хэрэг үүсгэх нэхэмжлэлийн шаардлагад

- сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл
- өмчлөлдөө байгаа, эсхүл итгэмжлэн емчилсэн эд хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн үнэлгээний талаарх санал

- нэхэмжлэгчдийн нэр, хаяг, нэхэмжлэгч тус бүрийн авлага буюу гаргуулах төлбөрийн хэмжээ:

- Хариуцагчид төлбөртэй этгээдийн нэр, хаяг, төлбөрийн хэмжээ:
- Дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэлд тухайн этгээдийг төлбөрийн чадваргүйд тооцуулах, төлбөрийн чадваргүй болсон гэж үзэх үндэслэл, түүний хүлээсэн үүрэг, төлбөрийн хэмжээ, үүрэг гүйцэтгэх хугацаа, хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл дампуурсанд тооцож татан буулгах тухай саналыг тус тус тусгаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

- Шаардлагатай тохиолдолд шүүх хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсон тухай нэмэлт нотлох баримтыг нэхэмжлэл, хүсэлт гаргасан этгээдээс шаардаж болно.

Төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахгүй бөгөөд Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1-д заасны дагуу төлбөр төлөгч болон төлбөр авагч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийг эрх үүрэг эрх залгамжлагчид шилжих хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагч нарт дампуурлын хэргийн оролцогчоор шүүхэд нэхэмжлэл гаргаж оролцох талаар танилцуулж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түр зогссон болохыг мэдэгдэж, шүүхийн шийдвэрийг дампуурлын хэрэг үүсгэсэн шүүхэд хүргүүлнэ.

Мөн дампуурлын хэрэг үүсгэсэн үеэс шийдвэр гүйцэтгэгч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах захирамжийн хүрээнд хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, эд хөрөнгийг хамгаалах, хариуцагчид тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг даалгаж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах бөгөөд дампуурлын хэрэг гүйцэтгэгчийг нэхэмжлэгчдийн хурлаас томилох хүртэл хугацаанд явуулна.

Дампуурлын хэрэг гүйцэтгэгч томилогдоход шийдвэр гүйцэтгэгч хариуцагчийн эд хөрөнгийн хамгаалалт болон шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах захирамжийн хүрээнд хийгдсэн ажиллагаа, хамгаалсан эд хөрөнгө зэргийг хэрэг гүйцэтгэгчид шилжүүлж өгнө.

Харин төлбөр төлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд төлбөр гаргуулах ажиллагааг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

Татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч, Иргэний болон Дампуурлын тухай хуульд заасны дагуу төлбөр авагчид, шийдвэр гүйцэтгэх албаны дансанд мөнгийг төвлөрүүлнэ.

Төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэж явуулсан татан буулгах ажиллагаа дуусгавар болоход эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байгаа нь шүүхээр тогтоогдсон шийдвэрийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгоно.

Төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэн төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг Шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлэхээр тус тус зохицуулсан байна.

## **Хоёрдугаар бүлэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй байдалд хийсэн шинжилгээ**

### **2.1. Шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааныг шийдвэрлэж буй байдал**

Иргэний эрх зүйн харилцаанд иргэдээс болон төрөл бүрийн байгууллага субъектээр оролцдог. Эдгээр байгууллагаыг иргэний эрх зүйн шинжлэх ухаан болон практик амьдралын түүхэнд хуулийн этгээд гэсэн нэр томъёогоор илэрхийлж ирсэн байна. Хувийн, нийтийн, хамтарсан болон холимог өмч дээр тулгуурласан байгууллагууд эд хөрөнгөний ба түүнтэй холбоотой эд хөрөнгөний бус харилцаан иргэний эрх зүйн эрх эдэлж, үүрэг хүлээж оролцдог<sup>15</sup>.

Хуулийн этгээдтэй холбоотой маргаан ихэвчлэн банкны зээлийн холбоотой маргаан, үүрэн холбооны оператар байгууллагууд худалдан худалдан авахтай холдбоотой болон төлбөрийн холбоотой маргаан, банк бус байгууллагууд зээлийн холбоотой нэхэмжлэл, гомдол гаргадаг ба үүнийг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлдэдэг байна.

Иргэний хэргийн шүүхийн сүүлийн таван жилийн шүүн таслах ажиллагааг судалж үзлээ. Үүнд:

#### *Нэг. Иргэний хэргийн 2016 оны шүүн таслах ажиллагаа*

1.1. Иргэний хэргийн анхан шатны шүүх 2016 онд нийт 64030 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11225 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, **46173** хэргийг хянан шийдвэрлэсэн үүний **5677** хэрэг нь хуулийн этгээдтэй холбоотой хэрэг маргаан байна<sup>16</sup>.


**Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал:** Шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 46173 иргэний хэргийн 23569 хэрэг буюу 51 хувийг нь ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бол 16204 хэрэг буюу 35 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 6400 хэрэг буюу 14 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгожээ<sup>17</sup>.

*Зураг 3. 2016 онд шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал*

<sup>15</sup> Мөнхжаргал.Т.,(2007). Монгол улсын иргэний эрх зүй.УБ хот.(х.54)


<sup>16</sup> Монгол улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан

<sup>17</sup> Монгол улсын шүүхийн 2016 оны шүүн таслах ажиллагааны тайлан



**Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл:** Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 24826 буюу 53.8 хувийг, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 11942 буюу 25.9 хувийг, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 4674 буюу 10.1 хувийг, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 2220 буюу 4.8 хувийг тус тус эзэлжээ<sup>18</sup>.

*Зураг 4. 2016 онд шүүхээс шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой хэрэг, маргааны төрөл*



- 2020 онд нийт **258** гүйцэтгэх хуудасны **879.959.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **34** гүйцэтгэх хуудасны **334.349.1** төгрөгийн төлбөрөөс тус онд **32** гүйцэтгэх хуудасны **332.822.5** төгрөг;




- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **73** гүйцэтгэх хуудасны **216.755.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **5** гүйцэтгэх хуудасны **6.435.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **3** гүйцэтгэх хуудасны **1.580.3** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 46. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 47. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2298** гүйцэтгэх хуудасны **78.020.638** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **187** гүйцэтгэх хуудасны **60.498.024** төгрөгийн төлбөрөөс **64** гүйцэтгэх хуудасны **4.690.850** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **462** гүйцэтгэх хуудасны **12.854.281.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **36** гүйцэтгэх хуудасны **7.591.122.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **14** гүйцэтгэх хуудасны **177.243.0** төгрөг;


- 2018 онд нийт **411** гүйцэтгэх хуудасны **15.740.088.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **29** гүйцэтгэх хуудасны **11.254.000.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **9** гүйцэтгэх хуудасны **95.908.0** төгрөг;

- 2019 онд нийт **527** гүйцэтгэх хуудасны **21.075.346.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **44** гүйцэтгэх хуудасны **16.133.329.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **15** гүйцэтгэх хуудасны **2.803.241.0** төгрөг

- 2020 онд нийт **542** гүйцэтгэх хуудасны **15.614.225.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **41** гүйцэтгэх хуудасны **13.057.248.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **13** гүйцэтгэх хуудасны **1.446.296.0** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **356** гүйцэтгэх хуудасны **12.736.696.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **37** гүйцэтгэх хуудасны **12.462.325.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **13** гүйцэтгэх хуудасны **166.162.0** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 48. Өмнөговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/*



Зураг 49. Өмнөговь аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/



### Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэлтэс:

Тус хэлтэс нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **163** гүйцэтгэх хуудасны **11.714.711.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **8** гүйцэтгэх хуудасны **214.386.9** төгрөгийн төлбөрөөс **7** гүйцэтгэх хуудасны **907.397.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2019 онд нийт **59** гүйцэтгэх хуудасны **10.087.856.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **1** гүйцэтгэх хуудасны **80.685.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **1** гүйцэтгэх хуудасны **841.401.9** төгрөг;


- 2020 онд нийт **74** гүйцэтгэх хуудасны **673.642.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **5** гүйцэтгэх хуудасны **97.553.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **5** гүйцэтгэх хуудасны **4.486.2** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **30** гүйцэтгэх хуудасны **953.213.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **2** гүйцэтгэх хуудасны **97.553.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **1** гүйцэтгэх хуудасны **4.486.2** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 50. Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 51. Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2248** гүйцэтгэх хуудасны **13.161.314.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **385** гүйцэтгэх хуудасны **4.242.273.8** төгрөгийн төлбөрөөс **200** гүйцэтгэх хуудасны **1.695.966.8** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **488** гүйцэтгэх хуудасны **2.178.535.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **67** гүйцэтгэх хуудасны **479.186.7** төгрөгийн төлбөрөөс тус онд **38** гүйцэтгэх хуудасны **130.904.1** төгрөг;

- 2018 онд нийт **454** гүйцэтгэх хуудасны **2.610.265.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **82** гүйцэтгэх хуудасны **968.800.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **43** гүйцэтгэх хуудасны **457.489.8** төгрөг;

- 2019 онд нийт **537** гүйцэтгэх хуудасны **2.838.385.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **104** гүйцэтгэх хуудасны 1.355.347.1 төгрөгийн төлбөрөөс тус онд **59** гүйцэтгэх хуудасны **460.118.2** төгрөг


- 2020 онд нийт **503** гүйцэтгэх хуудасны **3.313.783.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **81** гүйцэтгэх хуудасны **985.099** төгрөгийн төлбөрөөс тус онд **37** гүйцэтгэх хуудасны **498.080.8** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **266** гүйцэтгэх хуудасны **2.220.344.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **51** гүйцэтгэх хуудасны **453.840.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **23** гүйцэтгэх хуудасны **149.374.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 52. Сүхбаатар аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/*



*Зураг 53. Сүхбаатар аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/*



### Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **4152** гүйцэтгэх хуудасны **97.342.885.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **179** гүйцэтгэх хуудасны **2.952.643.7** төгрөгийн төлбөрөөс **92** гүйцэтгэх хуудасны **1.342.519.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **894** гүйцэтгэх хуудасны **4.605.677.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **20** гүйцэтгэх хуудасны **453.064.6** төгрөгийн төлбөрөөс тус онд **20** гүйцэтгэх хуудасны **129.296.1** төгрөг;


- 2018 онд нийт **841** гүйцэтгэх хуудасны **8.128.034.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **35** гүйцэтгэх хуудасны **983.693.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **24** гүйцэтгэх хуудасны **814.043.7** төгрөг;

- 2019 онд нийт **956** гүйцэтгэх хуудасны **18.403.027.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **538** гүйцэтгэх хуудасны **10.350.890.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **298** гүйцэтгэх хуудасны **1.042.292.4** төгрөг

- 2020 онд нийт **904** гүйцэтгэх хуудасны **72.900.334.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **38** гүйцэтгэх хуудасны **670.949.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **17** гүйцэтгэх хуудасны **146.215.4** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **557** гүйцэтгэх хуудасны **5.857.958.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **28** гүйцэтгэх хуудасны **415.187.5** төгрөгийн төлбөрөөс тус онд **9** гүйцэтгэх хуудасны **110.060.6** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 54. Сэлэнгэ аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/*



Зураг 55. Сэлэнгэ аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/



### Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс:

Тус хэлтэс нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2978** гүйцэтгэх хуудасны **20.049.180.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **151** гүйцэтгэх хуудасны **2.758.103.7** төгрөгийн төлбөрөөс **105** гүйцэтгэх хуудасны **470.729.4** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **507** гүйцэтгэх хуудасны **2.412.497.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **39** гүйцэтгэх хуудасны **183.388.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **36** гүйцэтгэх хуудасны **92.663.1** төгрөг;

- 2018 онд нийт **591** гүйцэтгэх хуудасны **3.188.070.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **35** гүйцэтгэх хуудасны **444.125.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **23** гүйцэтгэх хуудасны **46.079.9** төгрөг;

- 2019 онд нийт **661** гүйцэтгэх хуудасны **3.912.645.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **20** гүйцэтгэх хуудасны **222.454.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **15** гүйцэтгэх хуудасны **159.068.7** төгрөг;

- 2020 онд нийт **721** гүйцэтгэх хуудасны **5.757.056.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **35** гүйцэтгэх хуудасны **925.973.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **93.694.4** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **498** гүйцэтгэх хуудасны **4.778.909.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **22** гүйцэтгэх хуудасны **982.163.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **6** гүйцэтгэх хуудасны **79.223.3** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 56. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 57. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэлтэс:

Тус хэлтэс нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2010** гүйцэтгэх хуудасны **20.965.926.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **382** гүйцэтгэх хуудасны **16.350.367.6** төгрөгийн



төлбөрөөс **166** гүйцэтгэх хуудасны **10.293.490.0** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **387** гүйцэтгэх хуудасны **4.831.138.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **86** гүйцэтгэх хуудасны **3.735.492.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **1.975.623.5** төгрөг;


- 2018 онд нийт **395** гүйцэтгэх хуудасны **2.780.383.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **70** гүйцэтгэх хуудасны **1.997.843.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **712.290.3** төгрөг;

- 2019 онд нийт **496** гүйцэтгэх хуудасны **5.275.146.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **98** гүйцэтгэх хуудасны **2.684.993.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **51** гүйцэтгэх хуудасны **1.847.400.0** төгрөг;

- 2020 онд нийт **484** гүйцэтгэх хуудасны **3.497.649.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **81** гүйцэтгэх хуудасны **2.684.993.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **37** гүйцэтгэх хуудасны **1.847.400** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **248** гүйцэтгэх хуудасны **4.599.607.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **47** гүйцэтгэх хуудасны **3.762.481.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **18** гүйцэтгэх хуудасны **2.455.718.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 58. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 59. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2839** гүйцэтгэх хуудасны **33.819.351.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **135** гүйцэтгэх хуудасны **3.504.987.9** төгрөгийн төлбөрөөс **125** гүйцэтгэх хуудасны **4.199.980** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **732** гүйцэтгэх хуудасны **6.058.646.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **36** гүйцэтгэх хуудасны **980.046.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **3 310.120.0** төгрөг;

- 2018 онд нийт **638** гүйцэтгэх хуудасны **7.458.083.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **32** гүйцэтгэх хуудасны **658.200.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **285.200.0** төгрөг;

- 2019 онд нийт **628** гүйцэтгэх хуудасны **8.015.888.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **31** гүйцэтгэх хуудасны **656.220.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **26** гүйцэтгэх хуудасны **356.460.0** төгрөг;


- 2020 онд нийт **500** гүйцэтгэх хуудасны **7.774.422.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **22** гүйцэтгэх хуудасны **800.521.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **14** гүйцэтгэх хуудасны **405.000.0** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **341** гүйцэтгэх хуудасны **4.512.310.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **14** гүйцэтгэх хуудасны **410.000.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **5** гүйцэтгэх хуудасны **52.120.0** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 60. Увс аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/



Зураг 61. Увс аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/



### Төв аймаг дахь дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **3588** гүйцэтгэх хуудасны **30.472.946.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **679** гүйцэтгэх хуудасны **14.658.901.9** төгрөгийн төлбөрөөс **401** гүйцэтгэх хуудасны **3.020.356.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **1000** гүйцэтгэх хуудасны **6.151.632.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **215** гүйцэтгэх хуудасны **2.911.411.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **137** гүйцэтгэх хуудасны **1.067.702.8** төгрөг;

- 2018 онд нийт **813** гүйцэтгэх хуудасны **5.782.952.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **150** гүйцэтгэх хуудасны **2.177.331.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **60** гүйцэтгэх хуудасны **352.251.4** төгрөг;

- 2019 онд нийт **814** гүйцэтгэх хуудасны **6.775.478.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **152** гүйцэтгэх хуудасны **2.979.388.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **112** гүйцэтгэх хуудасны **557.159.6** төгрөг;

- 2020 онд нийт **628** гүйцэтгэх хуудасны **6.784.158.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **106** гүйцэтгэх хуудасны **3.372.186.7** төгрөгийн төлбөрөөс тус онд **68** гүйцэтгэх хуудасны **802.633.1** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **333** гүйцэтгэх хуудасны **4.978.724.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **56** гүйцэтгэх хуудасны **3.218.584.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **24** гүйцэтгэх хуудасны **240.609.2** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 62. Төв аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/*



*Зураг 63. Төв аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/*



### Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **2180** гүйцэтгэх хуудасны **11.208.606.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **147** гүйцэтгэх хуудасны **1.031.151.7** төгрөгийн төлбөрөөс **126** гүйцэтгэх хуудасны **971.982.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **493** гүйцэтгэх хуудасны **2.599.889.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **37** гүйцэтгэх хуудасны **698.108.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **32** гүйцэтгэх хуудасны **685.408.2** төгрөг;

- 2018 онд нийт **491** гүйцэтгэх хуудасны **2.364.770.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **35** гүйцэтгэх хуудасны **44.547.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **37** гүйцэтгэх хуудасны **44.882.7** төгрөг;

- 2019 онд нийт **380** гүйцэтгэх хуудасны **1.773.862.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **26** гүйцэтгэх хуудасны **68.520.1** төгрөгийн төлбөрөөс тус онд **21** гүйцэтгэх хуудасны **71.417.1** төгрөг;

- 2020 онд нийт **549** гүйцэтгэх хуудасны **2.437.685.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **37** гүйцэтгэх хуудасны **195.087.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **30** гүйцэтгэх хуудасны **161.040.5** төгрөг;


- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **267** гүйцэтгэх хуудасны **2.032.399.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд

холбогдох **12** гүйцэтгэх хуудасны **24.888.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **6** гүйцэтгэх хуудасны **9.234.2** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 64. Ховд аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/



Зураг 65. Ховд аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/



### Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **3728** гүйцэтгэх хуудасны **20.907.785.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **381** гүйцэтгэх хуудасны **860.270.1** төгрөгийн төлбөрөөс

**328** гүйцэтгэх хуудасны **384.896.2** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **888** гүйцэтгэх хуудасны **4.718.220.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **67** гүйцэтгэх хуудасны **91.804.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **60** гүйцэтгэх хуудасны **55.304.2** төгрөг;

- 2018 онд нийт **731** гүйцэтгэх хуудасны **4.158.231.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **87** гүйцэтгэх хуудасны **78.981.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **77** гүйцэтгэх хуудасны **42.491.4** төгрөг;

- 2019 онд нийт **774** гүйцэтгэх хуудасны **4.189.841.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **101** гүйцэтгэх хуудасны **116.886.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **85** гүйцэтгэх хуудасны **38.886.8** төгрөг;


- 2020 онд нийт **795** гүйцэтгэх хуудасны **4.401.130.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **113** гүйцэтгэх хуудасны **187.360.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **103** гүйцэтгэх хуудасны **151.670.4** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **540** гүйцэтгэх хуудасны **3.340.361.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **13** гүйцэтгэх хуудасны **385.236.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **3** гүйцэтгэх хуудасны **96.543.4** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 66. Хөвсгөл аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021/*



Зураг 67. Хөвсгөл аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/



### Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **4319** гүйцэтгэх хуудасны **33.186.531.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **855** гүйцэтгэх хуудасны **13.478.014.9** төгрөгийн төлбөрөөс **426** гүйцэтгэх хуудасны **5.664.438.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **752** гүйцэтгэх хуудасны **4.400.467.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **146** гүйцэтгэх хуудасны **1.228.266.7** төгрөгийн төлбөрөөс тус онд **67** гүйцэтгэх хуудасны **207.777.6** төгрөг;

- 2018 онд нийт **862** гүйцэтгэх хуудасны **4.845.895.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **166** гүйцэтгэх хуудасны **1.595.253.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **86** гүйцэтгэх хуудасны **513.673.3** төгрөг;

- 2019 онд нийт **966** гүйцэтгэх хуудасны **9.086.580.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **177** гүйцэтгэх хуудасны **4.941.897.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **109** гүйцэтгэх хуудасны **856.202.5** төгрөг;

- 2020 онд нийт **1042** гүйцэтгэх хуудасны **9.142.024.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **239** гүйцэтгэх хуудасны **4.992.472.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **136** гүйцэтгэх хуудасны **3.756.768.6** төгрөг;




- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **697** гүйцэтгэх хуудасны **5.711.862.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **127** гүйцэтгэх хуудасны **720.125.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **28** гүйцэтгэх хуудасны **330.016.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

*Зураг 68. Хэнтий аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо /2017-2021*



*Зураг 69. Хэнтий аймгийн хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн /2017-2021/*



### **Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба:**

Тус алба нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **6728** гүйцэтгэх хуудасны **1.638.584.991.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас

хуулийн этгээдэд холбогдох **3681** гүйцэтгэх хуудасны **1.494.684.717.0** төгрөгийн төлбөрөөс **914** гүйцэтгэх хуудасны **88.364.132.5** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **1778** гүйцэтгэх хуудасны **355.140.507.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **912** гүйцэтгэх хуудасны **329.001.215.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **155** гүйцэтгэх хуудасны **8.934.828.5** төгрөг;


- 2018 онд нийт **1641** гүйцэтгэх хуудасны **346.498.161.2** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **680** гүйцэтгэх хуудасны **316.390.778.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **175** гүйцэтгэх хуудасны **11.941.295.3** төгрөг;

- 2019 онд нийт **1694** гүйцэтгэх хуудасны **462.881.561.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **1119** гүйцэтгэх хуудасны **430.061.966.6** төгрөгийн төлбөрөөс тус онд **273** гүйцэтгэх хуудасны **27.568.731.2** төгрөг;


- 2020 онд нийт **1019** гүйцэтгэх хуудасны **204.378.738.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **588** гүйцэтгэх хуудасны **176.220.450.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **254** гүйцэтгэх хуудасны **36.678.079.5** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **596** гүйцэтгэх хуудасны **269.686.022.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **382** гүйцэтгэх хуудасны **243.010.305.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **57** гүйцэтгэх хуудасны **3.241.198.0** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 70. Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 71. Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар:

Тус газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **96265** гүйцэтгэх хуудасны **6.668.097.344.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **21546** гүйцэтгэх хуудасны **3.376.632.975.8** төгрөгийн төлбөрөөс **9089** гүйцэтгэх хуудасны **677.797.873.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **18921** гүйцэтгэх хуудасны **946.705.526.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **4563** гүйцэтгэх хуудасны **473.370.092.5** төгрөгийн төлбөрөөс тус онд **2069** гүйцэтгэх хуудасны **148.551.946.5** төгрөг;

- 2018 онд нийт **19224** гүйцэтгэх хуудасны **1.354.149.233.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **4603** гүйцэтгэх хуудасны **823.622.505.7** төгрөгийн төлбөрөөс тус онд **2250** гүйцэтгэх хуудасны **223.008.357.8** төгрөг;


- 2019 онд нийт **24331** гүйцэтгэх хуудасны **1.876.772.028.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **4478** гүйцэтгэх хуудасны **615.867.099.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **2291** гүйцэтгэх хуудасны **99.838.444.9** төгрөг;

- 2020 онд нийт **19043** гүйцэтгэх хуудасны **1.292.321.670.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **4493** гүйцэтгэх хуудасны **639.691.734.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **2001** гүйцэтгэх хуудасны **149.397.157.4** төгрөг;


- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **14746** гүйцэтгэх хуудасны **1.198.148.885.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **3409** гүйцэтгэх хуудасны **824.081.544.0** төгрөгийн

төлбөрөөс тус онд **478** гүйцэтгэх хуудасны **57.001.966.5** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 72. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 73. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Налайх дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэлтэс:

Тус хэлтэс нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **3012** гүйцэтгэх хуудасны **82.963.304.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **598** гүйцэтгэх хуудасны **6.749768.0** төгрөгийн төлбөрөөс **395** гүйцэтгэх хуудасны **2.588.200.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **688** гүйцэтгэх хуудасны **56.088.868.8** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **135** гүйцэтгэх хуудасны **3.859.742.3** төгрөгийн төлбөрөөс тус онд **94** гүйцэтгэх хуудасны **870.179.6** төгрөг;

- 2018 онд нийт **641** гүйцэтгэх хуудасны **4.816.846.0** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **124** гүйцэтгэх хуудасны **698.003.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **86** гүйцэтгэх хуудасны **143.533.8** төгрөг;

- 2019 онд нийт **639** гүйцэтгэх хуудасны **6.297.778.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **129** гүйцэтгэх хуудасны **793.584.1** төгрөгийн төлбөрөөс тус онд **98** гүйцэтгэх хуудасны **205.807.3** төгрөг;


- 2020 онд нийт **620** гүйцэтгэх хуудасны **8.194.294.4** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **114** гүйцэтгэх хуудасны **741.241.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **91** гүйцэтгэх хуудасны **55.307.2** төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **424** гүйцэтгэх хуудасны **7.656.516.7** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **96** гүйцэтгэх хуудасны **6.749.768.0** төгрөгийн төлбөрөөс тус онд **26** гүйцэтгэх хуудасны **2.588.200.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 74. Налайх дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 75. Налайх дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



### Багануур дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэлтэс:

Тус хэлтэс нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **3166** гүйцэтгэх хуудасны **24.758.254.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **223** гүйцэтгэх хуудасны **3.925.678.3** төгрөгийн төлбөрөөс **159** гүйцэтгэх хуудасны **2.071.828.5** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **703** гүйцэтгэх хуудасны **4.816.104.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **51** гүйцэтгэх хуудасны **844.256.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **25** гүйцэтгэх хуудасны **466.585.4** төгрөг;

- 2018 онд нийт **631** гүйцэтгэх хуудасны **4.068.788.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **46** гүйцэтгэх хуудасны **978.523.9** төгрөгийн төлбөрөөс тус онд **40** гүйцэтгэх хуудасны **325.879.4** төгрөг;


- 2019 онд нийт **684** гүйцэтгэх хуудасны **5.763.095** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **52** гүйцэтгэх хуудасны **1.203.341.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **35** гүйцэтгэх хуудасны **672.814.4** төгрөг;

- 2020 онд нийт **744** гүйцэтгэх хуудасны **6.491.558.1** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **59** гүйцэтгэх хуудасны **845.271.4** төгрөгийн төлбөрөөс тус онд **51** гүйцэтгэх хуудасны **547.283.2** төгрөг;


- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **404** гүйцэтгэх хуудасны **3.618.708.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд

холбогдох **15** гүйцэтгэх хуудасны **54.284.7** төгрөгийн төлбөрөөс тус онд **8** гүйцэтгэх хуудасны **59.266.1** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 76. Багануур дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 77. Багануур дүүрэг дэх хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн



**Монгол Улсын хэмжээнд төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулсан байдал:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүд нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт **189210** гүйцэтгэх хуудасны **7.998.353.658.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **39355** гүйцэтгэх хуудасны

**4.631.379.317.3** төгрөгийн төлбөрөөс **18183** гүйцэтгэх хуудасны **702.330.962.2** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

- 2017 онд нийт **39415** гүйцэтгэх хуудасны **1.504.141.175.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **8425** гүйцэтгэх хуудасны **872.329.320.5** төгрөгийн төлбөрөөс тус онд **4004** гүйцэтгэх хуудасны **175.662.981.8** төгрөг;

- 2018 онд нийт **38493** гүйцэтгэх хуудасны **1.853.072.717.6** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **8269** гүйцэтгэх хуудасны **1.208.248.849.8** төгрөгийн төлбөрөөс тус онд **4265** гүйцэтгэх хуудасны **246.406.724.3** төгрөг;

- 2019 онд нийт **44663** гүйцэтгэх хуудасны **2.534.369.306.5** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **8736** гүйцэтгэх хуудасны **1.131.189.772.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **4494** гүйцэтгэх хуудасны **147.182.243.7** төгрөг;

- 2020 онд нийт **39327** гүйцэтгэх хуудасны **467.626.125.3** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **8331** гүйцэтгэх хуудасны **270.760.262.2** төгрөгийн төлбөрөөс тус онд **4245** гүйцэтгэх хуудасны **64.946.685.7** төгрөг;


- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт **27312** гүйцэтгэх хуудасны **1.639.144.333.9** төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох **5594** гүйцэтгэх хуудасны **1.148.851.112.6** төгрөгийн төлбөрөөс тус онд **1175** гүйцэтгэх хуудасны **68.132.326.7** төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Зураг 78. Улсын хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны тоо



Зураг 79. Улсын хэмжээнд хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудасны мөнгөн дүн






### 2.3. Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй байдал, шийдвэрлэх арга зам

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, түүнийг боловсронгуй болгох арга замыг тодруулах зорилгоор нийт 188 шийдвэр гүйцэтгэгчээс цахимаар санал авахад дараахь хариултыг өгсөн.

Нэг. "Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгөх таны үнэлгээ" гэдэг асуултад хангалттай гэж 6 хувь буюу 10, сайжруулах шаардлагатай гэж 94 хувь буюу 170 шийдвэр гүйцэтгэгч хариулжээ.

*Зураг 80. Шийдвэр гүйцэтгэгчдээс хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ*



Энэ нь хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн практик хэрэглээний шаардлагыг хангахгүй байгааг илтгэн харуулж байгаа ба зайлшгүй сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Хоёр. "Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудалд хамаарах хэсгийг тодорхойлно уу" гэсэн асуултад "мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах" гэж 11% буюу 19 шийдвэр гүйцэтгэгч, эд хөрөнгийг хураан авах, худалдан борлуулах, төлбөрт суутгахад гэж 22% буюу 37 шийдвэр гүйцэтгэгч, бусдын эзэмшилд байгаа мөнгөн болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулахад гэж 48% буюу 80 шийдвэр гүйцэтгэгч, өөрчлөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулахад гэж 17% буюу 28 шийдвэр гүйцэтгэгч,

үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах үед гэж 2% буюу 3 шийдвэр гүйцэтгэгч хариулжээ.

*Зураг 81. Шийдвэр гүйцэтгэгчдээс хуулийн зохицуулалтыг өөрчлөхөд хамаарах асуудлын талаарх судалгааны дүн*



Гурав.Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах тулгамдаж буй асуудлын талаарх санал асуулгад давхардсан тоогоор 120 гаруй санал ирснээс бүлэглэн авч үзвэл:

1. үйл ажиллагаа явуулахгүй байгаа хуулийн этгээдээс төлбөр гаргуулахад хүндрэлтэй байдаг;
2. хуулийн этгээд төлбөрийн чадваргүй бол үүсгэн байгуулагч нарын хөрөнгө зааглагдсан эсэхийг тодруулах гэж хугацаа алддаг;
3. шийдвэр гүйцэтгэх явцад шүүхэд хандаж ажиллагааг зогсоодог;
4. хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн банкиндах харилцах данснаас суутгал хийхэд төлбөр төлөгч этгээд бус гэсэн үндэслэлээр хасалт хийдэггүй. Компаний данс хаалттай үед үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч дансаараа компанийн гүйлгээг хийж байна;
5. төлбөр төлөгч хуулийн этгээдийн хаяг тодорхойгүй;
6. төрийн байгууллагаас төлбөр гаргуулхад төсөв байхгүй төсвийн тодотголд дараа жил суулгаж өгнө гэх тайлбар өгдөг зэрэг нийтлэг асуудлуудыг гаргасан.

**Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох арга зам:**

Судалгааны ажлын үр дүн, шийдвэр гүйцэтгэгчдээс авсан санал асуулгын хүрээнд төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах

ажиллагааг боловсронгуй болгохтой холбоотой дараах арга зам байна гэж үзлээ.

**Хуулийн этгээдийн төлбөрийг хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөнөөс гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар компанийн хувьцаа эзэмшигчээс 4 нөхцөлөөр төлбөрийг гаргуулж байна. Үүнд:

1. Компанийн хувьцааг 100 хувь эзэмшигч буюу үүсгэн байгуулагчаас нь төлбөр гаргуулах;
2. Компани өөрийн хөрөнгөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр төлбөр гаргуулах;
3. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй үндэслэлээр;
4. Компаний хувьцаа эзэмшигч компанийн хөрөнгийг өөртөө шилжүүлсэн, нуун дарагдуулсан гэсэн үндэслэлээр тус тус төлбөр гаргуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93.4-т “төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заажээ.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэхдээ дараах үе шатыг дамжин хийх ёстой:

- а. Тухайн хуулийн этгээдийг төлбөрийн бүрэн чадамжгүй болохыг бүрэн нотолсон байх;
- б. Хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагааг хийх;

Компанийн тухай хуулийн 9.3-т “хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэж заасан нь энэ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг заасан зохицуулалт байдаг. Энэ нь компанийн өрийг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх ба хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжгүй юм.

Компанийн тухай хуулийн 9.5-т “хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд

хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэж заасан.

Эндээс компанид оруулсан эд хөрөнгийг хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэдгийг тогтоох арга нь:

1.компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

2.хөрөнгийн бодит шилжилтээр тогтоох ёстой, үүнд хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөө компанийн нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэх, оруулсны дараа өөрийн хувийн хөрөнгө рүү шилжүүлээгүй байх, ноогдол ашгаас бусдаар өөртэй шилжүүлэн авах, компанийн ашиг, орлогыг хувийн дансандаа шилжүүлсэн байвал хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэх үндэслэл болно.

Компанийн хувьцаа эзэмшигч компанийн эд хөрөнгөөс хувийн эд хөрөнгөнөөс зааглаагүй тохиолдолд өөрийн хувийн эд хөрөнгөнөөс бүрэн хариуцлага хүлээнэ.

Шийдвэр гүйцэтгэгч зааглагдаагүй эд хөрөнгийг тогтоох үүргийг хүлээн төлбөрийг гаргуулах нь зүйтэй юм. Энэ үүргийг гүйцэтгэхэд санхүү, нягтлан бодох бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг шаардлагатай юм.

**Гуравдугаар бүлэг. Гадаадын зарим оронд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын онцлог**

**3.1. ОХУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог**

ОХУ-ын аж ахуйн нэгжийн хууль тогтоомж нь Оросын худалдааны хуулийн дагуу удирддаг. Энэ хууль нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж, бизнесийн үйл ажиллагаанд хууль эрх зүйн дүрэм журам, хил хязгаарыг тогтоодог. Энэ нь мөн улсад явагдаж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулдаг.

Орост үйл ажиллагаа явуулахын тулд ихэвчлэн Хязгаарлагдмал хариуцлагатай нийгэмлэг буюу ООО-г сонгож байна. Учир нь ООО нь арилжааны бүх төрлийн үйл ажиллагааг ямар нэг хязгаарлалтгүй эрхлэх боломжтой. ООО-д эзэмшиж буй хувь хэмжээ нь үнэт цаасны ойлголтод хамаардаггүй бөгөөд үнэт цаас биш юм.

Салбар /филиал/ болон ХХК /ООО/ хоорондын гол ялгаануудыг доорх хүснэгтэд харуулав.

	<b>Салбар</b>	<b>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b>
<b>Үүсгэн байгуулах онцлогууд</b>	Гадаадын хуулийн этгээдийн салшгүй бүрдэл хэсэг болно. Толгой байгууллага “Салбар”-ын үйл ажиллагааны өмнөөс шууд хариуцлага хүлээнэ.	Өөрийн үйл ажиллагааны өмнөөс хариуцлага хүлээх үүрэгтэй бие даасан хуулийн этгээд. Үүсгэн байгуулагчид оруулсан хувь хэмжээгээрээ хариуцлага хүлээнэ. Хэрэв нийгэмлэг үүсгэн байгуулагчид, эсвэл нийгэмлэгийн үйл ажиллагааг тодорхойлох болон заавал биелүүлэх үүрэг даалгавар өгөх 4 эрхтэй этгээдийн буруугаас төлбөрийн чадваргүй (дампуурах) болсон үед дээрх буруутай этгээдүүдэд нийгэмлэгийн хөрөнгөнөөс давж гарсан хариуцлагыг шилжүүлэх боломжтой.

<b>Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ</b>	141 000 рубль	4 000 рубль
<b>Бүртгэл хийх хугацаа</b>	25 ажлын өдөр	5 ажлын өдөр
<b>Компанийн удирдлага</b>	Захирал/Тэргүүн/ Удирдагч - Итгэмжлэлийн үндсэн дээр ажиллах этгээд. Гадаадын хуулийн этгээдийн зүгээс үйл ажиллагаанд нь илүү хяналт тавих боломжтой.	Ерөнхий захирал – компанийн дүрмийн дагуу итгэмжлэлгүй ажиллах этгээд. Захирлуудын зөвлөл болон үүсгэн байгуулагчдаас урьдчилан зөвшөөрөл авалгүй өргөн хүрээний үйлдэл хийх эрхтэй этгээд
<b>Хуулийн этгээдийн нэршилд тавигдах шаардлага</b>	Салбарын оноосон нэрэнд толгой байгууллагатай адил нэр, "Салбар" (Филиал) гэсэн тодотгол, бүртгэл хийсэн газар зэрэг мэдээлэл оруулсан байх ёстой.	"ООО" – ын нэрийг оноож өгөхөд ямар нэг хязгаарлалт байхгүй. ("Москва", "Россия" гэх үгсийг ашиглахад нэмэлт зөвшөөрөл авах ёстойг эс тооцвол)
<b>Санхүүжилт</b>	Толгой байгууллагаас нэмэлт баримт бичиг бүрдүүлэхгүйгээр хязгаарлалтгүй, валютын хяналтгүй мөнгөн гуйвуулга хялбар хийж болно. Мөн дээрх нөхцлөөр мөнгөн гуйвуулгыг "Салбар"-аас толгой байгууллагад хийж болно.	Нийгэмлэгийн дүрмийн санд оруулсан үүсгэн байгуулагчдын хөрөнгө (дүрмийн санг нэмэгдүүлэхэд дахин бүртгүүлэх шаардлагатай) Дүрмийн санг нэмэгдүүлэхгүйгээр эд хөрөнгөд оруулсан хувь хэмжээ /бүртгэл шаардахгүй ч нийгэмлэгийн дотоод баримт, бичигт өөрчлөлт оруулах шаардлагатай/. Нийгэмлэгийн хувь нийлүүлэгчдийн олгосон зээл Нийгэмлэгийн хувь нийлүүлэгчдийн зүгээс олгож буй санхүүгийн буцалтгүй тусламж (дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхгүй нөхцлөөр) – мөн ялгаагүй холбогдох баримт бичгийг бүрдүүлэх, валютын хяналт,

		шалгалтад оруулах шаардлагатай.
<b>Хөдөлмөрийн харилцааны онцлогууд</b>	Зохион байгуулалт-эрх зүйн хэлбэрээс үл хамааран албан хаагчидтай тогтоох хөдөлмөрийн харилцаа Оросын хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана.	
<b>Татвар</b>	Хэрэв байнгын төлөөлөгчийн газрын статустай бол Оросын Оросын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулна. 6 татварын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаанд нь татвар ногдуулна. Татвар ногдуулахтай холбоотой хэм хэмжээг олон улсын гэрээнд Оросын татварын хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээнд заасан заалтыг дагаж мөрдөнө. Оффисын түрээсийн төлбөрт НӨАТ ногдохгүй.	Оросын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулна.
<b>Санхүүгийн тайлан</b>	Өөрийн гэсэн онцлогтой санхүүгийн тайлан гаргах ёстой тул дээрх тайланг гаргах тодорхой туршлагатай нягтлан бодогч хэрэгтэй.	Үйл ажиллагааны онцлог, хэмжээнээс шалтгаална.
<b>Зардал</b>	"Салбар"-ын санхүүгийн үр дүнг тооцохдоо толгой компанийн зардлын хэсгийг ашиглаж болно.	Санхүүгийн үр дүнг тооцохдоо зөвхөн өөрийн гаргасан зардлыг ашиглана.
<b>Валютын хууль тогтоомж дахь татвар төлөгчийн харьяалал</b>	"Салбар" нь оросын валютын хууль тогтоомжийн дагуу ОХУд байрладаггүй албан татвар төлөгч юм. Тэрээр Оросын нутаг дэвсгэр дээр гадаад валют болон рублиэр орлого олж болно. ОХУ-д байрладаггүй албан татвар төлөгчтэй оросын байгууллагууд хязгаарлалтгүй валютын гүйлгээ хийх эрхтэй.	ОХУ-д байрладаг албан татвар төлөгч. ОХУ-д байрладаг албан татвар төлөгчдийн хооронд гадаад валютын гүйлгээ хориотой.



	Гадаадын компанийн салбартай хийх тооцоог гадаадын валют болон рублиэр хязгаарлалтгүй хийж болно.	
<b>Гадаадын валют</b>	Оросод бараа, үйлчилгээний борлуулалтыг рубль, гадаад валютын аль алианаар хийх боломжтой. Гадаад валютын харилцах данстай байж болно.	Оросод бараа, үйлчилгээний борлуулалтыг зөвхөн рублиэр хийнэ. Гадаад валютын харилцах данстай байж болно.
<b>Импортын үйл ажиллагаа</b>	Бүтээгдэхүүнийг нэр дээрээ хүлээн авч гэрээ байгуулан борлуулах бололцоотой. Гэхдээ бараа бүтээгдэхүүний өмчлөгч нь толгой компани байна. Салбар нь нэг агуулахаас нөгөө агуулахад шилжсэн бараа бүтээгдэхүүнийг хадгалж байгаа эзэмшигчийн эрх эдэлнэ.	Өөрөө бие даан бараа оруулах, гаалийн мэдүүлэг хийх, импортын гаалийн бүрдүүлэлт хийх боломжтой.
<b>Худалдан авах сонгон шалгаруулалт (тендер) -д оролцох</b>	Гадаадын компаниудад хязгаарлалт тавих боломжтой.	Оросын хуулийн этгээд тендерт оролцохдоо давуу эрх эдлэнэ.
<b>Тусгай зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа</b>	Тусгай зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа явуулахад "Салбар" төдийлөн тохиромжгүй.	Оросын хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг илүү хялбар авна.
<b>Татан буулгах</b>	Татан буулгах шийдвэрийг толгой байгууллага гаргана. Бодит байдал дээр "Салбар"-ыг татан буулгах нь "ООО"-г татан буулгахад шаардагддаг олон шат дамжлагагүй тул хялбар байдаг. Гэсэн хэдий ч "ООО" – г татан буулгах үед гүйцэлдүүлдэг татвар болон санхүүгийн бүрэн аудит хийх шаардлагатай бөгөөд үүнд 6	Зөвхөн хувь эзэмшигчдийн 100 хувийн саналаар ООО – г татан буулгаж болно. "Салбар"-ыг татан буулгахаас илүү шат дамжлагатай. "ООО"-г татан буулгахад 9 сараас 1.5 жилийн хугацаа ордог.

	сараас 1 жилийн хугацаа ордог.	
--	--------------------------------	--

“Салбар” (Филиал) нь бие даасан хуулийн хуулийн этгээд биш – гадаадын компанийн бүтцийн нэг нэгж юм. Толгой компанийн Орост байрлаж байгаа нэг оффис гэж үзэж болно.

Иймд, санхүү талаас авч үзвэл, толгой компанийн харилцах данснаас салбарын харилцах дансанд, эргээд мөнгөн гуйвуулга хийх тохиолдолд валютын хяналт, шалгалтын шаардлагын дагуу төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах шаардлагагүй (холбогдох хууль тогтоомжийн дагуу Оросын банкууд харилцагчдынхаа гадаад валютын гүйлгээг хийхийн өмнө баримт бичгийн тусгайлсан бүрдлийг шаардах үүрэгтэй). Бүртгэлийн процесс нь 1,5-2 сар байдаг. Филиалыг бүртгүүлэхэд нэг удаа 141.0 мянган рублийн тэмдэгтийн хураамж төлдөг.

Хязгаарлагдмал хариуцлагатай нийгэмлэг (“ООО”) Ихэнх тохиолдолд “ООО” – ын хувь эзэмшигчдийн (Оросын болон гадаадын хувь хүн, хуулийн этгээдүүд байж болно) хариуцлага нь Нийгэмлэг дэх дүрмийн сангийн хэмжээгээр хязгаарлагдана. Дүрмийн сангийн зөвшөөрөгдөх доод хэмжээ 10.0 мянган рубль байна (Хуурамч компани - “однодневок” – үүдийг илрүүлэх, сэжигтэй мөнгөн гүйлгээний мониторинг хийхэд хэрэглэдэг шалгуур үзүүлэлтүүдийг баримжаалж ажилладаг татварын байгууллага болон банкуудад итгэл, үнэмшилтэй харагдах, үйл ажиллагааны эхлэлийн зардлыг гаргахад хангалттай байхын тулд дүрмийн санг дор хаяж 100.0 мянган рублиэр бүрдүүлэхийг санал болгож байна).

“ООО” нь бизнес, арилжааны үйл ажиллагааг хязгаарлалтгүй явуулж, гаалийн байгууллагатай шууд харилцаж, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл авах боломжтой. Бие даасан хуулийн этгээд тул түүний үйл ажиллагааны зардлыг дүрмийн сангийн хөрөнгийг ашиглах, эсвэл гэрээ байгуулах замаар шийдэж болно. Оросын болон дурын гадаадын компани хоорондын хэлцэл валютын хяналтын байгууллагаар зохицуулагддаг бөгөөд зарим шалгуурын дагуу Нийгэмлэг ийм гэрээг банкинд бүртгүүлэх шаардлагатай.

Оросын хөдөлмөрийн хууль, тогтоомжид “ООО” ба “Салбар”-т хамаарах зүйл, заалт хоорондоо ижил төстэй бөгөөд тэдгээрийн аль аль нь оросын болон гадаадын иргэдийг хөлсөөр ажиллуулахыг зөвшөөрдөг.

“ООО” болон “Салбар”-т гадаадын иргэнийг ажилд авахын тулд хөдөлмөрлөх эрхийн зөвшөөрөл авах шаардлагатай. Орост ажиллах эрхийн хоёр төрлийн зөвшөөрөл байдаг:

1. Энгийн
2. Өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийн хувьд (ӨММ)

Ажиллах эрхийн энгийн зөвшөөрлийг зөвхөн нэг жилийн хугацаатай олгодог. Өндөр мэргэшсэн мэргэжилтний ажиллах эрхийн зөвшөөрөл олголтын шат дамжлага, процедурыг хялбаршуулж, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг 3 жил болгосон. Ажил олгогч ӨММ-ний зөвшөөрөлтэй ажилтны цалингаас даатгалын хураамж төлөхгүй. Өндөр мэргэшсэн мэргэжилтэн – ажилтны хувь хүний орлогын албан 10 татварын хэмжээ ОХУ-д байсан хугацаанаас үл хамааран 13%-тай тэнцэнэ. (ОХУ-д хагас жилээс илүүгүй амьдарсан энгийн ажиллах зөвшөөрөл бүхий ажилтанд хамаарах хувь хүний орлогын албан татварын хэмжээ 30% байна). Өндөр мэргэшсэн мэргэжилтэнд зориулсан зөвшөөрлийг авах үндсэн нөхцөл нь түүнд олгох нэг жилийн хөдөлмөрийн хөлс 2.0 сая рублиэс багагүй байх юм.

“Салбар” (Филиал) – ашгийн татвар 20%, НӨАТ нийтлэг байдлаар төлнө. Даатгалын сангууд болон үл хөдлөх хөрөнгийн татварыг нийтлэг байдлаар төлнө.

“Охин компани” – Татварын ямар горим сонгосноос шалтгаалж нийтлэг байдлаар татвар төлнө (ТХГ – татварын хялбаршуулсан горим 6%, зарим төрлийн үйл ажиллагаанд хамаарах жишиг орлогод суурилсан нийтлэг татвар 15%)<sup>40</sup>

Гадаадын компани, хуулийн этгээдийн байгуулж буй ООО-ын бүртгэлийн онцлогууд

ООО – г үүсгэн байгуулагч нь гадаадын иргэн, хуулийн этгээдийн аль аль нь байж болно.

Гадаадын иргэн “ООО”-ын үүсгэн байгуулагч болохын тулд орос үүсгэн байгуулагчтай ижил, төстэй багц баримт, бичиг бүрдүүлнэ.

- Байгуулахаар төлөвлөж буй хуулийн этгээдийн товчилсон, дэлгэрэнгүй нэр

- Дүрмийн санг бүрдүүлэх хэлбэр, хэмжээ, хувь нийлүүлэгчдийн эзлэх хувь

---

<sup>40</sup><https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2020/12/22/nehk8518eura4sgy/medeenii-havsralt.pdf>

- Компанийн дүрмийн санг цаашид ямар аргаар нэмэгдүүлэх тухай мэдээлэл

- ОКВЭД кодыг тусгасан үйл ажиллагааг сонгосон байх

- Компанийн хууль ёсны хаяг

- Банкны реквизит

- Ерөнхий захирал, ерөнхий нягтлангийн татвар төлөгчийн бүртгэлийн дугаарын тодорхойлолтын хуулбар

- Ерөнхий нягтлан, Ерөнхий захирлын паспортын хуулбар (хэрэв тэд ОХУ-ын иргэн бол)

- Хуулийн этгээдийг Р11001 формын дагуу улсын бүртгэлд оруулахыг хүссэн өргөдөл (холбогдох хуулийн дагуу зөвхөн орос хэл дээр)

- Үүсгэн байгуулагчдын хурлын протокол (иргэншлээс үл хамааран бүх үүсгэн байгуулагчид оролцсон байх) эсвэл цорын ганц үүсгэн байгуулагчийн шийдвэр

- “ООО” байгуулах тухай гэрээ (ганц үүсгэн байгуулагчтай бол шаардлагагүй)

- “ООО” – г үүсгэн байгуулах гол баримт бичиг

- Хязгаарлагдмал хариуцлагатай нийгэмлэг (“ООО”) - ийн Дүрэм.

- Татварын хялбаршуулсан системийг анхнаасаа сонгох хэрэгтэй гэж үзвэл бүртгэлийг хийх шатанд мэдэгдэл бэлдэх. Тус мэдэгдлийг татварын байгууллагад бусад бүх баримт бичгийн хамт танилцуулах.

“ООО” – г бүртгэх явцад үүсгэн байгуулагчийн статусаас шалтгаалан зарим нэмэлт баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай болж болно. Тухайлбал доорх хувилбар байж болох юм.

- “ООО” – г үүсгэн байгуулагчийн аль нэг нь гадаадын иргэн

- “ООО” – ын цорын ганц үүсгэн байгуулагч нь гадаадын иргэн

Гадаад үүсгэн байгуулагчийн хувьд ямар нэг тусгайлсан хязгаарлалтгүйгээр гадаадын иргэн болон гадаадын байгууллага байж болно. Гадаадын хуулийн этгээдийн “ООО” байгууллагын үйл ажиллагаанд оролцохтой холбоотой эрхийг ОХУ-ын нутаг дэвсгэр дээр ямар нэг байдлаар хязгаарлаагүй (Тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулсан салбаруудын үйл ажиллагааг эс тооцвол).

ОХУ-ын Гүйцэтгэх ажиллагааны тухай холбооны хууль

Энэхүү хууль 19 бүлэг, 130 зүйлтэй бөгөөд 2007 онд ОХУ-ын Төрийн Думаар баталж, 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Гүйцэтгэх ажиллагааны зорилгыг тус хуулийн нэгдүгээр бүлгийн хоёрдугаар зүйлд "...шүүхийн шийдвэр, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг, мөн Оросын Холбооны Улсын хуульд заасан тохиолдолд зөрчигдсөн эрх, эрх чөлөө, иргэд байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг зөв, шуурхай гүйцэтгэхэд оршино" хэмээн тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг Холбооны энэхүү хуульд заасан журмын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Холбооны алба, түүний орон нутгийн байгууллага биелүүлнэ. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг төрийн болон орон нутгийн өөрөө удирдах бүх байгууллага, иргэд, бусад байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дээр хэлбэрэлтгүй сахин мөрдөнө.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, түүнчлэн шүүхийн шийдвэр, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг биелүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь саад хийсэн бол Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээдэг.

Төлбөр төлөгч хуулийн этгээд бол түүний албан ёсны хаяг, эд хөрөнгө байгаа газар буюу түүний төлөөлөгчийн газар, салбарын байгаа газар гүйцэтгэх үйл ажиллагааг явуулж, албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэглэхээр харъяаллыг тогтоосон байна.

Нэхэмжлэгч ба хариуцагчаар иргэн буюу байгууллага, мөн түүнчлэн хуулийн этгээд бус иргэдийн нэгдэл байж болно. Дурдсан нэгдэлд Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Холбооны энэхүү хуулийн гүйцэтгэх ажиллагаанд байгууллагын оролцоог тодорхойлсон хэм хэмжээг хэрэглэнэ.

Гүйцэтгэх үйл ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс Холбооны энэ хуульд зааснаар албадан гүйцэтгэх арга хэмжээг хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх, мөн хариуцагчаас гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг бүрэн дүүрэн, үнэн зөв, түргэн шуурхай биелүүлэхэд албадахад чиглүүлэн явуулж байгаа үйл ажиллагаа юм.

Албадан гүйцэтгэх арга хэмжээ нь гүйцэтгэх баримт бичигт заасан үйл ажиллагаа буюу гүйцэтгэх баримт бичгээр нэхэмжилж байгаа эд хөрөнгө, түүний дотор мөнгөн хөрөнгийг хариуцагчаас гаргуулах зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг ойлгоно. Албадан гүйцэтгэх арга хэмжээг гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг явуулна.

Хэрэв Холбооны хуулийн дагуу гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дураар биелүүлэх хугацааг заасан бол албадан гүйцэтгэх арга хэмжээг тухайн хугацаа дуссаны дараа хэрэглэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь дараах гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах эрхтэй: (2011.12.03-нд Холбооны ХХ-№ 389 хуулиар өөрчлөлт орсон)

1) гүйцэтгэх ажиллагааны талуудыг (тэдгээрийн төлөөлөгчдийг), Оросын Холбооны Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд бусад этгээдийг дуудан ирүүлэх;

2) шаардлагатай мэдээлэл, түүний дотор Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дээр, мөн түүнчлэн Оросын Холбооны Улсын олон улсын гэрээгээр тогтоосон журмаар гадаад улсын нутаг дэвсгэрт оршиж байгаа хувь хүн, байгууллага, албан газрын хувийн мэдээлэл гаргуулан авах, тэднээс тайлбар, мэдээ, лавлагаа авах; (2010.07.27-нд Холбооны ХХ-№213 хуулиар өөрчилөн найруулсан)

3) үзлэг, түүний дотор гүйцэтгэх баримт бичгийн талаарх санхүүгийн баримт бичигт үзлэг хийх;

4) гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэх талаар хувь хүн, хуулийн этгээдэд даалгавар өгөх;

5) гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх зорилгоор хариуцагч буюу бусад этгээдийн эзэмшилд байгаа эсхүл хариуцагч буюу бусад этгээдэд хамаарах орон сууцны бус байр тасалгаа, зоорьд нэвтэрч орох;

6) шүүхийн ахлах гүйцэтгэгчийн бичгийн хэлбэрээр өгсөн зөвшөөрлөөр (нэхэмжлэгчийг нүүлгэн шилжүүлэх буюу хариуцагчийг нүүлгэн шилжүүлэх тухай гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэх тохиолдолд –заасан зөвшөөрлийг авахгүйгээр) хариуцагчийн зөвшөөрөлгүйгээр хариуцагчийн байгаа орон сууцад нэвтрэн орох;

7) гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг түүний дотор мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг битүүмжлэх заасан эд хөрөнгийг хураан авах, хураан авсан болон битүүмжилсэн эд хөрөнгийг хадгалуулахаар шилжүүлэх;

8) Холбооны энэхүү хуулиар тогтоосон журам, хүрээнд эд хөрөнгийг үнэлэх;

9) Үнэлгээний хийх үйл ажиллагааны тухай Оросын Холбооны Улсын зохих хууль тогтоомжийн шаардлагаар эд хөрөнгийг үнэлүүлэхээр мэргэжилтнийг (цаашид үнэлгээчин гэх) татан оролцуулах;

10) хариуцагч, түүний эд хөрөнгө, хүүхдийг эрэн сурвалжлах ажиллагааг бие даан явуулах буюу дотоод хэргийн байгууллагуудыг татан оролцуулах;

11) гүйцэтгэх ажиллагааны талуудаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;

12) гүйцэтгэх ажиллагааны талууд болон гүйцэтгэх ажиллагаанд оролцогч бусад этгээдийн өргөдөл хүсэлтийг хянан шийдвэрлэх;

13) гүйцэтгэлийн хураамжийг нэхэмжлэх; (2011.07.18-нд Холбооны ХХ-№225 хуулиар өөрчлөлт орсон)

14) Холбооны энэхүү хуулиар тогтоосон тохиолдол болон журмаар хариуцагчид хамаарах эд хөрөнгийг түүний нэр дээр бүртгүүлэхийн тулд эд хөрөнгийн төрийн бүртгэлийг эрхлэх, эд хөрөнгөтэй холбоотой хэлцэл хийх байгууллагад (цаашид бүртгэх байгууллага гэх) хандах;

15) Хариуцагчийг Оросын Холбооны Улсаас гарч явахыг түр хугацаагаар хязгаарлах;

16) шүүхийн шийдвэр, бусад байгууллага буюу албан тушаалтны шийдвэрийн дагуу нэхэмжлэгчийн хүсэлтээр болон өөрийн санаачлагаар мөнгөн хөрөнгийн тооцоо, суутгалын үнэн зөв эсэхэд үзлэг шалгалт хийх. Холбооны энэхүү хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар байгууллага буюу бусад этгээдэд тийм шалгалтыг хийх явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид зохих нягтлан бодох бүртгэлийн болон бусад баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй;

17) Гүцэтгэх баримт бичгийг түргэн шуурхай, бүрэн дүүрэн, үнэн зөв гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагаа явуулах зэрэг болно.

Үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлэх үйл ажиллагаа нь хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд, хуулийн этгээд, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, бүтэц нэгж, үйлдвэрлэх хэсгийн үйл ажиллагааг, мөн түүнчлэн объект, цогцолбор, барилга буюу байгууламж ашиглах, зарим төрлийн ажиллагаа (ажил хийх) явуулах, үйлчилгээ үзүүлэхийг түр зогсооход оршино.

Үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлэх тухай гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэх явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь хариуцагчийн касс, эд бараа болон бусад материал баялгийг хадгалах газрыг битүүмжилж, лацдах буюу үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлэх бусад арга хэмжээг хэрэглэнэ. Үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлэхэд хөндлөнгийн гэрчийг (шаардлагатай тохиолдолд дотоод хэргийн байгууллагын ажилтнуудтай хамтран) оролцуулж акт үйлдэж хэрэгжүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь үйл ажиллагааг захиргааны журмаар түдгэлзүүлсэн хугацаа дуусахаас өмнө хариуцагч үйл ажиллагааг сэргээсэн

тохиолдолд хариуцагчид Холбооны энэхүү хуульд заасан арга хэмжээг хэрэглэх, Захиргааны зөрчлийн тухай Оросын Холбооны Улсын хуульд зааснаар хариуцагчид захиргааны зөрчлийн тухай протокол үйлдэх эрхтэй.

Шийдвэр гүйцэтгэх ажилагаанд оролцогчийн аль нэг нь гарсан тохиолдолд /иргэн нас барсан, байгууллага татан буугдсан, шаардах эрхгүй болсон, өр шилжсэн болон бусад/ шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр, бусад байгууллага буюу албан тушаалтны шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэх ажиллагааны энэ талыг түүний эрх залгамжлагчаар сольж болохоор зохицуулсан байна.

Харин эрх залгамжлагчийн хувьд гүйцэтгэх ажиллагаанд орохын өмнө явагдсан бүхий л ажиллагаа нь эрх залгамжлагчид гүйцэтгэх ажиллагааны талуудад байх тэр хэмжээгээр мөн адил хамаарна.

Төлбөр төлөгч хуулийн этгээд гүйцэтгэх ажиллагаанд оролцохдоо холбооны хууль, эрх зүйн баримт бичиг болон үүсгэн байгуулах баримт бичгээр олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий өөрийн нэгж буюу албан тушаалаар, эсхүл бусад төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрх нээлттэй. Ингэж оролцохдоо байгууллага, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах байгууллагын удирдагчийн бүрэн эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид танилцуулсан, тэдний албан тушаалын байдлыг нотолсон баримт бичиг, мөн үүсгэн байгуулах болон бусад баримт бичгээр баталгаажуулж, байгууллагын нэрийн өмнөөс өөр этгээдэд олгосон итгэмжлэлд удирдагч буюу тэр этгээдээс эрх олгосон этгээд гарын үсэг зурж, тамга дарсан байна.

Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах албадан ажиллагааны төрөлд:

1) Хариуцагчийн эд хөрөнгө, түүний дотор мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг нэхэмжлэн халдах

2) Хариуцагчийн хөдөлмөрийн, иргэний эрх зүйн буюу нийгмийн эрх зүйн харилцааны улмаас олж авсан тогтмол орлогод нэхэмжлэн халдах

3) Хариуцагчийн эд хөрөнгийн эрхүүдэд, түүний дотор нэхэмжлэгчийн хувьд оролцож байгаа гүйцэтгэх ажиллагаанаас төлбөр авах эрх, түрээслэх, хөлслөх талаар төлбөр авах эрх, мөн түүнчлэн оюуны үйл ажиллагаа болон бодгаль хэрэгслийн үр дүнгийн онцгой эрхийг борлуулах буюу ашиглах тухай гэрээгээр шаардах эрх, хариуцагчид тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хамаарах оюуны үйл ажиллагаа болон бодгаль хэрэгслийн үр дүнг ашиглах эрхэд нэхэмжлэн халдах



4) Хариуцагчийн эд хөрөнгийг нэхэмжлэгчид олгохоор, мөн түүнчлэн холбооны хуульд заасан тохиолдолд нотариатын гүйцэтгэх бичгээр хураан авах

5) Эд хөрөнгө битүүмжлэх тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад хариуцагч буюу гуравдагч этгээдэд байгаа эд хөрөнгийг битүүмжлэх

6) Холбооны энэхүү хуульд заасан жураар хариуцагчаас нэхэмжлэгчдэд хөрөнгийн эрх, түүний дотор үнэт цаасны эрхийг шилжсэнийг бүртгүүлээхийн тулд бүртгэлийн байгууллагад халдах

7) Хэрэв гүйцэтгэх баримт бичигт заасан үйл ажиллагааг хариуцагчийг биечлэн оролцуулахгүйгээр явуулах боломжтой тохиолдолд энэхүү үйл ажиллагааг хариуцагчийн нэрийн өмнөөс буюу түүнийг төлөөлөн явуулах

8) Нэхэмжлэгчийг орон сууцанд албадан оруулах

9) Хариуцагчийг орон сууцнаас албадан гаргах

10) Хариуцагч, түүний эд хөрөнгө түр байрлаж байгаа орон сууцны зориулалтын бус байр, зоорийг чөлөөлөх

10.1) Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Оросын Холбооны Улсын гадна албадан гаргах

11) Холбооны хууль буюу гүйцэтгэх баримт бичигт заасан үйл ажиллагаа зэрэг багтахаар хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн гол үүрэг бол батлагдсан шүүхийн шийдвэрийн дагуу төлбөрийг бүрэн хэмжээгээр барагдуулах явдал юм. Шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа нь "Өр барагдуулах журам"-ын хүрээнд явагддаг<sup>41</sup>.

Энэ ажиллагааны үед шүүхийн шийдвэр гүйцэтгэгч дангаараа ажилладаггүй, харин хариуцагчтай хамтарч ажилладаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хэд хэдэн үе шат, дарааллаар явагддаг. Энэ нь:

1. Нэхэмжлэгчээс гүйцэтгэх хуудас эсвэл өргөдөл авах,
2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэх тухай тогтоол гаргах,
3. Шийдвэрийн талаар хариуцагч болон нэхэмжлэгчид чиглэл өгөх,
4. Өр төлбөрийг сайн дураар төлөхийг хүлээх,
5. Хариуцагчийн данс, эд хөрөнгийг мөрдөх,
6. Албадан гаргуулах гэсэн үе шаттайгаар зохион байгуулагддаг байна.

Төлбөр төлөгчийн өмч хөрөнгийг олохын тулд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид өөрсдийн бүрэн эрхээ ашиглаж, кадастр, замын цагдаа,

---

<sup>41</sup> <https://bankirro.ru/kollektory-i-pristavy/kak-rabotayut-sudebnye-pristavy/>

Ростехнадзор, Холбооны татварын алба руу лавлагаа илгээдэг. Ийм байдлаар эзэмшилд буй орон сууц, байшин, газар, автомашин, данс, хувьцааны талаар тодорхой мэдээлэлтэй болно.

Эд хөрөнгө илэрсний дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид аюулгүй байдлыг нь хангах ёстой. Эдгээр нь төлбөрийг эд хөрөнгийг нь зарах, хандивлах, өөр хэлбэрээр нуух, захиран зарцуулахаас урьдчилан сэргийлдэг.

Төлбөр төлөгчийн төлөх төлбөрийн хэмжээ нь одоо байгаа хөрөнгө, тогтмол орлого, албадан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн зардлаар хийгддэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас дээр хэрхэн ажилладагийг хуулиар тогтоодог. Төлбөр төлөгчийн бүхий л орлогоос суутгал хийхийг зөршөөрдөг.

Төлбөр төлөгч нь мөн шүүхийн төлбөрийг нөхөн төлдөг. Төлбөр төлөгч төлбөрийн дүнгийн 7 хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг төлнө. Мөн дампуурлын үед төлбөр гаргуулах ажиллагааг түр зогсоох боломжийг олгодог байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн боломж хязгааргүй биш бөгөөд өр барагдуулах журмыг хуулиар тодорхой зохицуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид дараах зүйлийг хийж болно.

-Төлбөр төлөгчийн бүхий л орлогоос төлбөр гаргуулах, гэхдээ орлогын 50 хувиас хэтрүүлэхгүй байх,

-Эд хөрөнгийг хураах, хураагдсан эд хөрөнгийг битүүмжилж, хамгаалах,

-Эд хөрөнгийг дуудлага худалдаагаар зарах,

-Шүүхийн шийдвэрийн дагуу өр төлбөрт шилжүүлсэн эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх,

-Хариуцагчийн эд хөрөнгө, түүний дотор хувьцаа, үнэт цаасыг хураах, захиран зарцуулах,

-Зорчих эрхийг хязгаарлах,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг боловсруулж, өр төлбөр, нөхөн төлөгчдөд өгөх, хувийн мэдээлэлтэй ажиллах, талуудын ирж буй хүсэлтийг харгалзан үзэх, дээд байгууллагад тайлагнах, мөн төлбөр гаргуулах ажиллагааны явцад эд хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааг явуулна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн бүрэн эрхэд хамтын өмчлөлтэй эд хөрөнгө ч мөн хамаатай. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн төлбөр гаргуулах ажиллагаанд хамаарах эд хөрөнгийн жагсаалт хэд хэдэн хуудас болно.

### **3.2. БНХАУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог**

“БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрэм”-ийг 1986 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Зургадугаар хугацааны бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурлын Дөрөвдүгээр хуралдаанаас 9 бүлэг, 19 хэсэг, 156 зүйл бүхий бүтэц бүрэлдэхүүнтэй баталжээ. Дүрмийн бүлэг, хэсгийн эрэмбэ дараалал нь:

Үндсэн дүрэм буюу нэгдүгээр бүлэг нь иргэний хуулийн ерөнхий дүрмийн зохицуулах зүйл, онцлог, зарчим, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүргийн тухай ерөнхий бөгөөд нийтлэг зүйлийг заажээ.

Ард, иргэн гэсэн хоёрдугаар бүлэгт: иргэдийн иргэний эрх зүйн чадвар, уг чадвараа биеэрээ хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрэн чадвар, хязгаарлагдмал чадвар, чадваргүй гэж ангилсан байдал, харгалзан хамгаалах, харгалзан хамгаалагч, хамгаалуулагчийн эрх зүйн байдал, алга болсон ба үхсэнээр нийтлэх, иргэдийн өмчлөх эрхийн талаар заасан.

Хуулийн эрхтэн гэсэн гуравдугаар бүлэгт. хуулийн эрхтэний (хуулийн этгээд) үндсэн шинж, тодорхойлолт, хуулийн эрхтэний ангилал, тухайлбал, аж ахуйллын хуулийн эрхтэн, байгууллага, ажил үйлсийн нэгж ба нийгмийн бүлгэмийн хуулийн эрхтэн, холбоолон эзэглэх (аж ахуйг хамтран эрхлэх) зэрэг асуудлыг заажээ.

Иргэний хэргийн хууль цаазын үйл ажиллагаа ба орлох гэсэн дөрөвдүгээр бүлэгт: иргэн, хуулийн эрхтэний хууль цаазын үйл ажиллагаа ба иргэний эрх, үүргийг тогтоох, хувируулах, (өөрчлөх), дуусгах ажиллагаа, иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, хуулийн эрхтэнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах журам, орлох (төлөөлөх) журам, орлогч ба орлуулагчийн эрх, үүрэг, хариуцлагын тухай заалт байна.

Иргэний хэргийн эрх гэсэн тавдугаар бүлэгт: эд хөрөнгийн ба эд хөрөнгөтэй холбогдох эрх, өмчлөгч эд хөрөнгөө өмчлөх, хэрэглэх, ашиг тусыг хүртэх, шийдвэрлэх эрхтэй болох, авцааны эрх, өөрөөр хэлбэл авцаатан (үүрэг гүйцэтгүүлэгч), өгцөөтөн (үүрэг гүйцэтгэгч) хоёрын харилцан хүлээсэн эрх, үүрэг, хүний биеийн эрх (амины эрх), тухайлбал, овог нэр, биеийн хөрөг, нэр төр, алдар хүнд, ураглах эрх зэрэг асуудлыг хамааруулжээ.

Иргэний хэргийн хариуцлага гэсэн зургадугаар бүлэгт: иргэн, хуулийн эрхтэн гэрээ буюу бусад харилцааг зөрчсөн бол хууль ёсоор хариуцлага хүлээх, бусдын биеийн эрхэд халдсан бол учирсан хохирлыг төлөх, хариуцлага хүлээлгэх арга, хэлбэр гэх мэт асуудал хамаарч байна.

Заргын хүчин бүхий хугацаа гэсэн долдугаар бүлэгт: иргэн, хуулийн эрхтэн эд хөрөнгийн ба хуний биеийн эрх зөрчигдсөнөө хамгаалуулахаар ардын шүүх хороонд заалдлага хийх хоёр жил, хүний биеийн эрхтэн шархдсан, чанаргүй бараа худалдсан, түрээсийн мөнгө төлөөгүй, хадгалуулсан бараа үрэгдэж устсан гэх мэт зөрчлөөс үүссэн хохирол нэхэх хугацаа нэг жил, заргын хугацаа тасалдах, түр зогсох зэрэг харилцааг зохицуулсан байна.

Гадаадад холбогдох иргэний хэргийн харьцаанд тохирох хууль цааз буюу наймдугаар бүлэгт: БНХАУ-ын иргэн, хуулийн эрхтэн өөрийн буюу гадаадын нутаг дэвсгэрт гадаадын эрх зүйн этгээдтэй холбогдож үүссэн маргааныг аль улсын шүүх болон хөндлөнгөөс таслах шүүх (арбитр)-д хандаж гүйчлал (хүсэлт) гаргах журмыг хуульчилжээ.

Дагалдуулал дүрэм (бусад зүйл) буюу есдүгээр бүлэгт: Үндэстний өөртөө засах орны ардын төлөөлөгчдийн их хурал энэхүү дүрмийг үндэслэн тухайн орны өвөрмөц онцлогт нийцсэн зохицуулсан буюу нөхвөрлөсөн тусгай эрх зүйн тогтоол батлан мөрдөж болох, тэгэхдээ төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан байх, иргэний хуулийн ерөнхий дүрмийн заалтыг буцаан хэрэглэх, дагаж мөрдөх цаг хугацааг заажээ.

“Монгол Улсын иргэний хууль”-ийг 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаас 6 хэсэг, 11 дэд хэсэг, 63 бүлэг, 552 зүйл бүхий бүтэцтэй баталсан бөгөөд хэсэг, бүлэг, зүйлийн эрэмбэ дарааллыг хураангуйлан үзвэл: (8.7)

1 дүгээр хэсэг буюу Ерөнхий үндэслэлд: Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, тухайн харилцаанд оролцогч, иргэн, хуулийн этгээд үүргийн хэрэгжүүлэх, хэлцэл, хүчин төгөлдөр бус хэлцэл, төлөөлөл, иргэний эрх зүй дэх хугацаа, хөөн хэлэлцэх хугацаа, эдийн болон эдийн бус баялгийн эрх, өмч, өмчлөх эрх үүсэх үндэслэл, барьцааны эрх;

2 дугаар хэсэг буюу үүргийн эрхэд: Үүргийн тухай ерөнхий үндэслэл, үүрэг үүсэх үндэслэл, үүрэг гүйцэтгэх журам, арга, хугацаа, гэрээний ойлголт, гэрээ байгуулах, биелүүлэх журам, гэрээний стандарт нөхцөл, гэм хор, бусдад учруулсан эдийн ба сэтгэл санааны хохирлыг арилгах журам, иргэний эрх зүй дэх хариуцлага, түүний төрөл, хэлбэр;

3 дугаар хэсэг буюу гэрээний эрх зүйд: Бусдын өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон үүрэг, бусдын эзэмшил, ашиглалтад эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг гэсэн хоёр дэд хэсэгт ангилж төрөл бүрийн гэрээний тус бүрийн онцлогийг заасан байна;

4 дүгээр хэсэг буюу гэрээний бус үүрэгт: Дундын өмчлөлөөс үүсэх үүрэг, бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, гэмт хор учруулснаас үүсэх үүрэг, хариуцлага хүлээлгэх үндэслэл;

5 дугаар хэсэг буюу өвлөх эрхэд: өв өвлөх журам, хуульд зааснаар ба пэрээслэлээр өвлөх, өвлөгдөх эд хөрөнгийг хуваарилах, өв хүлээн авах журам, өвлөгдөх хөрөнгийг хамгаалах,

6 дугаар хэсэг буюу олон улсын иргэний эрх зүй хэсэгт: олон улсын гэрээ, гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх, олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадвар, чадамж, өмчлөх эрх, хэлцэл, гэм хор учруулснаас Үүсэх үүрэг, залгамжлахад хууль хэрэглэх журам зэргийг заажээ.

Дээрх хоёр хуулийн бүтэц, бүрэлдэхүүнийг харьцуулан үзвэл: БНХАУ-ын иргэний хуулийн бүтэц, түүний бүлэг, зүйлийн үзэл баримтлал, зарчмын язгуур асуудлыг ерөнхийд нь хуульчлан тогтоогоод, түүндээ тулгуурлан холбогдох харилцааг зохицуулсан хуулиудыг тусгайд нь бүр нарийвчлан зааж, батлан мөрдөж байгаагаар Монгол улсын иргэний хуулиас онцлог ялгаатай байна. Ийм учраас Хятад улс “Иргэний хуулийн ерөнхий дүрэм” гэж нэрлэсний учир оршино.

Монгол улсын Иргэний хуульд гэрээний ба гэрээний бус үүргийг бүхэлд нь нэрлэн зааж системчилсэн байдаг бол Хятад улсын иргэний хуульд гэрээний талаар зарчмын үндсэн асуудлыг заагаад 1999 онд 23 бүлэг, 428 зүйл бүхий “БНХАУ-ын гэрээний хууль”-ийг тусгайд нь бие даасан хууль болгон баталсан онцлогтой байна.

Гэрээний хуулийн ерөнхий дүрэм нь 1. Ерөнхий тогтоол; 2. Гэрээ тогтоох; 3. Гэрээний хүчин; 4. Гэрээг гүйцэтгэх; 5. Гэрээг хувируулах буюу шилжүүлж өгөх; 6. Гэрээний эрх ба үүрэг дуусах; 7. Болзоог зөрчсөн гэрээний хариуцлага; 8. Бусад тогтоолууд, Хуваарь дүрэм нь. 9. Наймаалах гэрээ; 10. Цахилгаан, ус, хий, элчийн хүчин хангах ба хэрэглэх гэрээ; 11. Бэлэглэж өгөх гэрээ; 12. Зоос зээлэх гэрээ; 13. Түрээслэх гэрээ; 14. Бэл тохируулгын түрээсийн гэрээ; 15. Даан авах гэрээ; 16. Бүтээн байгуулалтын барилгын гэрээ; 17. Тээврийн гэрээ; 18. Техник мэргэжлийн гэрээ; 19. Хадгалан хамгаалах гэрээ; 20. Хөмрөглөн хадгалах гэрээ; 21. Найдлагын гэрээ; 22. Зуучлах гэрээ; 23. зохицуулах гэрээ гэсэн бүлгүүдтэй, бүлгүүд нь хэсэг, зүйлээс бүрджээ.

Монгол Улсын Иргэний хуулийн “Эдийн ба эдийн бус баялгийн эрх” хэмээх 5 дугаар дэд хэсгийн 10, 11, 12 дугаар бүлэгт өмч, өмчлөх эрхийн

тухай дэлгэрэнгүй заасан бол БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрэмд өмчийн эрхийн талаар ерөнхий зарчим, зорилгыг товч заагаад "БНХАУ-ын бодисын эрхийн хууль"-ийг 2007 онд 5 анги 19 бүлэг 20 хэсэг 229 зүйл бүхий бүтэцтэй батлав.

Бодисын хууль. 1. Ерөнхий дүрэм; 2. Өмчлөлийн эрх; 3. Хэрэглэж ашиг олох бодисын эрх; 4. Батлан даах бодисын эрх; 5. Эзлэх гэсэн таван ангийн доторх хэсэг, бүлэг, зүйл заалтын агуулгыг товчлон хэлбэл бодисын эрхийг тогтоох, өөрчлөх, бусдад шилжүүлэн өгөх ба үгүйсгэх, үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх журам, улсын ба хамтран өмчлөх газар, шороо, үйлдвэр, худалдааны байгууллага, орон сууцыг эзэмших, ашиглах, барьцаалах, газар тариаг даачлан эзэгнэх зэрэг олон асуудлыг нарийвчлан дэлгэрэнгүй заасан байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 5 дугаар хэсэгт өв залгамжлалын харилцааг бүхэлд нь системчлэн зохицуулсан. Тухайлбал, өвлөх (53-р зүйл), хуульд зааснаар өвлөх (54-р зүйл), гэрээслэлээр өвлөх (55-р зүйл), өв хүлээн авах ба татгалзах (56-р зүйл), өвлөх эд хөрөнгийн хэмжээ (57-р зүйл), өвлөх эд хөрөнгийг хариуцах (58-р зүйл), өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах (59-р зүйл) гэсэн заалтыг багтаасан.

Харин БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрэмд өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт байдаггүй. 1985 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хугацааны бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурлын гуравдугаар их хуралдаанаас 5 бүлэг 37 зүйлтэй "БНХАУ-ын өв залгамжлах хууль"-ийг баталсан (9.237) бөгөөд уг хууль нь: 1. Ерөнхий дүрэм; 2. Хуульд тогтоосон өв залгамжлал; 3. Гэрээслэлээр өв залгамжлах; 4. Өв хөрөнгийг шийдвэрлэх; 5. Дагалдуулсан дүрэм гэсэн бүлэг, зүйлээс бүрджээ.

Монгол улсын Иргэний хуулийн 5 дугаар хэсэгт "Гэр бүлийн эд хөрөнгийн эрх" гэсэн бүлэгт гэр бүлийн эд хөрөнгө үүсэх үндэслэл, түүний эрх зүйн зохицуулалт, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран ба хэсгээр өмчлөх эд хөрөнгө, тэдгээрийг тодорхойлох хийгээд захиран зарцуулах нөхцөл журам, гэрлэлт цуцлахад эд хөрөнгийг хуваах арга, хэлбэр зэрэг гэр бүл дэх эд хөрөнгө өмчлөхтэй холбогдох харилцааг нэлээд дэлгэрэнгүй заасан. Харин Монгол улсын Гэр бүлийн хуульд гэр бүлийн эд хөрөнгийн талаар тусгайлан зориуд заасан зүйл байхгүй бөгөөд гэр бүлийн эд хөрөнгийн харилцаа, түүнтэй холбогдон үүссэн маргааныг Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар зохицуулна.

БНХАУ-ын хувьд гэр бүл дэх эд хөрөнгийн эрх, ер нь гэр бүлийн бүх харилцааг "БНХАУ-ын Ургийн хууль"-иар зохицуулсан нь онцлог юм. Энэ

хуулийг 2001 онд баталсан бөгөөд хууль нь ерөнхий дүрэм, ураг барилдах, гэр бүлийн харилцаа, ураг салах, авран туслах арга хэмжээ хийгээд хуулийн хариуцлага, дагалдуулсан дүрэм гэсэн зургаан бүлгээс бүрджээ.

Ийнхүү Монгол, Хятад улсын иргэний хуулийн бүтэц, бүрэлдэхүүн, хэлбэр тогтолцооны хувьд дээр дурдсан онцлог ялгаанууд байгаа боловч хоёр гүрний төр, засгийн бодлого, түүнийг амьдралд хэрэгжүүлэх хуулийн зорилго, чиглэл, баримтлах зарчим нь эцсийн бүлэгт ард түмний амьдралыг сайн сайхан болгох, иргэн, хуулийн этгээд, төрийн өмчлөх эрхийг хамгаалан бэхжүүлэх, гадаад улстай иргэн, аж ахуй, бизнесийн харилцаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаар найрсгаар хамтран ажиллах, үндэстнүүдийн эрх ашгийг хамгаалах зэрэг олон асуудлаар нийтлэг буюу ижил хэмээн хэлж болно.

#### Хуулийн этгээд<sup>42</sup>

Хуулийн этгээд бол иргэний эрх зүйн нэг үндсэн субъект байдаг. Орчин үед хуулийн этгээдийн үйл ажиллагаа нэг улсын хил хязгаараар хязгаарлагдахгүй болжээ. Нэг улсын компани өөр улсын компанитай гэрээ байгуулах, өөр улсад хөрөнгө оруулах, бараа экспортлох, ажил үйлчилгээ гүйцэтгэх явдал улам өргөжиж байна.

Олон улсын хооронд бий болж буй байдал Монгол, Хятад хоёр улсын хооронд ч элбэг байна. Тодруулж хэлбэл, хоёр гүрний хооронд эдийн засгийн харилцааны таатай уур амьсгал бүрэлдэж, хятад улсаас манай улсад хөрөнгө оруулж, дангаараа буюу хамтарсан аж ахуйн нэгж байгуулж төрөл бүрийн аж ахуй эрхлэх, манай зарим компани хятад улсын нутагт хуулийн этгээдийн төлөөлөгчдийн газар, салбар байгууллага байгуулах явдал жилээс жилд өргөжин тэлэх болов.

Ийм нөхцөл байдалд Монгол, Хятад улсын иргэн, аж ахуйн хууль дахь хуулийн этгээдийн талаар заасан нийтлэг ба онцлогийг харьцуулан судлах явдал зүй ёсоор шаардагдаж байна. Монгол улсын иргэний хуулийн 25 дугаар зүйлд: Өмчлөхдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ гэж тодорхойлсон.

---

42 Т.Мөнхжаргал. Монгол, БНХАУ-ын иргэний хуулийн харьцуулсан судалгаа. УБ., 2011 он. 28-37 дахь тал

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 26 дугаар зүйлд: Хуулийн эрхтэн (хуулийн) бол иргэний хэргийн эрхийн чадвар ба иргэний хэргийн үйл ажиллагааны чадвартай, хууль ёсоор биеэ дааж иргэний хэргийн эрх эдэлж, иргэний хэргийн үүргийг үүрэглэсэн зохион байгуулалт мөн гэж тодорхойлсон байна.

Хятад улсын хуульд: Хууль ёсоор байгуулагдсан гэдэг нь хуульд тогтоогдсон журмаар баримт материалаа бүрдүүлэн эрх бүхий байгууллагад бүртгүүлж, эрхийн гэрчилгээ авснаар хуулийн этгээд байгуулагдсанд тооцно гэсэн нь манай хуулийн заалт болон практик амьдралд ч байдаг. БНХАУ-ын хуульд чухалтай эд хөрөнгө буюу зардлын мөнгөтэй гэсэн нь манай хуулийн өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах хөрөнгөтэй гэсэнтэй үндсэндээ утга санаа адил гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл Монгол, Хятад улсын ямар ч хуулийн этгээд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж эцэст нь ашиг орлоготой байхаас гадна үйлдвэрлэл, удирдлага, цалин хөлс гэх мэт зардалтай байна гэсэн ойлголт юм.

Хятад улсын хуульд өөрийн нэрийдэл, зохион байгуулалтын байгууламж ба орон газартай гэсэн заалт нь Монголын хуулийн 27 дугаар зүйлд: Хуулийн этгээд өөрийн нэртэй, мөн төрлийг заасан нэртэй байна. 28 дугаар зүйлд: Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ.

Хятад улсын хуульд иргэний хариуцлагыг биеэ дааж үүрэглэж чадах гэсэн нь манай хуулийн 25 дугаар зүйлд: Хуулийн этгээд нь үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах гэж заасантай утга агуулгын хувьд дүйж байна.

Хуулийн этгээдийг байгуулах. Монгол улсын иргэний хуулийн 30 дугаар зүйлд: Хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно. Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно гэж заасан. Иргэн, хуулийн этгээд хуульд заасан журам нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад төрлийн хуулийн этгээдийг байгуулах урьдчилсан бэлтгэл буюу бичиг баримт бүрдүүлэхийг заасан юм. Тухайлбал, үүсгэн байгуулагчдын гэрээ, дүрэм, дүрмийн сан, тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай бичиг баримт бүрдүүлнэ гэсэн үг болно. Хуулийн этгээд албан ёсоор бүртгүүлж гэрчилгээ авснаар эрх зүйн чадвар, чадамжтай болно. Эдгээр дурдан буй нөхцөлүүд нь хуулийн этгээдийг байгуулсанд тооцох баталгаа болно.



БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 37 дугаар зүйлд хуулийн этгээдийг байгуулах урьдчилсан нөхцлийг заасан. Үүнд:

- Хууль ёсоор байгуулагдана;
- Чухалтай эд хөрөнгө, бусад зардлын мөнгөтэй;
- Өөрийн нэрийдэл, зохион байгуулалтын байгууламж ба орон газартай;
- Иргэний хариуцлагыг бие дааж үүрэглэж чадах гэж хуульчилсан байна.

Хоёр улсын хууль дахь дээрх тодорхойлолт болон дараагийн бүлэг зүйл дэх заалтын утга нь үүсгэн байгуулагчид хуульд заасан баримт материалыг бүрдүүлэх, төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх (Хятадын хуульд данслуулах гэдэг), гэрчилгээ авснаар хуулийн этгээд хэмээх субъект бий болно гэсэн ойлголт ажиглагдаж байна.

Хуулийн этгээдийн чадвар, чадамж. Монгол улсын Иргэний хуулийн 26 дугаар зүйлд: Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно. Ном зохиолд хуулийн этгээдийн чадвар, чадамж бүртгүүлсэн цаг, өдрөөс эхлэн зэрэг үүснэ гэж бичсэн байна.

БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 36 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт: хуулийн эрхтэний иргэний хэргийн эрхийн чадвар ба иргэний хэргийн үйл ажиллагааны чадвар нь хуулийн эрхтэний байгуулагдсан цагаас эхлэн буй болж, хуулийн эрхтэний дуусах үед устана гэжээ.

Хятад улсын судалгааны ном зохиолд: Хуулийн эрхтэний иргэний хэргийн эрхийн чадвар гэдэг нь хуулийн эрхтэн нь иргэний хэргийн эрхт биет цогцын хувиар иргэний хэргийн хөдөлгөөнд (утгачилбал иргэний эрх зүйн харилцаанд) оролцох, иргэний хэргийн эрхийг эдлэн, иргэний хэргийн үүрэг үүрэглэх хир хэмийгзаана гэж тодорхойлжээ.

Мөн зохиолд хуулийн эрхтэн, байгаллаг хүн (хувь хүн) аль аль нь иргэний хэргийн эрхийн чадвартай боловч ялгаатай бөгөөд энэ нь байгаллаг хүний эрхийн чадвар бүгд адил түгээмэл байдаг бол хуулийн эрхтэний эрхийн чадвар хязгаартай байна. Тухайлбал, хуулийн эрхтэн нь төр, засгаас тогтоосон эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажилагаагаа хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг иргэний хуулийн ерөнхий дүрмийн 42 дугаар зүйлд: Аж ахуйллын хуулийн эрхтэн нь хянан зөвшөөрүүлж данслуулсан эзэгнэлтийн хивчээн дотор эзэгнэх эрхтэй гэж заасан нь хуулийн эрхтэн ямар үйлдвэрлэл,

үйлчилгээ эрхлэхээ гэрээ, дүрмэндээ нарийн зааж, түүнийгээ хүлээн зөвшөөрч бүртгүүлсэн хүрээ хязгаарын дотор хэрэгжүүлнэ гэсэн тайлбар юм.

Хуулийн этгээдийн ангилал. Дэлхийн улс орнуудад хуулийн этгээдийг ангилах шалгуур үндсэндээ нэг чиглэл баримжаатайн зэрэгцээ тодорхой улс гүрийн эдийн засгийн хөгжлийн түвшин, хуулийн этгээдийг байгуулах, татан буулгах журам, эд хөрөнгөө хэрхэн өмчилж, захиран зарцуулах эрх мэдэл зэргээс хамаарч хуулийн этгээдийн төрөл хэлбэрээ өөр өөр өвөрмөц байдлаар хуульчилсан байдаг.

Монгол улсын Иргэний хуульд ашгийн төлөө ба ашгийн бус хуулийн этгээд гэж ангилаад ашгийн төлөөд нь компани, нөхөрлөл, ашгийн бусад нь хоршоо, холбоо, сан гэсэн хоёр төрөлд хуваажээ.

Ашгийн төлөө хуулийн этгээдийн нэг байгууллага болох компани нь хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, бүрэн бус хариуцлагатай нөхөрлөл, ашгийн бус хуулийн этгээд болох хоршоо нь эд хэрэглэгчдийн, үйлдвэрлэл үйлчилгээний гэх мэт хэлбэрүүдтэй байна.

Ашгийн бус хуулийн этгээдэд төрийн өмчинд тулгуурласан төрөл бүрийн үйлчилгээ, соёл боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн байгууллага хамаардаг.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрэмд хуулийн эрхтэнийг аж ахуйллын хуулийн эрхтэн ба аж ахуйллын бус хуулийн эрхтэн гэж хуваана. Аж ахуйллын хуулийн эрхтэн гэдэг нь үйлдвэрлэлийн эзэгнэлтийн хөтөлбөр хийж, ашиг хонжвор олохоор зорилго болгосон эл төрлийн аж ахуй зохион байгуулалтыг заана. Үүнд аж үйлдвэр, тариалан үйлдвэрлэл, худалдаа, зам тээвэр, мөнгөн гүйлгээ зэрэг аж ахуйлал, жич эл төрлийн компани багтана.

Аж ахуйллын бус хуулийн этгээд гэдэг нь улсын төсвөөр шилжүүлэн өгөх замаар зардал, сүйтгэлээ болгох буюу өөр бусад эд хөрөнгөтэй, үйлдвэр эзэгнэлтийн бус ажиллагааг эрхлэн ашиг хонжвор олохоор зорилго болгоогүй эл зүйлийн нийгмийн зохион байгуулалтыг заана. Жишээлбэл, улсын албан байгууллага соёл сурган хүмүүжил, эрүүлийг хамгаалал, эрдэм шинжлэх ухаан зэрэг тушаалын чадварыг гүйцэтгэж байгаа ажил үйлсийн нэгж ба нийгмийн бүлгэм багтана.

БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 3 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт: Аж ахуйллын хуулийн эрхтэнийг

1. Ард нийтийн аж ахуйллын хуулийн эрхтэн;

2. Хамтын өмчийн аж ахуйллын хуулийн эрхтэн гэж хуваажээ. Энэ хоёр хэлбэрийн хуулийн эрхтэн нь улсын тогтоолтой нийцэх бэл мөнгөтэй, зохион байгуулах дүрэмтэй, зохион байгууламж ба орон газартай бөгөөд иргэний хэргийн хариуцлагыг тусгаар үүрэглэж чадвал эрхлэн хамаарах байгууллагаар хянан зөвшөөрүүлж данслуулаад хуулийн эрхтэний хир хэмтэй болно гэж тодорхойлжээ.

Үүнийг өөрийн орны хуультай харьцуулбал улсаас тогтоосон бэл хөрөнгөтэй буюу дүрмийн сантай, үүсгэн байгуулах дүрэм хийгээд байнга оршин суух газартай, иргэний эрх зүйн эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай, эрх бүхий байгууллагаар зөвшөөрүүлж бүртгүүлэх гэх мэт утга агуулга бүхий заалтууд нь хоёр улсын аж ахуйллын хуулийн эрхтэн буюу аж ахуйн нэгжийн эрх зүйн байдал нь нийтлэг хэмээн хэлж болно.

Эцэст нь өмнөд хөршид иргэд хуулиар зөвшөөрч бүртгүүлсэн хувийн үйлдвэр, худалдааны өрх, хөдөө тосгоны даачлан эзэгнэх өрх, хувь хүний хоршооллын хэлбэрээр аж ахуй эрхлэж болох, эдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй байдаг. Үүрэг гүйцэтгүүлэгч, гүйцэтгэгч хоёр тал нэг этгээд болсноор гэрээний үүрэг дуусна. Энэ тухай Монгол, Хятад хоёр улсын иргэний эрх зүйн ном зохиолд гэрээний хоёр тал нэг ам бүл, өрх айл болох, хуулийн этгээд нэгдэж нийлсэн тохиолдолд гэрээний эрх, үүрэг дуусаж болно гэж бичсэн байдаг.

#### ЗУРГАДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ХУУЛЬ ДАХЬ ХАРИУЦЛАГА<sup>43</sup>

Иргэний хууль дахь хариуцлагын үндсэн шинж

Монгол, БНХАУ-ын иргэний эрх зүй дэх хариуцлагын нийтлэг шинж. Өгүүлэн буй хоёр гүрний иргэний хууль болон энэ чиглэлийн сэдвийн судлаачдын туурвисан ном бүтээлд иргэний эрх зүйн хариуцлагын талаар бичиж тайлбарласныг тоймлон авч үзье.

Хууль зүйн хариуцлага нь эрүүгийн, захиргааны, сахилгын, материалын гэх мэт хэлбэртэй байдаг. Иргэний эрх зүй дэх хариуцлага нь хууль зүйн бусад хариуцлагад байх нийтлэг шинжийг агуулахын сацуу өөртөө өвөрмөц онцлогтой хариуцлагын хэлбэр юм.

Тэрхүү өвөрмөц шинж нь нэгд: эд хөрөнгөний ба түүнтэй холбоотой эд хөрөнгөний бус харилцаагаар тодорхойлогддог. Хоёрт: иргэний эрх зүй дэх үүргийг хэрхэн гүйцэтгэсэн үр дагавартай шууд холбоотой байна. Өөрөөр

---

43 Т.Мөнхжаргал. Монгол, БНХАУ-ын иргэний хуулийн харьцуулсан судалгаа. УБ., 2011 он. 99-118 дахь тал

хэлбэл үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан талын гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүүний сөрөг дагавар баймааж хариуцлага байх ёстой. Гуравт: үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид материалын болон сэтгэл санааны хохирол учирсан нөхцөлд хэрэглэгддэг.

Иргэний эрх зүй дэх хариуцлага нь учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, үүргийг гүйцэтгүүлэх, анз, алданги төлүүлэх гэх мэт эд хөрөнгөний агуулга бүхий албадлагын хэрэгсэл байдаг. Энэ утгаар нь иргэний эрх зүй дэх материалын хариуцлага, эд хөрөнгөний хариуцлага хэмээн өөр өөрөөр нэрлэх нь бий.

Албадлагыг зөвхөн төрийн эрх бүхий байгууллага хэрэглэнэ. Тухайлбал, гэрээний үүргийг биелүүлэхгүй байх, бусдын эд хөрөнгийг үндэслэлгүй олж авах, нэр төр, алдар хүндийг гутааснаас бусдад хохирол учруулснаас эрх зөрчигч өөрөө сайн дураараа биелүүлэхгүй, зайлсхийсэн тохиолдолд түүний хөрөнгөнөөс албадан гаргуулж байгаад Иргэний эрх зүйн хариуцлагын онцлог оршино. Харин аль нэг тал үүргээ биелүүлээгүй, хохирол торгуулийг ямар нэг маргаангүйгээр тохиролцсон ёсоор өгч авах нь хариуцлага биш, үүргийн гүйцэтгэлийг хангаж буй арга юм.

Үүргийн харилцаанд оролцогчдын нэг тал нөгөө талын өмнө хүлээсэн үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл хугацаа хэтрүүлсэн гэм буруутай үйлдэлд нь иргэний эрх зүйн хэм хэмжээнд заасан хариуцлагыг оногдуулж буй хууль зүйн хариуцлагын нэг төрөл юм. Иргэний эрх зүйн хариуцлага нь үүрэг гүйцэтгүүлэгч буюу хохирогчийн эрх ашгийг хамгаалах, үүрэг гүйцэтгэгч буюу эрх зөрчигчид, хууль гэрээнд заасан албадлагын хэрэгсэл болох анз, торгууль, алданги оногдуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх онцлогтой гэж ном зохиолд тайлбарласнаас гадна Монгол Улсын иргэний эрх зүйн тайлбар тольд бичжээ.

БНХАУ-ын ном зохиолд иргэний хэргийн хариуцлага бол хууль цаазын хариуцлага бөгөөд иргэний хэргийн хууль дүрэмчлэлийг зөрчсөнөөс буй болсон хууль цаазын үр дүн болно. Иймд хууль цаазын хариуцлагын энгийн онцлог байх мөртөө иргэний хэргийн хариуцлага нь өөрийн бас онцлогтой байна. Энэ онцлог нь

1. Иргэний хэргийн хариуцлага бол улсын (төрийн) албадлагын арга барил болно. Улсын албадлагын хүчээр баталгаа болгох нь иргэний хэргийн хариуцлагын чухал онцлог болно. Энэ нь ёс моралын хариуцлагатай адилгүй. Иргэний хэргийн оролцогчид бусдад учруулсан хохирлыг өөрийн

ухамсраараа биелүүлэх, хэрэв биелүүлэхгүй бол шүүх албадлагаар хэрэгжүүлдэг.

2. Иргэний хэргийн хариуцлага бол иргэний хуулийн шаардлагыг зөрчиж, иргэний хэргийн үүргээ биелүүлээгүйгээс болсон үүрэглэх чухалтай хууль цаазын хариуцлага болно. Гэрээний талууд гэрээгээр гүйцэтгэх үүргийг, уг үүргийг биелүүлэхгүй бол хүлээх хариуцлагаа өөрсдөө харилцан тохиролцож тогтоодог нь хууль цаазын бусад хариуцлагаас ялгаатай юм.

3. Иргэний хэргийн хариуцлагын гол нь эд хөрөнгийн хариуцлага байдаг. Гэрээний зохицуулах зүйл нь ихэнхдээ эд хөрөнгийн агуулгатай. Тухайлбал, эд юмсыг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх, тодорхой товар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эд зүйл засварлах гэх мэт байх, эдгээр гэрээний үүргээ зөрчвөл хохирол төлөх, нөхөн гүйцэтгэх, торгууль оногдуулах хариуцлага үүрэглэнэ гэжээ.

Ийнхүү хоёр улсын зохиогчдын бичсэн зүйлийг хураангуйлан үзвэл иргэний хуулийн хариуцлага нь төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл болох, гэрээний аль нэг тал хуулиар тогтоосон буюу гэрээгээр тохиролцож тогтоосон гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлээгүйгээс нөгөө этгээдэд хохирол учруулсан байх, хүлээх хариуцлагаа талууд урьдчилан зөвшөөрсөн байдгаар хууль зүйн бусад хариуцлагаас ялгагдах онцлогтой гэх зэргээр илэрхийлсэн утга агуулга хийгээд үзэл баримтлал нийтлэг ижил байна.

Гэрээний ба гэрээний бус хариуцлага. БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн хоёрдугаар хэсэгт "Гэрээг зөрчсөн иргэний хэргийн хариуцлага", Гэрээний хуулийн дөрөвдүгээр бүлэгт "Болзоо зөрчсөн хариуцлага" гэж хоёр өөр нэр томъёо хэрэглэсэн нь гэрээний хариуцлага гэсэн ойлголтыг илэрхийлсэн байна. Гэрээний бус үүргийг иргэний хуулийн ерөнхий дүрмийн гуравдугаар хэсэгт "Эрхэнд халдсан иргэний эрхийн хариуцлага" гэж томъёолсон байна.

Гэрээний ба иргэний бус хариуцлага нь иргэний эрх зүйн эрх, үүргийн зөрчил, түүнд оногдуулах хариуцлагын зарчим, иргэн, хуулийн этгээд, улсын (төрийн) эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг хамгаалах үүрэг, зорилгоороо адил боловч тус бүрдээ өвөрмөц онцлогтой. Тэрхүү онцлогийг Хятад улсын зохиол бүтээлд тухайлан ангилан туурвисныг ишлэн авч үзье.

Нэгд: Иргэний эрх зүйн харилцаа зөрчигдсөн шинжээр ялгаатай байна. Гэрээний хариуцлага нь гэрээгээр тохиролцсон эрх, үүргээр суурь болгосон, тухайлбал үүрэгт этгээд хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд хэрэглэдэг. Гэрээний бус хариуцлага нь гэрээний

үүргийг бус хуульд заасан хэм хэмжээг эерчсэн, өөрөөр хэлбэл хохирогч, хохироулагч хоёрын хооронд урьд нь ямар нэг эрх зүйн харилцаагүй бөгөөд харин тодорхой орон зай, цаг хугацаанд бусдын эд хөрөнгө, бие эрхтэнд халдсан тохиолдолд үүсдэг хариуцлага юм.

Хоёр: Эрхийг хамгаалах үр дагаврын хувьд ялгаатай. Гэрээний нэг тал үүргээ биелүүлээгүй нь нөгөө талын үйлдвэрлэл, үйлчилгээ, иргэдийн ахуйд эд юмсын хохирол бодитой учирсан байх тул хохирогч этгээд хохирсон эд хөрөнгөө нэхэмжлэх эрхтэй байна. Гэрээний бус хариуцлага нь эд хөрөнгийн хохирол байхаас гадна хүний амь бие, нэр төр, сэтгэл санаанд гэм хор учирсан, түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Гуравт: Хариуцлага хүлээх субъектийн хүрээгээр ялгаатай. Гэрээний хариуцлага нь зөвхөн гэрээгээр хүлээсэн нөхцөл болзлыг зөрчсөн талын хууль бус ажиллагааны гэм буруугийн төлөө хариуцлага оногдуулна. Гэтэл гэрээний бус хариуцлагыг бусдын эд хөрөнгө, амь биед халдсан иргэн, хуулийн этгээд байхын зэрэгцээ асран хамгаалалтад байгаа эрх зүйн чадамжгүй хүн бусдын бие, эд хөрөнгөд хохирол учруулбал асран хамгаалагч нь өөрөө үйлдээгүй ч асруулагчийг харж хамгаалаагүй гэм буруугийн төлөө хариуцлага хүлээдэг.

Дөрөв: Хариуцлагын хүрээгээр ялгаатай. Хоёр тал байгуулсан гэрээндээ ямар хохирол гарч болох, хэрэв гарвал түүнд тохирсон хэмжээний анз, торгууль оногдуулахаа урьдчилан тохиролцож тогтоодог бол гэрээний бус хариуцлагыг урьдчилан тооцох боломжгүй. Жишээ нь хүний биед гэмтэл учруулсан эмнэлэг, сувилалын зардал, хэрэв уг хүн үхсэн бол оршуулгын зардал төлөх гэх мэт.

Тав: Хариуцлагыг үгүйсгэх нөхцөлөөр ялгаатай. Гэрээний талууд гэрээг биелүүлэх явцад ямар нөхцөл буюу үзэгдэл (байгалийн давагдашгүй хүчин гэх мэт) тохиолдож хохирол учирвал хариуцлага хүлээхгүй гэж анх тохиролцсон байдаг. Бусдын эд хөрөнгө, амь биед хохирол учруулагч хохирогчийн өөрийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн гэдгээ гэрч баримтаар баттай нотолж чадвал гэрээний бус хариуцлагаас чөлөөлөгдөж болно.

Зургаа: Хариуцлага хүлээх арга хэлбэрийн хувьд ялгаатай. Хэрэв гэрээний үүрэг зөрчсөнөөс болж учирсан хохирлыг адил яс чанарын эд хөрөнгөөр, эсхүл мөнгөөр тооцож төлүүлдэг бол бусдын эд хөрөнгө, бие махбодид халдсан хариуцлага нь Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 134 дүгээр зүйлд заасан халдлагыг зогсоох, аюул түгшүүрийг арилгах, харш саадыг зайлуулах, мөнгөөр торгох зэрэг хэлбэрүүдтэй байна.

## Хариуцлага хүлээх үндэслэл

Хууль зүйн хариуцлагыг тодорхой нөхцөл байдал бүрдсэний үндсэн дээр хүлээлгэдэг зарчим нь иргэний эрх зүйд хариуцлага хүлээлгэхэд нэгэн адил баримтлах учиртай. Хэрэв нөхцөл бүрдээгүй бол хариуцлага оногдуулах тухай яригдах учиргүй юм. Энэ зарчим өгүүлэн буй хоёр улсын иргэний эрх зүйд нэгэн адил баримтлагдаж байна.

Хоёр улсын иргэний хууль болон ном бүтээлд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг 1. Эрх зөрчигчийн хууль бус идэвхтэй ба идэвхгүй үйлдэл (хятад улсын ном зохиолд ажиллагаа нь хууль зөрчсөн чанартай байх хэрэгтэй); 2. Хохирол учирсан байх (хятад улсынхад хор хөнөөл байх хэрэгтэй); 3. Хууль бус идэвхтэй ба идэвхгүй үйлдэл, хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байна (хятад улсын ном зохиолд хууль бус ажиллагаа ба хор хөнөөл болсон бодит хэрэг хоорондоо шалтгаан ба үр дүнгийн холбогдол байх хэрэгтэй гэжээ);

4. Эрх зөрчигчийн гэм буруу (хятад улсын ном зохиолд ажиллагаат хүний буруу байх хэрэгтэй гэжээ) гэсэн дөрвөн элемент байна гэж бичжээ.

Хуульд заасан буюу гэрээгээр хийж болохгүй гэж шууд хориглосон зүйлийг үйлдсэн бол хууль бус идэвхтэй, харин хууль гэрээнд хийхээр үүрэг болгосон зүйлийг хүндэтгэх шалтгаангүйгээр хийгээгүй нь хууль бус идэвхгүй үйлдэл болно.

БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 128 дугаар зүйлд: Зүй ёсны хамгаалалтаас болж хохирол учруулсан байвал иргэний хэргийн хариуцлага үүрэглэхгүй. Зүй ёсны хамгаалалт нь зохих хэмжээнээс даваад учруулахгүй байж болох хохирлыг учруулсан байвал иргэний хэргийн хариуцлагыг зохих хэмжээгээр үүрэглэх хэрэгтэй гэж заасан бол хуулийн дараагийн зүйлд: аюулаас бачим зайлснаас болж хохирол учруулсан бол аюул түгшүүрийг буй болгосон хүн иргэний хэргийн хариуцлага үүрэглэнэ. Аюул түгшүүр нь байгалийн шалтгаанаар үүссэн байвал аюулаас бачим зайлагсад иргэний хэргийн хариуцлага үүрэглэхгүй буюу иргэний хэргийн хариуцлагыг зохих хэмжээгээр үүрэглэнэ. Аюулаас бачим зайлахаар авсан арга хэмжээ нь зохисгүй буюу зохих хэмжээнээс даваад учруулахгүй байж болох хохирлыг учруулсан байвал аюулаас бачим зайлагсад иргэний хэргийн хариуцлагыг зохих хэмжээгээр үүрэглэх хэрэгтэй гэсэн байна.

Монгол улсын Иргэний хуулийн 11 дүгээр зүйлд: Тухайн нөхцөл байдалд аюулыг өөр арга замаар зайлуулах боломжгүй бол түүнийг таслан зогсоох, сэргийлэх зорилгоор хийсэн үйлдэл (эс үйлдэхүй)-ийг гарцаагүй

байдлын улмаас хийсэн үйлдэл гэнэ. Гарцаагүй байдалд учруулсан гэм хор нь учирч болох байсан гэм хороос бага байвал уг үйлдэл хийсэн этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээхгүй гэж заасан.

Хуулийн энэ хоёр заалтыг харьцуулан ажиглавал анх аюул түгшүүртэй байдал үүссэн шалтгаан, түүнийг зайлуулах буюу зогсоохоор хийсэн хууль ёсны ба хууль бус үйлдэл, уг үйлдэл, эс үйлдэл нь учирсан, эсхүл учирч болох байсан хохирлын хэмжээтэй хэрхэн хамааралтай байх зэрэг эрх зүйн зарчим, үзэл баримтлал адил утга санааг агуулж байна.

Хохирол бол хариуцлага оногдуулах нэг нөхцөл болно. Хоёр улсын иргэний хууль, түүнд холбогдох бусад хууль тогтоомж болон иргэний эрх зүйн сурах бичиг, судалгааны зохиол бүтээлд хохирол эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус байх, тэр нь эрх зөрчигчийн ямар үйлдлээр үүсэж, ямар хэлбэрээр илрэх байдлыг тодорхой хуульчилсан бөгөөд мөн тодорхой тайлбарлан бичсэн байна. Хэрэв хохирол учраагүй бол хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй. Эд хөрөнгийн хохирол учраагүй боловч хүний нэр төр, алдар хүндийг гутаах, доромжлох, гүтгэснээс болж сэтгэл санаанд хохирол учирч болох бөгөөд уг хохирлыг няцаах, осол бурууг нь хүлээлгэх, сэргээх аргаар хариуцлага хүлээлгэдэг.

Хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл нь хууль бус идэвхтэй ба идэвхгүй хохирол хоёрын хоорон дахь шалтгаант холбоо байна. Эд хөрөнгийн гэмтэл, алдагдал, орох ёстой байсан орлого болон сэтгэл санааны хохирлын хэлбэрийг бий болгогч нь эрх зөрчигчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл байдаг. Өөрөөр хэлбэл хууль бус үйлдлийн эцэст сөрөг үр дагавар, үзэгдэл заавал бий болсон байх ёстой.

Хохирол учирсан л бол хариуцлага хүлээлгэх үндэслэл болно хэмээн туйлшран ойлгож болохгүй. Өөрөөр хэлбэл эрх, үүргийнхээ ёсоор бусдад хохирол учруулсан бол шалтгаант холбоотой гэж үзэхгүй бөгөөд энэ тухай Улсын Дээд Шүүхийн тайлбарт: Эрх, үүргийнхээ ёсоор бусдад хохирол учруулсан этгээдэд хууль тогтоомжид зааснаар бусдын эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд эрхэлж байгаа ажил, албан тушаал, мэргэжлийн хувьд халдах эрхтэй бөгөөд үүний улмаас гэм хор учруулж болох хүн, малын эмнэлэг, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, зэвсэгт хүчний зэрэг байгууллагын эрх бүхий ажилтан хамаарна гэжээ.

Хятад улсын иргэний эрх зүйн судлаачид: тушаалын хууль ёсны ажиллагаа, тухайлбал, хууль цаазад тогтоосон эрхийн хэвчээн дотор тушаал буюу ажил үйлс дээр зүй ёсны ажиллагаа нь хэдийгээр бусад хүнд хохирол



учруулсан боловч иргэнд халдсан ажиллагаа болохгүй. Жишээ нь: эмч өвчтөнд мэс засал хийх, бусдын гоц халдвартай малыг устгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тогтоол ёсоор өгцөөтний эд хөрөнгийг битүүмжлэх, хураан авах нь бусдын бие болон эд хөрөнгөнд гэм хор учруулсан гэж үзэхгүй гэж бичсэн байна.

Эрх зөрчигчийн гэм буруу буюу ажиллагаат хүний буруу нь иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийн нэг байна. Гэм буруу нь эрх зөрчигчийн санаа сэтгэхүйтэй холбоотой субъектив талын ойлголт. Өөрөөр хэлбэл эрх зөрчигчийн хууль бус үйлдэл, эс үйлдэл, түүний эцэст учирсан хохирол хоёрын шалтгаант холбоо, тэдгээрийн эцсийн үр дагаварт харьцах санаа зоригийн хандлага нь гэм буруу болно. Осол буруу гэдэг нь ажиллагаат хүн ажиллагаа хийх үеийн нэг зүйлийн сэтгэц зүйн байдлыг заах бөгөөд зориуд ба осол буруу гэж хоёр хуваана. Зориуд гэдэг нь ажиллагаат хүн өөрийн ажиллагаагаа хор хөнөөл болох үр дүнг зөгнөн мэдэх боловч энэхүү хор хөнөөлийн үр дүн гарахыг хүсэх буюу түүний аяар сул тавихыг зааж байна. Осол буруу гэдэг нь ажиллагаат хүн өөрийн ажиллагаагаа хор хөнөөл болох үр дүнг зөгнөн мэдэх ёстой байтал мэдэж чадсангүй буюу нэгэнт зөгнөн мэдсэн боловч энэхүү үр дүн гарахгүй гэж хөнгөн хуумгай итгэснийг зааж байна гэж Хятад улсын ном зохиолд тодорхойлсон нь манай судлаачдын үзэл баримтлалтай дүйж байна.

Иргэний хуульд захиалагч еерийн буруугаар ажлын үр дүнг хугацаанд нь хүлээж аваагүй, ажлын үр дүн гүйцэтгэгчийн эзэмшилд байхдаа гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас эвдэрч сүйдсэн болон зайлшгүй гарсан бусад зардлыг үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй гэж заасан.

Монгол, Хятад улсын хуульд торгууль, хохирол хоёрыг хэрхэн тохиролцож төлөхөөр заасныг үзье. Монгол улсын Иргэний хуулийн 232 дугаар зүйлд: хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөрийг анз хэмээн тогтоогоод анзыг торгууль, алданги гэсэн хоёр төрөлтэй байна гэжээ. Анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн байна.

БНХАУ-ын Гэрээний хуулийн 114 дүгээр зүйлд: Тухайн хүний нэг этгээд нь болзоог зөрчсөн үед болзоог зөрчсөн байдлыг үндэслэн нөгөө этгээддээ зохих тооны болзоог зөрчсөн мөнгө өгөхөөр болзон тогтоож болох бөгөөд бас болзоог зөрчсөнөөс болсон хохирлыг төлөх тоо хэмжээг бодох аргыг ч болзон тогтоож болно гэснийг манай хуулийн заалттай харьцуулбал хохирол,

торгууль төлөхөөр урьдчилан тохиролцоно гэсэн нь адил бөгөөд харин монголын хуульд анзын нийт дүн нь хохирлын 50 хувиас хэтрэхгүй, хятад улсын хуульд хохирлын хэмжээг талууд болзон тогтооно гэсэн нь өвөрмөц ялгаа байна.

Мөн хуульд болзон тогтсон болзоог зөрчсөн мөнгө нь учруулсан хохирлоосоо бага байвал тухайн хүн нь Ардын шүүх хороо буюу хөндлөнгөөс таслах байгууламжид нэмэгдүүлэх гуйчлал гаргаж болно. Болзон тогтсон болзоог зөрчсөн мөнгө нь учруулсан хохиролоосоо хэтэрхий их байвал тухайн хүн нь Ардын шүүх хороо буюу хөндлөнгийн таслах байгууламжид зохих хэмжээгээр хасуулах гуйчлал гаргаж болно гэж заасан нь онцпог юм. Өөрөөр хэлбэл болзоо зөрчсөн мөнгөний хэмжээг урьдчилан тогтох, харин учирч болох хохирлыг урьдчилан тооцох боломжгүй учир хэрэв гэрээний үүрэг зөрчиж, хохирол учирвал анз хохирол хоёрын зөрөөг хэрхэн зохицуулах арга замыг тогтоосон хэрэг юм.

Гэрээний бус хариуцлагыг Хятад улсын хуульд эрхэнд халдсан иргэний хэргийн хариуцлага, ном зохиолд хураангуйлан эрхэнд халдсан хариуцлага гэж нэрлэсэн байдаг. Гэрээний бус үүрэг хууль зүйн ямар ойлголт болох, тухайн үүргийг зөрчсөн төрөл, хэлбэр, онцлог, үүссэн буюу үүсч болох зөрчлийг зогсоох, зайлуулах арга зам, нэгэнт бий болсон хохирол төлөх талаар хоёр улсын иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт нийтлэг агаад тодорхой байгааг юуны өмнө тэмдэглэж байна.

Монгол улсын иргэний хуулийн 497 дугаар зүйлд: бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-гээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө гэж заасан.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрэмд: улс орны, хамт нийтийн эд хөрөнгө буюу бусдын эд хөрөнгийг эзлэн авсан байвал эд хөрөнгийг нь буцааж өгөх, хэрэв буцааж чадахгүй бол үнэлэн бодож төлөх хэрэгтэй. Бусдын эд хөрөнгийг эвдэж сүйтгэсэн байвал угийн байдлыг нь сэргээх буюу үнэлэн бодож төлж өгөх хэрэгтэй.

Ард иргэний бие махбодод халдаж шархдуулж гэмтээсэн байвал эмнүүлсэн сүйтгэл, ажил саатаад хасагдсан орлого, зэмдэг бологсдын амьдралын нөхвөр зардал зэрэг зардал сүтгэлийг төлөх, хүн нь үхсэн байвал оршуулгын зардал, үхсэн хүний амьд сэрүүн байхдаа асран тэжээж байсан

хүний амьдралын чухал зардал, сүйтгэлийг нь өгөх хэрэгтэй. Ард иргэний овог нэрийн эрх, биеийн хөргийн эрх, нэр хүндийн эрх, алдар хүндийн эрх халдлагад учирвал халдлагыг зогсоох, нэр хүндээ сэргээх, нөлөөг арилгах, осол бурууг хүлээлгэх, хохирлоо төлүүлэхээр шаардаж болно.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 131 дүгээр зүйлд: хохирол амссан хүн нь хохирол гарсан явдалд бас алдаатай байвал хохирол учруулсан хүний иргэний хэргийн хариуцлагыг хөнгөрүүлж болно гэж заасныг 2003 онд “БНХАУ-ын Дээд шүүх хорооны хүний биеийн хохирлыг төлөх хэргийг шүүн шийдвэрлэхэд хууль цаазыг тохируулан хэрэглэх асуудлуудын тухай тайлбар” баталжээ.

Тайлбарын 2 дугаар зүйлд: хохирогч нь адил нэг хохирлыг зориуд учруулсан буюу ихэсгэн, эсхүл энэ талаар адил буруутай байхад хүрвэл, Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 131 дүгээр зүйлийн тогтоолыг үндэслэн, төлбөр өгөгчийн төлбөр өгөх хариуцлагыг хөнгөрүүлэх буюу эсхүл хэлтрүүлж болно. Хэрэв эрхэд халдсан хүний зориуд буюу хүнд ноцтой эндлээс болж бусдад хохирол учруулсан бөгөөд зөвхөн хохирогчийн энгийн осол буруугаас болсон байхад хүрвэл төлбөр өгөгчийн төлбөр өгөх хариуцлагыг хөнгөрүүлж болохгүй гэж тайлбарласан нь онцпог юм.

Хуулийн этгээдийн, албан хариуцлагатан бусдад учруулсан гэм хорын хариуцлага Монгол Улсын Иргэний хуулийн 498 дугаар зүйлд: ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 121 дүгээр зүйлд: төрийн байгууллага, төрийн байгууллагын ажилтан үүрэг тушаал гүйцэтгэхдээ ард иргэн, хуулийн эрхтэний хууль ёсны эрх ашигт халдаад хохирол учруулсан байвал иргэний хэргийн хариуцлага үүрэглэх хэрэгтэй гэж заасан. Энэ заалтыг Ардын Дээд Шүүх хорооны талбарын 8 дугаар зүйлд: хуулийн эрхтэн буюу бусад зохион байгуулалтын хуулиар тогтоосон төлөөлөгч, хариуцлагатан, жич ажилтан үүрэг тушаалаа гүйцэтгэх дунд (явцад) бусдад хохирол учруулсан байвал дээр дурдсан хуулийн тогтоол ёсоор тус хуулийн эрхтэн буюу бусад зохион байгуулалт нь иргэний хэргийн хариуцлагыг үүрэглэх хэрэгтэй гэж тайлбарласан байна.

Мөн тайлбарт: дээр дурдсан хүмүүс өөрийн үүрэг тушаал лугаа эс холбогдох үйл ажиллагааны дунд бусдыг хохироосон байвал, хохирол төлөх хариуцлагыг тус хүн өөрөө хүлээх хэрэгтэй гэсэн нь Монгол Улсын Иргэний хуулийн 498.3 дугаар зүйлд: хохирогч өөрөө санаатай буюу болгоомжгүйгээс

бусдад гэм хор учруулсан бол хуулийн этгээд хариуцлагаас чөлөөлөгдөнө гэсэнтэй утга агуулга адил байна.

Монгол Улсын Иргэний хуульд төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад бусдад гэм хор учруулсан бол түүний ажиллаж байгаа хуулийн этгээд, буюу төр хариуцна шүүх, прокурор, цагдаагийн байгууллага хүнийг хууль бус яллагдагчаар татсан, ял шийтгэсэн, саатуулсан, захиргааны журмаар баривчилсан бол дээрх байгууллагын албан тушаалтнаас үл хамааран төр учирсан хохирлыг хариуцна гэж заасан.

БНХАУ-ын 1994 оны 5 сарын 12-ны өдөр “БНХАУ-ын улсын төлбөрийн хууль” -ийг баталсан бөгөөд уг хуульд засаг захиргаа, хуулийн байгууллагын албан тушаалтан, хууль зөрчиж ард иргэн, хуулийн эрхтэнд хохирол учруулсан бол хохирсон этгээд улсаас (төрөөс) төлбөр авах эрхтэй болохыг тогтоосон байна. Хуулийн агуулга нь засаг, захиргаа, шүүх, прокурор, мөрдөн байцаах, цагдаагийн байгууллагын эрх мэдэл бүхий албан тушаалтны хууль бус идэвхитэй бай идэвхигүй үйл ажиллагаанаас болж иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн болон оюун санааны хохирол учруулсан бол уг хохирлыг улс (төр) — аас хариуцах, хохирлыг хэрхэн тооцож бодох арга хэлбэрийн тухай нарийвчлан заасан өвөрмөц бөгөөд онцлог хууль болно.

Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс бий болсон хохирлыг арилгах хариуцлага. Энэ тухай хоёр улсын хуулийн зохицуулалт нийтлэг ижил байна. Тухайлбал тээврийн хэрэгслэлийн ашиглалт, барилга байгууламж барих, ашиглах, тэжээвэр амьтан, тэсэрч дэлбэрэх аюултай бодис хадгалахад уг зүйлүүдийг хэрэглэх, ашиглах, хадгалах, тээвэрлэх явцад бусдад хохирол учруулбал иргэний эрх зүйн хариуцлага оногдуулах нь адил харин зарим нэг онцлогууд байна.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 123 дугаар зүйлд: ойр хавийн орчин тойронд ихээхэн аюултай байдаг өндөр дээр, өндөр хүчдэл, ноцомтгой, тэсрэмтгий, хор ихтэй, цацраг идэвхи чанартай, дээд хурдацтай тээврийн багаж хэрэгсэл зэргийг ажиллах ажиллагаанаас болж бусад хүнд хохирол учруулсан байвал, мөн орчин тойрныг хамгаалан бузардлыг хориглох улсын хууль зөрчиж бусдад хохирол учруулбал, мөн олон нийтийн газар замын дагуу буюу голд нүх ухах, газар доорхи төхөөрөмжийг засах, сэлбэх, угсрахдаа тодорхой тэмдэг тавилгүй, аюулаас сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс бусдад хохирол учруулбал тус тус хариуцлага хүлээлгэж байхаар хуульчилжээ.

Тэгвэл эдгээртэй төсөөтэй Монгол Улсын Иргэний хуульд тухайлбал барилга байгууламжийн хийц, байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн, эсхүл

түүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд гэм хор учруулсан бол уг гэм хорыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсхүл аюултай зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй гэсэн байна.

Ишлэн авсан хоёр зүйлийн ялгаа нь хятад улсын хуульд аюул учруулж болох эд юмс, бодисын төрөл, зүйлийг нэг бүрчлэн нэрлэн засан бол монгол улсын иргэний хуульд гэм хор учруулж, хариуцлага хүлээх этгээд хэн болохыг тодорхой заасан нь ялгаатай хэмээн хэлж болно.

Гэрийн тэжээвэр амьтны учруулсан гэм хорын талаар хоёр гүрний хуулийн заалтыг авч үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн 501.2 дугаар зүйлд: гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учруулсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй гэж заасны эсрэг утга нь хэрэв холбоотой байсан бол өмчлөгч буюу эзэмшигч хариуцна гэсэн ойлголтыг агуулж байна. Монгол Улсын дээд шүүхийн тайлбарын амьтан гэдэгт гэрийн тэжээвэр нохой, орсон буур, циркийн бар, арслан, бусад амьтад хамаарна гэжээ.

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 127 дугаар зүйлд: тэжээвэр амьтан бусад хүнд хохирол учруулбал тэжээгч нь буюу хамаарагч нь иргэний хэргийн хариуцлага үүрэглэх хэрэгтэй. Хохирол амссан хүний өөрийн алдаанаас болж хохирол гарсан байвал амьтны тэжээгч буюу хамаарагч нь иргэний хэргийн хариуцлага үүрэглэхгүй гэсэн нь монгол улсын хуулийн заалттай адил юм. Харин хятад улсын хуульд тэжээвэр амьтан гуравдугаар хүний алдаанаас болж хохирол учруулсан байвал гуравдугаар хүн иргэний хэргийн хариуцлага үүрэглэх хэрэгтэй гэж хохирол учруулж болох субъектийн тухай нэмж заасан нь онцлогтой байна.

Монгол Хятад хоёр улсын иргэний хуульд Иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг хэрхэн тогтоож хуульчилсныг харьцуулан үзэе.

Монгол улсын иргэний хуулийн 9.4 дүгээр зүйлд:

1. Эрхийг хүлээн зөвшөөрөх;
2. Эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх;
3. Хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;
4. Учруулсан хохирлыг арилгуулах;

5. Эдийн бус гэм хорыг арилгуулах;
6. Хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;
7. Бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох;
8. Иргэний эрх зүйн харицааг өөрчлөх дуусгавар болгох;
9. Өөртөө туслах;
10. Хуулиар тогтоосон бусад арга;

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 134 дүгээр зүйлд: иргэний хэргийн хариуцлагыг үүрэглэх гол арга хэлбэр нь:

5. Халдлагыг зогсоох;
6. Харш саадыг зайлуулах;
7. Аюул түгшүүрийг арилгуулах;
8. Эд хөрөнгийг нь буцаах;
9. Угийн байдлыг сэргээх;
10. Засах, дахиж хийх, сольж өгөх;
11. Хохирлыг төлөх;
12. Гэрээ зөрчсөн мөнгө төлөх
13. Нөлөөг арилган, нэр хүндийг нь сэргээх;
14. Осол буруугаа хүлээх

Эдгээр аргуудыг нэг бүрчлэн ажиглавал илэрхийлж буй үг, нэр томъёоны хувьд ялгаатай мэт боловч иргэний эрх зүйн тодорхой төрлийн харилцааг ямар байдлаар зөрчиж, ямар хэлбэр хэмжээний хохирол (эдийн ба эдийн бус) учруулсан, түүнийг арилгах, нөхөн төлөх, угийн байдалд нь оруулах журам, оногдуулах хариуцлага үндсэндээ нийтлэг нэг зарчимтай хэмээн хэлж болно. Гэрээний ба гэрээний бус зөрчил, дутагдал, хүлээлгэх хариуцпагын талаар хоёр улсын иргэний хууль, бусад холбогдох хуулиудын бүлэг, зүйлүүдэд тодорхой байгаа бөгөөд бас энэ тухай өмнө нэгэнт дурдсан билээ.

Харин зарим нэг ялгаа байна. Монгол Улсын Иргэний хуулийн “өөртөө туслах” гэсэн 12 дугаар зүйлд: эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэпкүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэн авах, устгах буюу эвдэх, эсхүл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдлийг хууль бус гэж үзэхгүй гэж заасан. Ямар үйлдлийг өөртөө туслах гэж

ойлгох, тэр нь иргэн хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах арга болох, ямар тохиолдолд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг хуульчилсан юм

БНХАУ-ын иргэний хуулийн ерөнхий дүрмийн 134 дүгээр зүйлийн хоёр дахь зурваст: иргэний хэргийн хариуцлагыг үүрэглэх дээрх арга хэлбэрүүдийг дангаар нь хэрэглэж болно. Нийлүүлэн хэрэглэж ч болно. Ардын шүүх хороо иргэний хэргийг шүүхдээ дээр дурьдсан тогтоолыг (аргуудыг) хэрэглэхээс гадна зэмлэн цээрлүүлэх, зарлигдаж байгаад гэмшин засрах баталгаа бичүүлэх, хууль бус ажиллагаа хийж байсан эд хогшил ба хууль бусын орлогыг авч болох бөгөөд бас хуулийн тогтоол ёсоор торгож, түр хорьж болно гэсэн нь хариуцлага хүлээлгэх өвөрмөц онцлогийг заасан байна.

### **3.3. ХБНГУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог**

1896 оны Германы Иргэний хууль нь Францын иргэний хуулиас бараг 100 жилийн дараа гарч ирсэн тул боловсруулагчид нь 19-р зууны үед хуулийг системчилж, тодруулж, шинэчилж байсан Германы эрдэмтдийн эрчимтэй хичээл зүтгэлээс ашиг олж байв. Үүний үр дүнд Германы код нь Францын өмнөх хувилбараас эрс ялгаатай болжээ: зохион байгуулалт нь илүү эмх цэгцтэй, хэл нь илүү нарийвчлалтай, хэрэглээ нь илүү нарийн байдаг.

Германы хуулийн давж заалдах гомдол нь хуульчдаас өмгөөлөгчдөөс; төвийг сахисан өнгө нь Францын Иргэний хуулийг бичсэн сэтгэл хөдлөм байдалтай харьцуулж үздэг. Энэ нь эрэгтэйчүүдийг өргөн утгаар нь заахыг хичээдэггүй боловч ёс суртахууны тулгамдсан зүйлийг онцолдог. Бүх итгэл үнэмшил, шударга харилцаа нь бүх асуудалд ажиглагдах ёстой. Зөрчил сайн ёс суртахуун, эрх зүй бус харьцаа, *underhanded* хууль эрх зүйн гүйлгээний хууль эрх зүйн хүчин төгөлдөр хасуулсан байна. Энэхүү код нь 20-р зууны эхэн үеийн нийгэмд тохирсон байх ёстой байсан боловч тодорхой хэм хэмжээг боловсруулах ажлыг шүүгчдэд үлдээсэн ерөнхий заалтуудыг ашигласнаар энэ нь эдийн засаг, соёл, нийгэм-улс төрийн шинэ постулатуудад дасан зохицох чадварыг харуулсан болно.

Иргэний хууль бол Германд хамгийн том эрх зүйн салбар юм. Үүнийг заримдаа хувийн хууль эсвэл иргэний хууль гэж нэрлэдэг бөгөөд үндсэндээ иргэний хуульд зохицуулагддаг. Гэхдээ үүнтэй зэрэгцэн "Ажлын цагийн тухай хууль" эсвэл "Арилжааны тухай хууль" гэх мэт олон тооны тусгай хууль байдаг.

Иргэний эрх зүй ямар харилцааг зохицуулдаг вэ?

Иргэний хууль (хувийн хууль гэж нэрлэдэг) нь бусад зүйлээс гадна хувийн болон хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулдаг. Ердийн бүрэлдэхүүн хэсэг нь хэрэглэгчид, компаниуд гэх мэт өөр хоорондоо байгуулж болох янз бүрийн гэрээ юм. Түрээсийн тухай хууль дахь түрээсийн гэрээ, борлуулалтын тухай хууль дахь худалдан авах гэрээ зэргийг зохицуулдаг.

Иргэний хуулийн шинж чанарууд юу вэ?

Германы иргэний эрх зүйд хувийн автоматжуулалтын зарчим үйлчилдэг бөгөөд үүний дагуу хүн бүр ямар агуулгаар хэнтэй, хэнтэй гэрээ байгуулахаа чөлөөтэй шийдэж болно. Хууль тогтоох байгууллага нь зөвхөн тодорхой хүрээг хангаж өгдөг, хэрэглэгчдийг хамгаалах замаар.

Иргэний хууль олон нийтийн хуулиас юугаараа ялгаатай вэ?



Олон нийтийн хууль нь нийтийн эрх мэдлийн хувьд иргэд ба төр хоорондын харилцаатай холбоотой юм. Мужийн зохион байгуулалт ба түүний байгууллагууд мөн энэ чиглэлд ордог.

### Иргэний хуулийн тодорхойлолт

Иргэний хууль гэж хууль ёсны дагуу тэнцэх аж ахуйн нэгж хоорондын эрх зүйн харилцаа зохицуулна. Хуулийн субъектууд нь ихэвчлэн хувь хүмүүс (жишээлбэл, иргэн) эсвэл хуулийн этгээд (жишээлбэл, компаниуд) байдаг.

Үүнийг ерөнхий буюу иргэний хувийн эрх зүй (үүргийн тухай хууль, өв залгамжлалын тухай хууль, гэр бүлийн тухай хууль гэх мэт) ба хувийн тусгай хууль (арилжааны хууль, хөдөлмөрийн тухай хууль гэх мэт) гэж хуваадаг. Иргэний эрх зүйн хамгийн чухал хууль бол Германы Иргэний хууль (BGB) бөгөөд үүнд хүмүүс, эд зүйл, амьтны эрх, үүргийн талаархи үндсэн дүрмүүд ордог.

“Иргэний хууль” гэсэн нэр томъёо нь ихэвчлэн хувийн хуультай ижил утгатай хэрэглэгддэг. Эрх зүйн тодорхойлолтод иргэний эрх зүй нь ихэвчлэн хувийн эрх зүйн чухал хэсэг, тухайлбал хувийн ерөнхий хуулийг илэрхийлдэг. Гэхдээ энд иргэний хууль нь хувийн хуультай ижил утгатай хэрэглэгддэг.

### Олон нийтийн хуулиас ялгавартай байдал

Иргэний болон нийтийн эрх зүйн хоорондын заагийг үргэлж маргаангүй байна. Давамгайлсан сургаал нь өөрчлөгдсөн сэдвийн онолыг дагаж мөрддөг. Үүний дагуу, хэрэв эрх зүйн хэм хэмжээ нь төрийн эрх бүхий байгууллагад ийм эрх олгох, үүрэг хүлээхгүй бол энэ нь иргэний хууль юм. Гэсэн хэдий ч хил хязгаарыг тогтоох нь үргэлж тодорхой байдаггүй. Иргэний хуулийн өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлагыг иргэний эсвэл олон нийтийнх эсэхийг тодорхойлоход тусална.

### **Иргэний хууль нь дараахь бүтэцтэй байна.**

I дэвтэр: Ерөнхий хэсэг (§§ 1–240 BGB)

II дэвтэр: Үүрэг (§§ 241–853 BGB)

III дэвтэр: Өмчийн тухай хууль (§§ 854–1296 BGB)

IV ном: Гэр бүлийн тухай хууль (§§ 1297–1921 BGB)

V дэвтэр: Өв залгамжлалын тухай хууль (§§ 1922–2385 BGB)

### **Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны талаар:**

### **802в-р зүйл. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийн тухай мэдүүлэг**

(1) Төлбөр төлөгч мөнгөн төлбөр гаргуулах шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор шийдвэр гүйцэтгэгчийн шаардснаар өөрийн эд хөрөнгийн байдлын тухай мэдүүлгийг дараахь зохицуулалтын дагуу гарган өгөх үүрэгтэй бөгөөд өөрийн төрсөн нэр, огноо, газрыг мэдэгдэнэ. Төлбөр төлөгч нь хуулийн этгээд эсхүл иргэдийн байгуулсан холбоо, нийгэмлэг<sup>44</sup> бол компанийн нэр, бүртгэлийн дугаар, оршин байх газрын хаягаа мэдэгдэнэ.

(2) Төлбөр төлөгч эд хөрөнгийнхөө тухай мэдүүлэг гаргахдаа өөрт хамаарах бүхийл хөрөнгийг дурьдана. Шаардах эрхийн тухайд түүний үндэслэл болон нотлох баримтыг тодорхойлон заана. Түүнчлэн дараахь зүйлсийг тусгана:

1. Төлбөр төлөгчийн энэ хуулийн 802е-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс хоёр жилээс доошгүй хугацааны өмнө ойр дотны хүндээ төлбөртэй шилжүүлсэн эд хөрөнгө (Дампуурлын тухай хуулийн 138-р зүйл);

2. Төлбөр төлөгч энэ хуулийн 802е-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс дөрвөн жилээс доошгүй хугацааны өмнө бусдад шилжүүлсэн бөгөөд ёс заншлын дагуу бэлэглэсэн, ялимгүй өртөг бүхий зүйлсээс бусад эд хөрөнгө. Барьцааны зүйлийг орлуулан солихоос<sup>45</sup> бусад тохиолдолд энэ хуулийн 811.1.1 ба 2-р зүйлд зааснаар барьцаалж үл болох эд хөрөнгийг мэдүүлэгт тусгахгүй байж болно.

(3) Төлбөр төлөгч нь энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан мэдээллийг үнэн, зөв бөгөөд бүрэн гүйцэд өгсөн гэдгээ тангараг орлох батламж<sup>46</sup> өгөн тэмдэглэлд тусгуулна. Энэ хуулийн 478-480 болон 483-р зүйл нэгэн адил хэрэгжинэ.

802к-р зүйл. Шийдвэр гүйцэтгэгчийн мэдээлэл авах эрх

(1) Төлбөр төлөгч эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөх үүргээ биелүүлэхгүй байвал эсхүл жагсаалтад байгаа эд хөрөнгө төлбөр авагчийн шаардлагыг бүрэн хангаж хүрэхгүй нь мэдэгдэж байгаа тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч дараахь арга хэмжээг авч болно:

1. Хуульд заасан тэтгэвэрийн даатгагчаас түүний овог, нэрийг эсхүл компанийн хаяг, төлбөр төлөгчийн даатгалд зайлшгүй хамруулах ажил хөдөлмөрийн харилцаатай одоогийн ажил олгогчийн хаягийг тодруулах;

---

<sup>44</sup> Personenvereinigung гэснийг ингэж бичлээ. Орч.

<sup>45</sup> Austauschpfändung гэсэн байна. Барьцаанд авах нэг юмны оронд өөр юм авч байгааг ингэж бичлээ. Орч.

<sup>46</sup> Eidesstattliche Versicherung. Тангараг өргөхөөс арай сул хэлбэр нь. Үүнийг худал гаргасан бол германы эрүүгийн хуулиар(156-р зүйл) 3 жил хүртэл ял оногдуулдаг. Ийм маягаар монголчлов. Орч.

2. Татварын ерөнхий хуулийн 936-р зүйлийн 1-д заасан мэдээллийг зээлийн байгууллагаас тодруулж өгөхийг холбооны татварын ерөнхий газраас хүсэх (Татварын ерөнхий хуулийн 93.8-р зүйл);

3. Замын хөдөлгөөний дүрмийн тухай хуулийн 33.1-р зүйлд зааснаар тээврийн хэрэгсэлийн жолоочоор бүртгэгдсэн этгээд төлбөр төлөгч мөн эсэхийг тодруулахаар холбооны тээврийн албаны автомашин-жолоочийн бүртгэлээс мэдээлэл хүсэх.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бөгөөд шаардах эрхийн үнийн дүн 500 еврогоос доошгүй байгаа тохиолдолд мэдээллийг авах эсхүл хүсэлт гаргаж болно. Шийдвэр гүйцэтгэлийн зүйл нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал ба дагалдах шаардлага байсан тохиолдолд үнийн дүнг тогтооход түүнийг харгалзан үзнэ.

(2) Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд үл хамаарах мэдээллийг шийдвэр гүйцэтгэгч нэн даруй устгах буюу түгжинэ. Устгасан тухай тэмдэглэлд дурьдана.

(3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шийдвэр гүйцэтгэгч мэдээлэл авсан буюу хүсэлт гаргасны үр дүнг энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг баримтлан төлбөр авагчид нэн даруй, төлбөр төлөгчид үр дүн мэдэгдсэнээс хойш дөрвөн долоо хоногийн дотор тус тус мэдэгдэнэ. Энэ хуулийн 802г-р зүйлийн 1 дэх хэсгийн 1-р өгүүлбэр ба 2 хэсэг нэгэн адил хэрэгжинэ

850-р зүйл.Барьцаалах хөдөлмөрийн цалин хөлсний хэмжээг тооцох

Барьцаалах хөдөлмөрийн цалин хөлсний хэмжээг тооцоход дараахь зүйлсийг баримтална:

1. Энэ хуулийн 850а-р зүйлд заасан үл барьцаалах орлого, түүнчлэн татварын эсхүл нийгмийн халамжийн эрх зүйн зохицуулалтын дагуу төлбөр төлөгчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд суутгах мөнгийг оруулан тооцохгүй. Түүнчлэн эдгээр мөнгөтэй төлөх хугацаа нь давхцах төлбөр төлөгчийн

а) нийгмийн даатгалын хуулийн дагуу давхар даатгалд төлөх хураамж эсхүл

б) ердийн хэмжээнээс хэтрээгүй бол эрүүл мэндийн даатгалын нөөц касс эсвэл хувийн компанид төлсөн хураамжийг адилтган үзнэ.

2. Хэд хэдэн хөдөлмөрийн цалин хөлсийг шийдвэр гүйцэтгэлийн шүүх хүсэлтийг үндэслэн нэгтгэн тооцно. Төлбөр төлөгчийн амьжиргааны гол суурь болсон үл барьцаалах цалин хөлсийг тэргүүн ээлжинд тусгаарлана.

2а. Барьцаалагдах орлогод хамаарах бол Нийгмийн халамжийн хуулийн дагуу үргэлжлэн төлөгдөх мөнгөн төлбөр шаардах эрхийг хүсэлтийг дагуу хөдөлмөрийн цалин хөлсөд оруулан тооцно. Хуульд зааснаар тэтгэмж төлөх шаардлагыг хангахын тулд барьцаалсанаас бусад тохиолдолд үл барьцаалах үндсэн мөнгөн дүнг Нийгмийн халамжийн тухай хуулийн зохицуулалтаар тодорхойлно. Орлогын албан татварын тухай хуулийн 76-р зүйл эсхүл Нийгмийн халамжийн тухай хуулийн 54в5-р зүйлд зааснаар барьцаалах боломжтой тохиолдолд хүүхдэд төлөх мөнгөн төлбөрийг шаардах эрхийг хөдөлмөрийн цалин хөлсөнд оруулан тооцно.

3. Төлбөр төлөгч мөнгөн хэлбэрийн хөдөлмөрийн цалин хөлсний зэрэгцээ эд зүйлс хүлээн авдаг бол мөнгө ба эд зүйлсийг нэгтгэн тооцно. Энэ тохиолдолд мөнгөн хэлбэрийн цалин хөлсийг барьцаалах хэмжээ нь эд зүйлсийн үнэ цэнийг тооцон төлбөр авагчийн шаардлагыг хангаж үлдэх төлбөрийн хэмжээгээр тодорхойлогдоно.

4. Барьцаа, эрх шилжүүлэлт эсхүл энэ хуулийн 850г-д заасан шаардах эрх нь өөр шаардах эрхтэй холбоотой барьцаатай давхцаж байвал тэтгэмж төлүүлэх шаардах эрхэд 850г-д зааснаар нэмэгдүүлсэн барьцаанд үүнийг оруулан тооцно. Шийдвэр гүйцэтгэлийн шүүх аль нэг оролцогчын хүсэлтээр ийнхүү оруулан тооцно. Гуравдагч үүрэг гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрийг хүргүүлэхээс өмнө барьцаалах, эрх шилжүүлэх тухай эсхүл бусад захирамжийн талаар өөрт мэдэгдэж буй агуулгын дагуу үүрэг гүйцэтгэж болох ба ингэж гүйцэтгэсэн үүргийг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.

882-р зүйл. Мөнгөн төлбөр гаргуулах шаардах эрхийн үндсэн дээр явуулах шийдвэр гүйцэтгэл

(1) Холбооны улс, муж улсын эсрэг мөнгөн төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эд юмсын эрхтэй холбоотойгоос бусад тохиолдолд төлбөр төлөгчийн төлөөлөгчөөр тодорхой байгууллагыг томилсон буюу эд хөрөнгийг өөр байгууллага захиран зарцуулж байгаа бол хариуцсан Сангийн яаманд мэдэгдэж төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулуулах тухайгаа илэрхийлсэнээс хойш дөрвөн долоо хоногийн дараа эхлүүлнэ.

(2) Тухайн эд хөрөнгө төлбөр төлөгчийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй эсхүл түүнийг бусдад шилжүүлэх нь нийтийн ашиг сонирхолд харшлах бол шийдвэр гүйцэтгэл явуулахгүй. Энэ хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасан угтвар нөхцөл үүссэн эсэхийн талаар маргаан гарсан тохиолдолд 766-р зүйлийн дагуу шийдвэрлэнэ.

(3) Энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан журам нийтийн эрх зүйн байгууллага, нийгэмлэг, сангуудын эсрэг шийдвэр гүйцэтгэл явуулахад энэ

зүйлийн 1 дэх хэсэгт заасан утгаар төрийн байгууллагын оронд түүний хууль ёсны төлөөлөгч оролцоно гэж тооцно.

(4) (Хүчингүй болсон)

(5) Түр захирамжийг<sup>47</sup> гүйцэтгэх тохиолдолд шийдвэр гүйцэтгэх болсоныг мэдэгдэх ба энэ зүйлийн 1 ба 3 дахь хэсэгт заасан хүлээх хугацааг баримтлах шаардлагагүй.

Эд хөрөнгө гаргуулах, тодорхой үйлдэл хийлгэх эсхүл хийхгүй байхыг даалгасан шийдвэрийг гүйцэтгэх

883-р зүйл. Тодорхой хөдлөх эд хөрөнгө гаргуулах

(1) Төлбөр төлөгч тодорхой эд хөрөнгө эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө гарган өгөх бол шийдвэр гүйцэтгэгч түүнийг хураан авч төлбөр авагчид шилжүүлнэ.

(2) Гаргуулах эд хөрөнгө олдоогүй бол төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгч тухайн эд хөрөнгө нь түүний эзэмшилд байхгүй, хаана байгааг нь мэдэхгүй тухай шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд тусгуулж тангараг орлох батламж гаргана. Энэ хуулийн 802д-р зүйлд заасан шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийг тангараг орлох батламж гаргуулахаар дуудан ирүүлнэ. Энэ хуулийн 478-480, 483, 802е-р зүйлийн 4, 802ё-р зүйлээс 802з-р зүйл болон 802и-р зүйлийн 1 ба 2 дах хэсэг нэгэн адил хэрэгжинэ.

(3) Шүүх хэргийн нөхцөлд байдал өөрчлөгдсөнд нийцүүлэн тангараг орлох батламж гаргуулан авч болно.

(4) (Хүчингүй болсон)

884-р зүйл. Төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө шилжүүлэх

Төлбөр төлөгч тодорхой тооны төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө эсхүл үнэт цаас шилжүүлэн өгөх үүрэгтэй бол энэ хуулийн 883.1-р зүйл нэгэн адил хэрэгжинэ.

885-р зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө ба хөлөг онгоц гаргуулах

(1) Төлбөр төлөгч үл хөдлөх эд хөрөнгө, бүртгүүлсэн хөлөг онгоц эсхүл баригдаж буй хөлөг онгоц гарган өгөх, ашиглалтад шилжүүлэх эсхүл чөлөөлж өгөх бол шийдвэр гүйцэтгэгч тэдгээрийг төлбөр төлөгчийн эзэмшилээс салгаж төлбөр авагчийн эзэмшилд өгнө. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс баримт бичиг хүргүүлэх зорилгоор өөрийн эсхүл баримт бичиг хүргүүлэх итгэмжлэгдсэн этгээдийн хаягийг өгөхийг шаардана.

---

<sup>47</sup> Einstweilige Verfügung. Энэ нь монголын ИХШХШТХ-ийн 70-р зүйлд заасан "шүүхээс гарах шийдвэрийн баталгаажилттай" төстэй захирамж. Орч.

(2) Шийдвэр гүйцэтгэлийн зүйлд хамаарахгүй хөдлөх эд хөрөнгийг шийдвэр гүйцэтгэгч салган авч төлбөр төлөгчид, төлбөр төлөгч эзгүй үед төлбөр төлөгчийн итгэмжлэгдсэн этгээд, гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, уг гэр бүлд ажилладаг эсхүл байнга хамт амьдардаг этгээдэд өгөх буюу захиран зарцуулалтад шилжүүлнэ.

(3) Төлбөр төлөгч эсхүл нэр дурьдагдсан этгээд эзгүй байсан эсхүл хүлээн авахаас татгалзсан бол шийдвэр гүйцэтгэгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан эд хөрөнгийг төлбөр төлөгчийн зардлаар барьцааны агуулахад хүргэх эсхүл бусад байдлаар хадгална.

(4) Төлбөр төлөгч эд хөрөнгийг нүүлгэн гаргаснаас хойш нэг сарын дотор буцаан шаардаагүй бол шийдвэр гүйцэтгэгч уг эд хөрөнгийг борлуулж орлогыг нь хадгалуулна. Төлбөр төлөгч нэг сарын дотор эд хөрөнгөө буцаан шаардсан боловч нүүлгэн гаргаснаас хойш хоёр сарын дотор зардлыг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг борлуулж орлогыг хадгалуулна. Энэ хуулийн 806, 814 ба 817-р зүйлүүдийг нэгэн адил хэрэглэнэ. Борлуулах боломжгүй эд хөрөнгийг устгана.

(5) Үл барьцаалагдах эд хөрөнгө ба борлуулж орлого олох боломжгүй эд хөрөнгийг төлбөр төлөгч буцаан шаардсан бол хэдийд ч буцаан олгож болно.

885-р зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн даалгавар хязгаарлагдмал байх

(1) Шийдвэр гүйцэтгэл явуулах даалгаварыг энэ хуулийн 885.1-р зүйлд зааснаар хязгаарлаж болно.

(2) Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад олсон, нүдэнд ил байгаа хөдлөх эд хөрөнгийг баримтжуулан тэмдэглэнэ. Шийдвэр гүйцэтгэгч цахим хэлбэрээр зураг авч баримтжуулан тэмдэглэж болно.

(3) Шийдвэр гүйцэтгэлд хамаарахгүй хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагч хэдийд ч салган тусгаарлаж болох бөгөөд тэдгээрийг хадгалах үүрэгтэй. Хадгалах сонирхолгүй хөдлөх эд хөрөнгийг хэдийд ч устгаж болно. Энэ хэсгийн 1 ба 2 дахь өгүүлбэрт заасан тохиолдолд төлбөр авагч санаатай эсхүл илт болгоомжгүй хандсан гэм буруутай тохиолдолд хариуцлага хүлээнэ.

(4) Эд хөрөнгийг төлбөр авагчийн эзэмшилд шилжүүлсэнээс хойш төлбөр төлөгч нэг сарын дотор буцаан авахаар шаардаагүй бол төлбөр авагч тэдгээрийг борлуулж болно. Иргэний хуулийн 372-380, 382, 383 ба 385-р зүйлүүд нэгэн адил хэрэглэнэ. Дуудлага худалдаа явуулах тухай захирамж гаргахгүй. Борлуулах боломжгүй эд хөрөнгийг устгаж болно.

(5) Үл барьцаалагдах эд хөрөнгө ба борлуулж орлого олох боломжгүй эд хөрөнгийг төлбөр төлөгч буцаан шаардсан бол хэдийд ч буцаан олгож болно.

(6) Орон байрнаас нүүлгэн гаргах тов тогтооход шийдвэр гүйцэтгэгч энэ зүйлийн 2-5 дахь хэсгийн заалтыг төлбөр төлөгч ба төлбөр авагчид сануулна.

(7) Энэ зүйлийн 3 ба 4 дэх хэсэгт заасан зардал нь шийдвэр гүйцэтгэлийн зардалд хамаарна.

886-р зүйл. Гуравдагч этгээдийн мэдэлд<sup>48</sup> байгаа зүйлийг гаргуулах

Гаргуулах эд хөрөнгө гуравдагч этгээдийн мэдэлд байгаа бол тухайн эд зүйлийг шаардах төлбөр төлөгчийн эрхийг мөнгөн төлбөр гаргуулах шаардлагыг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтын дагуу төлбөр авагчид шилжүүлнэ.

887-р зүйл. Төлөөлүүлэн гүйцэтгэх үйлдэл

(1) Төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх үүргээ гүйцэтгэхгүй байгаа бөгөөд түүнийг гурвадагч этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой тохиолдолд хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх хүсэлтийг үндэслэн төлбөр авагчид тухайн үйлдлийг төлбөр төлөгчийн зардлаар гүйцэтгэх эрх олгож болно.

(3) Төлбөр авагч тухайн үйлдлийг гүйцэтгэснээр үүсэх зардлыг төлбөр төлөгчөөр урьдчилан төлүүлэхээр хүсэлт гаргаж болох ба энэ хүсэлт нь тухайн үйлдлийг гүйцэтгэснээр илүү их зардал гарсаныг хожим нөхөн төлүүлэх эрхэд харшлахгүй.

(3) Эд хөрөнгө гаргуулах ба шилжүүлэх ажиллагаанд дээрх хэсгийн зохицуулалт нэгэн адил хэрэгжинэ.

888-р зүйл. Төлөөлүүлэн гүйцэтгэхгүй үйлдэл

(1) Гүйцэтгэх үйлдлийг гуравдагч этгээдээр төлөөлүүлэн гүйцэтгэх боломжгүй бөгөөд гагцхүү төлбөр төлөгчийн хүсэл зоригоос шалтгаалах тохиолдолд хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх хүсэлтийг үндэслэн төлбөр төлөгчийг үйлдэл хийлгэхэд албадах зорилгоор мөнгөн торгууль ногдуулах эсхүл төлбөр төлөх чадваргүй бол баривчлах замаар албадна. Нэг удаа ногдуулах мөнгөн торгуулийн хэмжээ 25000 еврогоос ихгүй байна. Албадан баривчлахад энэ хуулийн 2 дугаар бүлэг дэх баривчилгааны тухай зохицуулалт нэгэн адил хэрэгжинэ.

(2) Албадлагын арга хэмжээг хэрэглэх тухай урьдчилан сануулахгүй.

---

<sup>48</sup> Gewahrsam. Дээр тайлбарласан.

(3) Энэ зүйлийг хөлсөөр ажиллах гэрээний үүргийг биелүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд хэрэглэхгүй.

888-р зүйл. Хохирол нөхөн төлөх шийдвэрийг гүйцэтгэхэд албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх

Хариуцагчийг энэ хуулийн 5106-р зүйлд<sup>49</sup> зааснаар хохирол нөхөн төлүүлэх шийдвэр гарсан бол 887 ба 888-р зүйлүүдэд зааснаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахгүй.

889-р зүйл. Иргэний эрх зүйн дагуу гаргах тангараг орлох батламж

(1) Төлбөр төлөгч иргэний эрх зүйн зохицуулалтын дагуу шүүхийн шийдвэрээр тангараг орлох батламжийг гаргах үүрэгтэй бол түүнийг төлбөр төлөгчийн дотоодод байнга оршин суух газрын анхан шатны шүүхийг шийдвэр гүйцэтгэлийн шүүхэд тооцон эсхүл байнга оршин суух газаргүй тохиолдолд хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн нутаг дэвсгэр дэх шийдвэр гүйцэтгэлийн шүүхэд батламжийг гаргана.

(2) Төлбөр төлөгч тангараг орлох батламж гаргах тогтоосон хугацаанд ирээгүй эсхүл ийм батламж гаргахаас татгалзсан бол шийдвэр гүйцэтгэлийн шүүх энэ хуулийн 888-р зүйлд зааснаар ажиллана.

890-р зүйл. Эс үйлдэхийг ба хүлцэхийг албадах

(1) Төлбөр төлөгч үйлдэл хийхгүй байх эсхүл тодорхой үйлдэл хийснийг хүлцэх үүргээ зөрчсөн бол төлбөр авагчийн хүсэлтээр хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүхээс зөрчил бүрт мөнгөн торгуульногдуулах эсхүл мөнгөн торгуулийг төлөх боломжгүй тохиолдолд зургаан сар хүртэл баривчлах шийдвэр гаргана. Нэг удаа ногдуулах торгуулийн хэмжээ 250000 еврогоос ихгүй, баривчлах нийт хугацаа хоёр жилээс ихгүй байна.

(2) Үүрэг ногдуулсан шүүхийн шийдвэрт дурьдаагүй бол шийдвэр гаргахаас өмнө хүсэлтийг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхээс албадлагын арга хэмжээний тухай урьдчилан сануулна.

(3) Төлбөр авагч хүсэлт гаргасан бол төлбөр төлөгчийг зөрчил гаргасны улмаас үүдэх хохиролыг нөхөн төлүүлэх баталгааг гаргуулахаар шүүхээс шийдвэрлэж болно.

891-р зүйл. Хэрэг шийдвэрлэх ажиллагаа, төлбөр төлөгчийн тайлбар, зардлын тухай шийдвэр

---

<sup>49</sup>5106-р зүйл нь хариуцагч тодорхой үйлдэл хийхээр шүүхийн шийдвэр гарсан боловч түүнийгээ хийгээгүй бол учирсан хохиролыг нөхөн төлнө. Шүүх нөхөн төлөх хохиролын хэмжээг өөрөө мэдэн тогтооно гэсэн агуулгатай зохицуулалт байна.



Энэ хуулийн 887-890 дүгээр зүйлүүдэд заасан шийдвэрийг захирамж хэлбэрээр гаргана. Шийдвэр гаргахаас өмнө төлбөр төлөгчийн тайлбарыг авна. Зардлын тухай шийдвэр гаргахад энэ хуулийн 91-93, 95-100, 106, 107 дугаар зүйлүүд нэгэн адил хэрэгжинэ.

892-р зүйл. Төлбөр төлөгч эсэргүүцэл үзүүлэх

Төлбөр төлөгч энэ хуулийн 887-р зүйлд зааснаар хүлцэх үүрэгтэй үйлдлийн эсрэг эсэргүүцэл үзүүлсэн бол төлбөр авагч шийдвэр гүйцэтгэгчийг татан оролцуулах ба шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 758.3 ба 759-р зүйлд зааснаар ажиллагаа явуулна.

892а-р зүйл. (Хүчингүй болсон)

893-р зүйл. Ашиг сонирхолыг<sup>50</sup>гүйцэлдүүлэх нэхэмжлэл

(1) Төлбөр авагчийн ашиг сонирхолоо гүйцэлдүүлэх шаардах эрхэд энэ бүлгийн зохицуулалтууд саад учруулахгүй.

(2) Ашиг сонирхолоо гүйцэлдүүлэхийг шаардах эрхээ төлбөр авагч хэргийг анхан шатны журмаар шийдсэн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар хэрэгжүүлнэ.

894-р зүйл. Хүсэл зоригийн илэрхийлэл гаргасанд тооцох

Төлбөр төлөгчөөр хүсэл зоригийн илэрхийлэл гаргуулахаар шүүхээс шийдвэрлэсэн бол шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсоноор хүсэл зоригийн илэрхийллийг гаргасанд тооцно. Хүсэл зоригийн илэрхийлэлийг хариу үүргээс хамааралтай болгосон бол энэ хуулийн 726, 730 дугаар зүйлд заасан урьдчилан гүйцэтгэгдэх боломжтой хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хуулбарыг олгосноор дээрх үр дагавар гарсанд тооцно.

---

<sup>50</sup> Interesse. Энэ зүйлд яригдаж байгаа ашиг сонирхол гэдэг нь хохирол нөхөн төлүүлэх эрх юм. Орч.

### **3.4. БНСУ-д шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдээс төлбөр гаргуулж буй онцлог**

БНСУ-ын 2002 оны Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт зааснаар төлбөр төлөгч иргэн болон төлбөр төлөгч хуулийн этгээд нар “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 320, 321 дүгээр зүйл нь энэ зүйлийн 1-т заасан тангарагт нэгэн адил хамаарна. Энэ тохиолдолд бичгэн тангараг нь дараах агуулгатай байвал зохино. Би өөрийн ухамсрын дагуу эд хөрөнгийн жагсаалтыг байгаа байдлаар нь бэлдэж хүргүүлсэн бөгөөд ямар нэг зүйлийг нуун дарагдуулсан буюу худал мэдүүлсэн бол зохих шийтгэлийг хүлээхээ амалж байна.” гэж шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай тангараг өргөдөг.<sup>51</sup>

Тангаргаа эс биелүүлбэл хуулийн хариуцлагыг бүх хүн, хуулийн этгээд хүлээдэг. Энэ тухай Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 68 дугаар зүйлд өр төлбөртэй этгээдийг баривчлах, шийтгэл ногдуулахаар зохицуулжээ. Үүнд:

1. Эд хөрөнгийг тодруулах өдөр ирээгүй;
2. Эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж өгөхөөс татгалзсан;
3. Тангараг өргөхөөс татгалзсан.

Өр төлбөртэй этгээд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дээрх заалтад заасан үйлдлийг гаргасан тохиолдолд шүүх өөрийн шийдвэрээр 20 хүртэл хоногоор баривчлах шийтгэл ногдуулна гэж заасан байна.<sup>52</sup>

Өр төлбөртэй этгээд нь хуулийн этгээд, холбоо, сан бол түүний төлөөлөгч буюу албан тушаалтныг баривчлах шийтгэлээр шийтгэхээр зохицуулжээ.

БНСУ-ын Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийг өөрийн орны хуультай харьцуулан үзвэл хуулийн бүтэц, зохион байгуулалтаараа ялгаатай.

Манай Улсын хуульд төлбөр төлөгч иргэнээс, төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа хэмээн ангилж үздэг бол БНСУ-ын хуульд усан онгоцны албадан дуудлага худалдаа, хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаа, үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаа, бэлэн мөнгө нэхэмжлэхээс бусад төрлийн нэхэмжлэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэх зэргээр ангилдаг байна. Өөрөөр хэлбэл иргэн болон хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа нэг зарчмаар явагддаг гэсэн үг юм.

---

<sup>51</sup> БНСУ-ын Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль. 2002 он., 65 дугаар зүйл.

<sup>52</sup> БНСУ-ын Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль. 2002 он., 68 дугаар зүйл

БНСУ-ын Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн нэг онцлог зохицуулалт нь гадаад улсад явуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулсан байдаг.

Гадаад Улсад албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах тохиолдолд тухайн гадаад Улсын нийтийн албатай хуулийн дагуу хамтран ажиллах боломжтой бол анхан шатны шүүх нь зээлдүүлэгчийн хүсэлтээр гадаадын нийтийн албанд эрх олгодог эсхүл гадаад улсад байрлах Бүгд Найрамдах Солонгос Улсын консул албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой бол анхан шатны шүүх нь консулд эрх олгох замаар ажиллагаа явуулдаг байна.

Албадан ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1.Зөвхөн давж заалдах замаар нэхэмжлэл гаргах боломжтой шүүхийн шийдвэр;

2.Урьдчилан гүйцэтгэх ажиллагааны зарлал агуулсан шүүхийн шийдвэр;

3.Эцэслэгдэн хүчин төгөлдөр болсон төлбөрийн даалгавар;

4.Тодорхой хэмжээний төлбөрийг төлсөн болон өр төлбөртэй этгээдээс албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүлээн зөвшөөрсөн тухай нотариатын гэрчилсэн баримт болон эцэслэгдэж хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэртэй ижил үр дагавар бүхий шүүхийн эвлэрэл, нэхэмжлэлийг зөвшөөрч хүлээн авах болон бусад шийдвэр.

Мөн төлбөрийн даалгавар ба түүнийг биелүүлэхтэй холбогдсон харилцаа хамаарна. Эцэслэгдэж хүчин төгөлдөр болсон төлбөрийн даалгаварт үндэслэсэн албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэлийн заалт шаардахгүйгээр төлбөрийн даалгаврын батламжилсан хувь дээр үндэслэн хийх бөгөөд энэхүү заалт нь дараах заалтад заасан тохиолдолд хамаарахгүй байна. Үүнд:

1.Төлбөрийн даалгаврыг гүйцэтгэхэд саад болох нөхцөл байдал үүссэн;

2.Албадан гүйцэтгэх ажиллагаанд зээлдүүлэгчийн залгамжлагч оролцож байгаа;

3.Албадан гүйцэтгэх ажиллагаанд өр төлбөртэй этгээдийн залгамжлагч оролцож байгаа тохиолдолд хамаарна.

Зээлдүүлэгч төлбөрийн даалгаврын хэд хэдэн батламжилсан хувь гаргуулахаар хүсэлт гаргасан, эсхүл өмнө нь олгосон төлбөрийн даалгаврын батламжилсан хувийг буцааж ирүүлэлгүйгээр ахин гаргуулах хүсэлт гаргасан бол шүүхийн захиргааны багаас тушаалыг гаргаж өгнө.

Манай Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны нэгэн адил БНСУ-д нотариатын гэрчилсэн баримт, түүнийг гүйцэтгэх ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

1.Нотариатын гэрчилсэн баримтыг гүйцэтгэх заалтыг тухайн баримтыг хадгалагч нотариатч олгоно.

2.Нотариатын гэрчилсэн баримтад гүйцэтгэх заалт гаргуулах хүсэлтийг шийдвэрлэсэн нотариатчийн шийдвэрт гомдол гаргах бол тухайн гомдлыг нотариатчийн албан газар байрлах нутаг дэвсгэрийг харъяалах дүүргийн шүүхийн шүүгч дангаар шийдвэрлэнэ.

Солонгосын хуулийн бас нэгэн онцлог зохицуулалт нь хайхрамжгүй байдлын торгуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг.

Хайхрамжгүй байдлын торгууль ногдуулсан шүүхийн шийдвэрийг төрийн прокурорын даалгавраар гүйцэтгэдэг байна.

Төлбөр авагчийн хүсэлтээр анхан шатны шүүх өр төлбөрийн шууд бус албадан ажиллагаа шаардлагатай байгаа нөхцөл байдлыг харгалзан үзэж шууд бус албадан ажиллагаа явуулах шийдвэр гаргаж болдог. Энэ нь тухайн шийдвэрт өр төлбөрийг төлөх цаг хугацааг тогтоох бөгөөд төлбөр төлөгч тогтоосон хугацааны дотор үүргээ гүйцэтгээгүй бол шүүх үүргээ гүйцэтгээгүй хоног тутамд алданги тооцох эсвэл учруулсан хохирлыг нөхөн төлөх шийдвэр гаргадаг онцлог зохицуулалттай байна.

Шийдвэр гүйцэтгэгчээр ажиллахын тулд шүүх болон прокурорын байгууллагад 25-аас дээш үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагч тэр дундаа өндөр насны тэтгэвэрт гарах хугацаа болж байгаа албан хаагчийг сонгон шалгаруулж томилдог байна.

Нийт шийдвэр гүйцэтгэгчийн 10% нь эмэгтэй албан хаагчтай байдаг. Шийдвэр гүйцэтгэгч нь нутаг дэвсгэрийн болон шүүхийн харъяалалтай нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг байдаг байна.

Шүүгч нь өөрийн гаргасан шүүхийн шийдвэртэй хяналт тавьж ажилладаг. Шийдвэр гүйцэтгэгч нь төрөөс цалин авдаггүй бөгөөд 4 жилийн хугацаанд нэг л удаа томилогдон ажилладаг хэдий ч зөвхөн гүйцэтгэсэн урамшууллаас насаараа амьдрах хөрөнгөө бий болгодог байна.

Жишээлбэл нэг шийдвэр гүйцэтгэгч дундараар 4 тэрбум вон хуримтлуулсан байдаг байна. Төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд гомдол гаргах явдал маш их байдаг бөгөөд шүүх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх захирамж гаргахаас татгалзсан тухай шийдвэр гаргадаг бөгөөд гомдол гаргах бүрт өндөр үнийн дүнтэй хураамж авдаг болсон цагаас төлбөр төлөлт шуурхай болсон давуу талтай байна.

Мөн дуудлага худалдаа нь тендерийн зарчимаар буюу далд хэлбэрээр явуулдаг нь тусгалгаа олж, дуудлага худалдаанд маргаан гардаггүй байна.23 Хууль бол тариачдын нар нь, насанд хүрэгчдийн ухаан нь, залуу хүний мэдрэмж нь, сүмд бол индэр нь, хуулийн байгууллагад хэл нь юм.

Хууль бол яг л хайр гэсэн үг. Уйлахаас өөр аргагүй, эцсээ хүртэл үнэнч байх боломжгүй зүйл гэж БНСУ-ын шүүгч, профессор Им Гуанху тодорхойлжээ.

БНСУ-ын хөдлөх хөрөнгө ба шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагааны онолын үндэс, бодит шижээг дурдвал.

- Үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гүйцэтгэл
- Хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гүйцэтгэл
- Хамгаалах арга хэмжээ авах гүйцэтгэл.

Үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гүйцэтгэл болон хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гүйцэтгэл нь:

- Эд хөрөнгийн шийдвэр гүйцэтгэл
- Шаардах эрх шийдвэр гүйцэтгэл гэсэн бүтэцтэй байдаг байна.

Хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах дараалал нь:



Битүүмжлэх



Бэлэн мөнгө болгох



Төлбөр төлөх (сэтгэл ханамж)

Битүүмжлэх: Төлбөр авагчийн хүсэлт, шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэх

Бэлэн мөнгө болгох: Тендер зарлах, үнэ хаялцуулах худалдаа, хөрөнгийг бүхэлд нь дуудлага худалдаанд оруулах, бэлэн мөнгө болгох онцгой арга

Төлбөр төлөх: Төлбөр авагчид төлбөрийг олгох /оногдол хувийг тохиролцох/ хуваарилах ажиллагааг явуулдаг дараалалтай.

Мөн БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагааны онцлогоос дурдвал:

Эдийн засаг хөгжихөөс өмнө хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө нь ихэвчлэн албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны объект болж байсан бол эдийн засаг хөгжихийг хэрээр шаардах эрх болон бусад хөрөнгөийн эрх үл хөдлөх хөрөнгөөс дутуугүй чухал хөрөнгийн үнэ цэнэтэй болж, үүнтэй холбоотой албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цар хүрээ нэмэгдэж байна.

БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагааг эхлүүлэхдээ БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 223 дугаар зүйл /шаардах эрхийг битүүмжлэх шийдвэр/ гуравдагч этгээдээс гаргуулах төлбөр төлөгчийн шаардах эрх болон үнэт цаасны эрх, бусад хөдлөх хөрөнгийн эрхийг шилжүүлэх, бусдад өгөх зорилгоор хэрэгжүүлэх шаардах эрхээс төлбөр гаруулах ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэх шүүхийн битүүмжлэх шийдвэрт үндэслэн эхэлдэг байна.

БНСУ-ын Бүртгэлийн байгууллага нь Шүүхийн харьяандаа үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд шүүгчийн захирамжаар бүртгэлийн байгууллагаас төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг олж авдаг бөгөөд төлбөр төлөгчийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааг төвөггүйхэн хийдэг нь шийдэр гүйцэтгэх ажиллагаа нь хурдан явагддаг байна.

## **Дүгнэлт**

ШШГЕГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/68 тоот Ажлын хэсэг байгуулах тухай тушаалын хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачид ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх албатай хамтран “Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” судалгааны ажлыг хийж гүйцэтгэн дараах дүгнэлтэд хүрлээ.

### **Нэг.Судалгааны ажлын арга зүйн хүрээнд:**

Судалгааны тайланд тусгагдсан тоо баримтыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Статистикийн төв газраас авсан албан ёсны мэдээ, тайлангаас авсан.

Түүнчлэн ШШГЕГ-ын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 250 шийдвэр гүйцэтгэгчийн 188 шийдвэр гүйцэтгэгчээс буюу 75.2%-иас судалгаа авлаа.

Ийнхүү асуулгад хамрагдсан алба хаагчдын тоо нь өндөр хувийг эзэлж байгаа нь судалгааны үнэн бодит байдлын магадлалыг өндөрсгөж өглөө.

Судалгааны ажлын явцад 3 иргэний шүүгч, 6 төлбөр төлөгч-хуулийн этгээдийн захиралтай биечлэн уулзаж асуулга авсан болно.

### **Хоёр.Шүүхээс хуулийн этгээдтэй холбоотой иргэний хэргийг шийдвэрлэж буй байдал:**

Иргэний хууль тогтоомжийн үндсэн зарчим нь эрх тэгш байх, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх, үүргийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах явдал байдаг.

Иргэний хэргийн анхан шатны шүүхэр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан нь 2016 онд 5677, 2017 онд 5646, 2018 онд 4828, 2019 онд 4392, 2020 онд 3497 хэрэг шийдвэрлэсэн нь жил бүр буурсан үзүүлэлттэй байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан нь 2016 онд 3, 2017 онд 4, 2018 онд 10, 2019 онд 190, 2020 онд 44 хэрэг шийдвэрлэсэн нь 2016-2019 он хүртэл өсч 2020 оноос буурсан үзүүлэлттэй байна.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хуулийн этгээдтэй холбоотой маргаан нь 2016 онд 6, 2017 онд 10, 2018 онд 34, 2019 онд 134, 2020 онд 4 хэрэг шийдвэрлэсэн нь 2016-2019 он хүртэл өсч 2020 оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **Гурав.Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны хэрэгжилт:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүд нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт 189210 гүйцэтгэх хуудасны 7.998.353.658.9 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 39355 гүйцэтгэх хуудасны 4.631.379.317.3 төгрөгийн төлбөрөөс 18183 гүйцэтгэх хуудасны 702.330.962.2 төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

### **Дөрөв. Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал:**

Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах тулгамдаж буй асуудлыг бүлэглэн авч үзвэл:

1. үйл ажиллагаа явуулахгүй байгаа хуулийн этгээдээс төлбөр гаргуулахад хүндрэлтэй байдаг;
2. хуулийн этгээд төлбөрийн чадваргүй бол үүсгэн байгуулагч нарын хөрөнгө зааглагдсан эсэхийг тодруулах гэж хугацаа алддаг;
3. шийдвэр гүйцэтгэх явцад шүүхэд хандаж ажиллагааг зогсоодог;
4. хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн банкин дахь харилцах данснаас суутгал хийхэд төлбөр төлөгч этгээд бус гэсэн үндэслэлээр хасалт хийдэггүй. Компаний данс хаалттай үед үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч дансаараа компанийн гүйлгээг хийж байна;
5. төлбөр төлөгч хуулийн этгээдийн хаяг тодорхойгүй;
6. төрийн байгууллагаас төлбөр гаргуулхад төсөв байхгүй төсвийн тодотголд дараа жил суулгаж өгнө гэх тайлбар өгдөг зэрэг байна.

### **Тав.Гадаадын зарим орны хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа:**

Судалгааны явцад судалсан гадаад орнуудад хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны онцлог нь шийдвэр гүйцэтгэгч хуулийн этгээдийн эд хөрөнгийг нэг бүрчлэн тодорхойлох, улмаар санхүү, бүртгэлийн системийг бүрэн ашигладаг байна.

### **Санал-зөвлөмж**

1. Компанийн тухай хуулийн 9.5-т "хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд



хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэж заасан.

Эндээс компанид оруулсан эд хөрөнгийг хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэдгийг тогтоох арга нь:

1. компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

2. хөрөнгийн бодит шилжилтээр тогтоох ёстой, үүнд хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөө компанийн нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэх, оруулсны дараа өөрийн хувийн хөрөнгө рүү шилжүүлээгүй байх, ноогдол ашгаас бусдаар өөртэй шилжүүлэн авах, компанийн ашиг, орлогыг хувийн дансандаа шилжүүлсэн байвал хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэх үндэслэл болно.

Компанийн хувьцаа эзэмшигч компанийн эд хөрөнгөөс хувийн эд хөрөнгөнөөс зааглаагүй тохиолдолд өөрийн хувийн эд хөрөнгөнөөс бүрэн хариуцлага хүлээнэ.

Шийдвэр гүйцэтгэгч зааглагдаагүй эд хөрөнгийг тогтоох үүргийг хүлээн төлбөрийг гаргуулах нь зүйтэй юм. Энэ үүргийг гүйцэтгэхэд санхүү, нягтлан бодох бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг шаардлагатай юм.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэшсэн нягтлан бодох бүртгэл, аудитын байгууллагатай хамтран ажилладаг тогтолцоонд шилжих

2. Хуулийн этгээдийн оршин суух хаягийн шилжилт, хөдөлгөөнийг Бүртгэлийн байгууллага тухай бүр шинэчлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж өгөх зэрэг болно.

## **Эх сурвалжийн жагсаалт**

### **Нэг.Хууль:**

1. Иргэний хууль
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай
4. Компанийн тухай хууль
5. Улсын бүртгэлийн ерөнхий хууль
6. Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль
7. Хоршооны тухай хууль
- 8.Төрийн бус байгууллагын тухай хууль

### **Хоёр. Ном, сурах бичиг:**

- 1.“Монгол Улсад хэрэгжсэн мөнгөний бодлого: 100 жилийн түүхэн сургамж” судалгааны ажил. Н.Баяртсайхан. 2018 он
- 2.Санхүүгийн боловсрол /багшийн ном/. Монгол банк, Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сан. 2019 он. 12 дугаар сар Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв. Сар тутмын макро эдийн засгийн тойм. 2019 он
- 3.ННФ.Дампуурлын эрх зүй. гарын авлага. 2014 он
4. Монгол Улсын Дээд Шүүх. Монголын шүүх.2 дахь боть
5. Б.Баярсайхан.Хууль зүйн тайлбар толь /МУ-ын төр, эрх зүйн түүх/ 2003 он
6. Т.Мөнхжаргал. МУ-ын Иргэний цаазын товчоон. 2006 он
7. С.Энхбаяр. ИХШХШийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд” 2005 он
8. Ж.Урангуа, Б.Баярсайхан. Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм /1913-1918/. эх бичгийн судалгаа. 2004 он
9. Федеральная Служба судебных приставов.Государственная и частная системы принудительного исполнения:сравнительный анализ и лучшие практики. сборник материалов. 9-й международной научно-практическое конференций. 10 октября 2018

### **Гурав. Судалгааны тайлан, материал:**

- 1.Монгол банк. Арилжааны банкуудын зээлийн тайлан
2. Санхүүгийн зохицуулах хороо
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- 4.Ю.Оюунаа,М.Хажидмаа.Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал” судалгаа.2020 он
- 5.Шийдвэр гүйцэтгэх албаны 1996-2020 оны тайлан
- 6.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2011-2020 оны тайлан
- 7.ДХИС.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт.2020 он

## Хавсралт

### Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн актын жагсаалт:

д/д	Журмын нэр	Дугаар	Огноо	
			Баталсан	Дагаж мөрдөж эхэлсэн
<b>Нэг.Хууль:</b>				
1	Иргэний хууль		2002-01-10	2002-02-05
2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх		2002-01-10	2002-09-01
3	Зөрчлийн тухай		2017-05-11	2017-07-01
4	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль		2017-05-18	2017-07-01
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай		2017-06-09	2017-07-01
6	Банкны тухай хууль		2010-01-18	2010-01-18
7	Компанийн тухай хууль		2011-11-06	2011-11-26
8	Төрийн бус байгууллагын тухай хууль		1997-01-31	1997-01-31
9	Улсын бүртгэлийн ерөнхий хууль		2018-06-21	2018-06-21
10	Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль		2011-11-27	2011-11-05
11	Хоршооны тухай хууль		2021-05-06	
<b>Хоёр.Засгийн газрын тогтоол:</b>				
1	Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журам	242	2007-09-27	
2	Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай	194	2017-07-04	
3	Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам	195	2017-07-04	
4	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	01	2017-10-26	
5	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	258	2018-08-22	
<b>Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал:</b>				
1	Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зарцуулах, төлбөр авагчид буцаан олгох журам	ХЗДХС, СС-ын А/107/13 2	2018-06-06	
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив	ХЗДХС, ХНХС, СС-ын А/247/16 7/303	2017-09-29	
3	Гадаадад оршин суугаа төлбөр авагчид төлбөрийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх газрын данснаас банкаар дамжуулан	ХЗДХС, Монгол банкны Ерөнхий	2017-10-18	

	гадаад төлбөр тооцооны журмаар олгох, шилжүүлэх журам	лөгчийн А/259/270		
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам	ХЗДХС, УЕП-ын А/260/112	2017-10-18	
5	Шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах журам	А/215	2017-08-31	
6	Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, тодорхойлолт, лавлагаа гаргах журам	А/219	2017-09-01	
7	Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журам, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам	А/218	2017-09-01	
8	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны данс, бүртгэл, тайлан тэнцлийн тухай журам	А/245	2017-09-29	
9	Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам	А/24	2018-02-13	
<b>Дөрөв. ШШГЕГ-ын даргын тушаал:</b>				
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны шалгалт явуулах журам	А/34	2013-02-06	
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт	А/81	2013-04-24	
4	ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам	А/82	2013-04-24	
5	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам	А/80	2013-04-24	
6	Албаны хэрэгцээнд ашиглах гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглах журам	А/79	2014-04-30	
7	Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх журам	А/181	2017-09-12	
8	ШШГБ-ын алба хаагчийн мэргэшлийн түвшин үнэлэх журам	А/178	2017-09-06	
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам	ШШГЕГ, ЦЕГ-ын даргын А/260 А/242	2017-12-14	
10	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт өөрчлөлт	А/148	2018-08-31	
11	Маягтын жагсаалт, загварт нэмэлт өөрчлөлт оруулах тухай	А/166	2018-09-25	
12	Загвар батлах тухай	А/182	2019-10-14	
13	Гүйцэтгэх баримт бичгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журам	А/196	2019-11-07	

14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам	A/198	2019-11-07	
15	Ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлах тухай	A/227	2019-12-20	
16	Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих журам	A/27	2020-01-27	
17	Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам	A/40	2020-02-28	